



ТАЙЛАН

МОНГОЛ-ЯПОНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН
ХӨГЖЛИЙН ТӨВ

АРВАНДОЛООДУГААР
2025 он



МОНГОЛ-ЯПОНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ



ТАЙЛАН

(2024.01.01-2024.12.31)

2025 он



ТӨВИЙН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв (Цаашид Монгол-Японы төв гэх) нь Монголын зах зээлийн эдийн засагт хувь нэмэр оруулахуйц хүний нөөцийг хөгжүүлэх Монгол, Япон хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (Цаашид ЖАЙКА гэх), Боловсрол, Шинжлэх ухааны яам болон МУИС-ийн хамтарсан төсөл хэлбэрээр 2002 оноос үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Одоо бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх, япон хэлний боловсрол, хамтын ажиллагаа гэсэн үндсэн үйл ажиллагаа явуулдаг. 2012 оноос япон хэлний боловсрол болоод хоёр орны хамтын ажиллагааны хувьд Япон сантай хамтран ажиллаж байна. Мөн өнөөг хүртэл бий болгосон харилцаа холбоогоо үр дүнтэйгээр ашиглан Япон, Монголын бизнесийн гүүр болон ажиллахыг зорьж байна.

2002 он 01 сарын 22	ЖАЙКА болон МУИС-ийн оролцоотойгоор Төслийн нэгдүгээр үе шатыг эхлүүлсэн.
2002 он 03 сарын 14	Япон улсын засгийн газрын буцалтгүй тусламжаар Монгол-Японы Төвийн барилга байгууламж тоног төхөөрөмжийг (нийт 4.43 сая ам доллар) хүлээлгэн өгсөн. (Барилгын талбайн хэмжээ нь 1,520 m ² , нийт талбайн хэмжээ нь 7,000 m ²)
2002 он 06 сарын 21	Албан ёсны нээлтийн үйл ажиллагаанд Японы эрхэм дээд ханхүү Акишинономия, Гүнж Кикогийн хамт оролцсон.
2007 он 01 сарын 22	Төслийн хоёрдугаар үе шат эхэлсэн. (2012 оны 1 сарын 21 хүртэл)
2007 он 07 сарын 16	Төвийн 5 жилийн ойн арга хэмжээнд Японы эрхэм дээд угсаа залгамжлах ханхүү Нарүхито морилон ирсэн.
2009 он 07 сарын 03	Үйлчлүүлэгчдийн тоо давхардсан тоогоор 1,000,000-д хүрсэн.
2012 он 01 сарын 22	ЖАЙКА-ын техникийн хамтын ажиллагаа бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх төслийг эхлүүлсэн
2012 он 04 сарын 01	Япон сангийн хэлний төвийн төслийг эхлүүлсэн.
2012 он 04 сарын 13	Монгол Улсын Их Сургуулийн бүрэлдэхүүн, санхүүгийн бие даасан нэгж болсон.
2012 он 06 сарын 21	Төвийн 10 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулсан.
2015 он 04 сарын 22	Бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх, хамтын ажиллагааны суурийг бэхжүүлэх төслийг эхлүүлсэн.
2016 он 04 сарын 01	Үйлчлүүлэгчдийн тоо давхардсан тоогоор 2,000,000-д хүрсэн.
2017 он 06 сарын 14	Канэко Харүкогийн вааран урлалын “Аз жаргалын цэнхэр хана” бүтээлийн нээлтийн ёслол.
2017 он 06 сарын 21	Төв байгуулагдсаны 15 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулсан.
2020 он 04 сарын 22	Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн хамтын ажиллагааны суурийг бэхжүүлэх, бизнесийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх төсөл
2020 он 10 сарын 19	Үйлчлүүлэгчдийн тоо давхардсан тоогоор 2,500,000-д хүрсэн.
2022 он 06 сарын 21	Төв байгуулагдсаны 20 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулсан.



АЛСЫН ХАРАА

- Монгол улсын ирээдүйн хөгжилд хувь нэмэр оруулахуйц хүний нөөцийг бэлтгэж, Монгол, Япон хоёр улсыг холбогч гүүр болон ажиллах болно.

ЭРХЭМ ЗОРИЛГО

- Үйлчлүүлэгчдийн эрэлтэд нийцсэн үйлчилгээ бий болгон хэрэгжүүлж, Монгол, Япон хоёр улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулна.

УРИА

- Монголын ирээдүйг энд хөгжүүлье!

ҮНЭТ ЗҮЙЛС

- ✓ Монгол дахь япон орчин
- ✓ Япон маягийн үйлчилгээ, японы талаарх мэдээллийг түгээх
- ✓ Японд хуримтлуулсан мэдлэг, мэдээллийг түгээх
- ✓ Чадварлаг Монгол, Япон ажилтнуудын баг
- ✓ МУИС болон бусад байгууллагуудын хамтын ажиллагаа
- ✓ ЖАЙКА, Япон сан ба японы бусад байгууллагуудын хүчтэй дэмжлэг



ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн захирал Ц.Даваадорж.....8

МЭНДЧИЛГЭЭ

Япон улсаас Монгол улсад суугаа
Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Игавахара Масарү.....9

МУИС-ийн ректор, профессор Б.Очирхуяг.....11

ЖАЙКА Монгол дахь Төлөөлөгчийн газрын дарга Мияаги Кэнсүкэ.....12

Япон улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
Япон сан Япон хэлний 1-р хэлтсийн дарга Ёцүя Томоаки.....13

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв Ерөнхий зөвлөх,
ЖАЙКА-ын мэргэжилтэн Изаки Хироши.....15

I. БИЗНЕСИЙН СУРГАЛТЫН ТАСАГ

1. 2024 онд зохион байгуулсан бизнесийн сургалт, семинарын тайлан.....18

Бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх сургалтын хэрэгжилт.....18

1) Танхимын сургалт “Бизнесийн сургалт”18

2) “Ажлын байран дээрх сургалт” болон “Загвар аж ахуйн нэгжийг хөгжүүлэх
хөтөлбөр”21

3) Япон дахь дадлага сургалт.....22

2. Онцлох мэдээ.....37

1) Баруун бүсийн эмэгтэйчүүдийн холбооны нэгдсэн сургалт семинарт оролцлоо
оролцлоо.....37

2) Үндэсний сургагч багш нарт зориулсан “Манлайлал болон баг бүрдүүлэлтээр
бүтээх үнэ цэн” сургалтыг анх удаа зохион байгуулав.....38

3) Эрдэнэт хотод “Хүний нөөцийн менежмент” сургалтыг зохион байгуулав.....39

II. БИЗНЕСИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТАСАГ

1. 2024 онд зохион байгуулсан монгол японы бизнесийн хамтын ажиллагааг
дэмжих үйл ажиллагааны тайлан.....41

2. Онцлох мэдээ.....44

1) Монгол улсын “Үйлдвэрлэлийн технологийг сайжруулах” сэдэвт Япон дахь
дадлага сургалтыг амжилттай зохион байгууллаа.....44



2) Бизнесийн хамтын ажиллагааны тасгийн эхлэл ба одоо.....	46
--	----

III. ЯПОН ХЭЛНИЙ СУРГАЛТЫН ТАСАГ

1. 2024 онд зохион байгуулсан япон хэлний сургалт, семинарын тайлан.....	50
1) Япон хэлний сургалтын талаар.....	50
2) Хамтран зохион байгуулсан үйл ажиллагааны талаар.....	51
2. Онцлох мэдээ.....	70
1) 8-10 насны хүүхдэд зориулсан япон хэлний сургалт.....	70
2) “РРТ-д суурилсан япон хэлний сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах арга зүй” практик сургалт.....	72
3) “Япон хэлний дунд түвшний суралцагчдын уншиж ойлгох чадварыг ахиулах сургалт”.....	73
4) “Япон соёлтой танилцацгаая” тусгай сургалт.....	74
5) “Тусгай ур чадварын тогтолцоо” гэрээт ажлын хүрээнд.....	75
3. Гэрээт сургалт, үйл ажиллагааны хүрээнд.....	75
1) Япон сангийн япон хэлний суурь мэдлэгийн шалгалт (JFT-Basic)-тай хамаарах ажил.....	75
2) Япон хэлний багш нарыг дэмжих үйл ажиллагаа.....	76
3) Япон хэлний сургалтын төв болон Япон улс руу ажилтан илгээгч байгуулагад хандсан судалгаа, зөвлөгөө.....	76
4) Япон хэлний сургалтын төв болон Япон улс руу ажилтан илгээгч байгуулагад хандсан судалгаа, зөвлөгөө.....	76
4. Үйл ажиллагааны талаарх онцлох мэдээ.....	77
1) “2024 оны Нийгата мужийн нэрэмжит япон хэлний уран илтгэлийн тэмцээн”.....	77
2) “Монгол дахь JDS хөтөлбөрийн оюутнуудад зориулсан япон хэлний анхан шатны бэлтгэл сургалт”.....	77
3) “Киотогийн их сургуульд элсэн орохын өмнөх япон хэлний бэлтгэл сургалт-2024”	78
4) “Япон хэлтэй аяллын хөтөч-тайлбарлагчдад зориулсан ахисан түвшний сургалт”	78
5. Суралцагчдын дуу хоолой.....	80

IV. НОМЫН САН, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТАСАГ

1. 2024 оны үйл ажиллагааны ерөнхий тайлан.....	90
1) Номын сангийн үйл ажиллагаа.....	90
2) Япон киноны өдөр.....	91



3) Нээлттэй семинар.....	91
4) Японд суралцах мэдээллийн яармаг-2024.....	91
5) Гэрээгээр гүйцэтгэх ажил.....	92
6) Арван хурууны бичээчийн сургалт.....	92
2. Онцлох мэдээ.....	96
1) “Хаврын мэдээллийн яармаг”-ийг анх удаа зохион байгууллаа.....	96
2) “Японд суралцах тухай мэдээллийн яармаг -2024” 15 дахь удаагаа амжилттай зохион байгуулагдлаа.....	97
3) “Тэртээ оршихуйн юмс” керамик урлагын үзэсгэлэн.....	100
4) 84-р нээлттэй семинар: “Японы анимейшний салбарын хөгжлийн түүх.....	101
5) “Япон соёл судлаач, эрдэм шинжилгээний ажилтанд зориулсан мэргэжлийн япон хэлний 2 сарын сургалт”-д амжилттай оролцлоо.....	105
6) Анимэгийн соёлын танилцуулах өдөрлөг.....	105
 V. ЕРӨНХИЙ УДИРДЛАГЫН ТАСАГ	
1. 2024 оны үйл ажиллагааны ерөнхий тайлан.....	107
2. Онцлох мэдээ.....	110
1) Баталгаат орчуулгын үйлчилгээгээ эхлүүллээ.....	110
2) Анхан шатны монгол хэлний сургалт.....	110
 VI. БАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	
1. 2024 оны багуудын үйл ажиллагааны тайлан.....	112
1) Маркетингийн баг.....	112
2) 5S Кайзен баг.....	113
3) Эрүүл мэнд, спортын баг.....	114



ӨМНӨХ ҮГ



2024 он бидний ажлын өөдлөн дэвших нэгэн жил болж өнгөрлөө.

Жилийн ажлаа нэгтгэн тайлагнах нь бидний уламжлал байдаг. 2024 онд ч амжилтын буухиагаа амжилттай үргэлжлүүлж, төлөвлөсөн ажлаа давуулан биелүүлснээ тайлагнахад урамтай байна. 2024 онд БИД 42 төрлийн 294 ажил төлөвлөснөөс 9 ажил тасарч, 10 ажил шинээр нэмж хийлээ. Ингэснээр ажлын гүйцэтгэл 100.3%-д хүрсэн.

Төвийн бүтэц зохион байгуулалт өөрчлөгдөөгүй, үндсэн ажилтан 31, гэрээт ажилтан 2, цагийн ажилтан 12, цагийн багш 5, үндэсний сургагч багш 8, нийтдээ 63 хүн 2024 онд ажилласан байна. Төвийн нийт ажиллагсдын дундаж цалин 2.2 сая төгрөгт хүрч, өмнөх жилээс 8%-иар өсчээ. Монгол улсын дундаж цалингийн түвшинд байгаа ч бодит орлого өмнөх түвшинд хадгалагдаж байгаа юм.

Япон мэргэжилтэн 5 хүн урт хугацаагаар томилогдон ажиллаж байна.

2024 оны төлөвлөгөөт орлогыг 6.4%-иар давуулж, зарлагаа 7.8%-иар хэмнэж чадлаа. Япон улсын ЖАЙКА байгууллага болон Япон сангийн дэмжлэг урьдын адил үргэлжилж байна. Жилийн нийт төсвийн 21% хувийг Япон талын дэмжлэгээр санхүүжүүлсэн. 2024 онд, тогтмол зардал гэгдэх төвийн дулаан, цахилгаан, усны төлбөрийг Боловсролын Яамны төсвөөс санхүүжүүлсэн байна. Төвийн жилийн төсвийн 3%-тай тэнцэх 49.1 сая төгрөгийн санхүүжилтийг БШУЯ-наас олгосон.

2024 оны дэлгэрэнгүй тайланг энэ товхимолоос танилцах боломжтой. Энэ жилийн тайланг өмнө жилийн нэгэн адил цахим хэлбэрээр гаргаж байна.

Бидний үйл ажиллагааг ямагт дэмжиж, тусалж байдаг хамтран ажиллагч Японы болон Монголын бүх байгууллага, хувь хүмүүст халуун талархлаа дахин дахин илэрхийлье. Та бүхний дэмжлэг, туслалцаа, хамтын ажиллагаа байгаа учраас манай төвийн үйл ажиллагаа үргэлж урагш ахиж, амжилт дүүрэн байдаг.

Манай хамт олон ч цаашид ихээр хичээн, өөрсдийн чадвар, мэдлэгээ бүрэн дайчлан ажиллах болно. Та бүхний дэмжлэг, туслалцаа, хамтын ажиллагааг амжилттай болгон, төвийнхөө нэр хүндийг өндөрт өргөн явахаа амлаж байна.

Монголын ирээдүйг гэрэлтэй, гэгээлэг болгохын төлөө МЯТ-ийн хамт олон ажил үүргийнхээ хүрээнд бүхнийг хийх болно. Бүх хүмүүст сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Баярлалаа.

*Монгол-Японы Хүний Нөөцийн хөгжлийн төвийн
Захирал Ц.Даваадорж*



МЭНДЧИЛГЭЭ



2024 он бол хоёр орны иргэд харилцан зорчсон болон харилцаа идэвхтэй өрнөсөн жил байлаа. Япон Улсын Засгийн газрыг төлөөлөн хоёр орны холбогдох хүмүүсийн өнөөг хүртэлх тал бүрийн анхаарал халамж, дэмжлэг туслалцаанд гүн талархал илэрхийлье.

Миний бие 2023 оны 12 дугаар сард Япон улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар томилогдон ирснээс хойш жил гаруй хугацаа өнгөрч байна. 80-аад оны сүүлээр Монголд анх ирж байсан бөгөөд түүнээс хойш хэд хэдэн удаа томилолтоор ирж байсан. Иймд Монгол Улс бол миний хамгийн дуртай орны нэг байсан ч энэ удаад ч ийнхүү удаан хугацаанд амьдрахаар ирсэн маань анхных билээ. Энэ 1 жилийн хугацаанд тэсгим хүйтэн, хаврын хавсаргатай өдрүүдийг өнгөрүүлж, өдөр уртсан, тал хээр гэнэтхэн ногоон өнгөөр хучигдах Монголын эрс тэс уур амьсгалыг энд амьдарч буй та бүхний хамт мэдэрснээр Монгол ажиллаж байгаа маань аз завшаан гэх мэдрэмжийг төрүүлж байна.

Хоёр орны харилцаа улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, спорт зэрэг олон салбарт тууштай урагшлан хөгжиж байна. 2022 онд зарласан “Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай стратегийн түншлэл”-д Япон, Монголын харилцааг цаашид улам бэхжүүлэхийн тулд улс төр, аюулгүй байдал, эдийн засаг зэрэг чиглэлд хамтран ажиллахаас гадна хоёр орны бүхий л салбарт харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэхийн үндэс суурь нь “Хүн” хэмээн санал нэгдэж, хүний нөөцийг хөгжүүлэх хамтын ажиллагааг үргэлжүүлнэ дурдсан байдаг.

Япон төв нь байгуулагдсанаас хойш бизнесийн болон Япон хэлний сургалтаар дамжуулан олон хүний нөөц бэлтгэсэн ба цаашид ч Монгол Улс дахь хоёр орны хүний нөөцийн хөгжүүлэх хамтын ажиллагааны гол түшиц болж “Тусгай стратегийн түншлэл”-ийг бодитоор хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулна гэдэгт итгэлтэй байна.

Өнгөрсөн онд Япон, Монголын хооронд Соёлын хэлэлцээр байгуулагдсаны 50 жилийн тэмдэглэлт ой тохиосон. Уг хэлэлцээрийн хүрээнд судлаач, уран бүтээлчид хоорондын солилцоо, соёлын арга хэмжээ зохион байгуулах, харилцан оюутан хүлээн авах тухайд Засгийн газрын хэмжээнд хамтран ажиллахаар тохиролцсон ба хоёр орны хүмүүс хоорондын болон соёлын солилцоо олон түвшинд өрнөж эхэлсэн. Ийнхүү соёлын хэлэлцээр байгуулагдсаны дараа жил буюу 1975 онд Монгол Улсын Их Сургуульд Япон хэл судлалын тэнхим байгуулагдсан ба энэ жил Монгол Улсад Япон хэлний боловсрол олгож эхэлсний 50 жилийн ой тохиож байна. Соёлын арга хэмжээ боловсрол зэрэг, бидний өмнөх үеийн олон хүмүүсийн хоорондын солилцооны буухиаг хойч үедээ уламжлуулахад ч Япон төвийн хувь нэмэр маш чухал юм.

Япон төв нь байгуулагдсанаас хойшхи 20 гаруй жилийн туршлагаа шинэ санаатай хослуулан, хоёр орны харилцаа, бизнесийг хөгжүүлэхэд шаардлагатай төсөл хөтөлбөрүүдийг тууштай хэрэгжүүлдэг билээ. Хоёр орны харилцаа бэхжиж буй энэ үед Япон төвийг үүрэг оролцоо улам чухал болж байна. Япон төвийн цаашдын үйл



ажилагаанд өндөр амжилтыг хүсэж, Япон, Монголыг харилцаа улам цэцэглэн хөгжихийн ерөөл дэвшүүлье.

*Япон Улсаас Монгол Улсад суугаа
Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин Сайд Игавахара Масарү*



МЭНДЧИЛГЭЭ



МУИС-ийн Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв Монгол, Япон хоёр улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, бизнесийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, хүний нөөцийг хөгжүүлэх түшиц газар байж хүний нөөцийн карьерийг дэмжих зорилгоо бүрэн дүүрэн биелүүлж хоёр улсыг холбосон шинэ зам, хамтын ажиллагааны бат бөх холбоосыг бий болгожээ.

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн үйл ажиллагааг тогтмол дэмжин ажилладаг Япон Улсын Элчин сайдын яам, ЖАЙКА, “Япон сан”, Монгол Улсын Боловсролын яам, Сангийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон бусад байгууллага, хүмүүст Монгол Улсын Их Сургуулийн эрдмийн хамт олны өмнөөс гүн талархал илэрхийлье.

Тус төвөөс эрхлэн, Монгол Улсын Их Сургууль хамтран жил бүрийн намар зохион байгуулдаг “Японд суралцах талаарх мэдээллийг яармаг”-ийг 2024 оноос эхлэн намраас гадна 4 дүгээр сард цахимаар зохион байгуулдаг болсон нь Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн үндсэн зорилгыг тодотгосон чухал алхам болсон юм.

2025 оны хавар буюу 4 дүгээр сараас Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн төслийн шинэ үе шат эхэлж буйтай холбогдуулан хоёр орны нийгэм, эдийн засаг, бизнесийн хамтын ажиллагаа хөгжлийн шинэ түвшинд хүрнэ гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлье.

Та бүхэнд ажлын амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

МУИС-ийн ректор, профессор Б.Очирхуяг



МЭНДЧИЛГЭЭ



Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв төслийн 2-р шат эхэлснээс хойш ойролцоогоор 5 жил өнгөрчээ. Энэхүү хугацаанд шинэ төрлийн коронавирусийн тархалт болон дэлхий даяар үүссэн зөрчил маргаан, дэлхий дахины улс төр, эдийн засаг, нийгмийн байдалд томоохон нөлөө үзүүлсэн үйл явдлууд болсон бөгөөд уг төслийн зорилтот хувийн хэвшлийн салбарт ч томоохон өөрчлөлтүүд гарсан билээ. Хэдий тийм ч Япон төвийн хамт олны хичээл зүтгэлийн ачаар олон талт үйл ажиллагаанууд амжилттай хэрэгжиж ирсэнд чин сэтгэлээсээ талархаж байна.

Монгол Улсад 7-р сард шинэ засгийн газар байгуулагдаж, 8-р сард парламентаар батлагдсан 2024-2028 оны шинэ засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд нэг хүнд ногдох ДНБ-ийг 8000-10,000 ам.долларт хүргэх зорилт тавигдсан. Монголын эдийн засгийн цаашдын өсөлт, тогтвортой хөгжлийн хувьд хувийн хэвшлийн хөгжил нь маш чухал ач холбогдолтой юм. Мөн 11-р сард Улаанбаатар хотноо 7 жилийн дараа 11дэх удаагийн Монгол-Японы төр, хувийн хэвшлийн хамтарсан зөвлөгөөн болж өнгөрлөө. Уг зөвлөгөөнөөр Монгол-Японы хувийн хэвшлийн бизнесийн харилцааг нэмэгдүүлэн хөгжүүлэх явдал хүлээгдэж байгаа бөгөөд энэ хүрээнд Япон төвийн үүрэг, хариуцлага улам чухал болон ирж байна.

2025 оны 3-р сард Япон төв нь JICA, Монгол улсын засгийн газар, Монголын худалдаа аж үйлдвэрийн танхим, Японд суралцагчдын холбоо (JUGAMO) зэрэг байгууллагуудтай хамтран азийн хамгийн том хүнсний бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа болох **“FOODEX JAPAN 2025”**-д Монголын павильоныг амжилттай оролцуулахаар төлөвлөж байгаа бөгөөд Монголын хүнсний салбарын 7 компанийг үзэсгэлэнд оролцуулах, худалдааны гэрээ байгуулах, маркетинг болон экспортын үйл ажиллагаанд зориулан техникийн дэмжлэг үзүүлэхээр бэлтгэж байна. Цаашид **FOODEX JAPAN** гэх мэт олон улсын үзэсгэлэнгүүдэд оролцоход дэмжлэг үзүүлэх замаар Монгол, Японы хувийн хэвшил хоорондын бизнесийн харилцаа улам бүр өргөжин тэлнэ гэдэгт найдаж байна.

Монгол-Японы хөгжлийн төв болон ЖАЙКА-ийн хамтын үйл ажиллагааг байнга дэмжиж, хамтран ажилладаг та бүхэнд талархал илэрхийлье. Одоо хэрэгжиж буй төсөл дуусахад 3 сар хүрэхгүй хугацаа үлдсэн хэдий ч Монгол-Японы хөгжлийн төв нь цаашид ч хоёр орны бизнесийн харилцаа болон харилцан ойлголцлын гүүр болон үйл ажиллагаагаа явуулахад ЖАЙКА-ийн зүгээс бүх талаар дэмжиж хамтран ажиллах болно.

*ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын дарга
Мияаги Кэнсүкэ*



МЭНДЧИЛГЭЭ



Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв нь /цаашид Монгол-Японы төв гэх/ 2002 онд үүсэн байгуулагдсанаас хойш Монгол улсын нийгэм эдийн засгийн хөгжил, Монгол-Япон хоёр орны харилцан ойлголцол, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулах олон тооны хүний нөөцийг бэлтгэж ирсэн билээ. Түүнчлэн Монгол улсад япон хэлний боловсролыг түгээн дэлгэрүүлэхийн төлөө хичээнгүйлэн зүтгэсээр ирсэн. Энэхүү мэндчилгээгээр дамжуулан Ц.Даваадорж захиралтай тус төвийн хамт олонд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Япон сан нь тус төвийн үйл ажиллагааны үндсэн дөрвөн багана болох бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх, япон хэлний боловсролыг түгээн дэлгэрүүлэх, хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх, Монголын хүний нөөцийг дэмжих зорилго бүхий үйл ажиллагаануудаас япон хэлний боловсрол болон харилцаа хамтын ажиллагааны тасагтай хамтран ажилласаар ирсэн билээ.

2002 оноос өнөөг хүртэл Япон сангийн япон хэлний мэргэжилтэн багшийг томилон ажиллуулж, улмаар 2012 оны 4 сараас эхлэн тус төвтэй хамтран “Япон сангийн хэлний төв” төслийн хүрээнд “Япон сангийн япон хэлний сургалт”-ыг зохион явуулсаар байна. Япон сангийн япон хэлний сургалт нь “Япон хэлийг ашиглан юуг хэрхэн чаддаг болох вэ?” буюу “Асуудал шийдвэрлэх чадвар”, харилцагчийнхаа соёлыг ойлгож хүндэтгэх буюу “Бусад орны соёлыг ойлгон, хүндэтгэх чадвар”-ыг хөгжүүлэхийг гол зорилгоо болгосон “Япон сангийн япон хэлний боловсролын стандарт”-д тулгуурлан явагддаг. Мөн энэхүү сургалтад Япон сангаас боловсруулан гаргасан “Марүгото япон хэл ба соёл” сурах бичгийг ашиглан япон хэлний анхан шатнаас дунд шат хүртэлх түвшний сургалтуудыг зохион явуулдаг билээ. Цаашлаад Монгол-Японы төв нь япон хэлний ахисан түвшний суралцагчдад зориулсан сургалт, зуны улиралд хүүхдэд зориулсан япон хэлний сургалт зэрэг япон хэлийг сонирхон суралцаж буй нийт суралцагчдад хүртээмжтэйгээр, тэдний хэрэгцээ шаардлагад нийцүүлж, Монгол дахь япон хэлний боловсролын орчин нөхцөлд тохируулан төрөл бүрийн сургалтуудыг бэлтгэн явуулсаар байна.

Ялангуяа 2024 оны хувьд гаднын эрэлт хэрэгцээнд үндэслэн шинээр "Япон хэлтэй хөтөч-тайлбарлагчийн ахисан түвшний сургалт" болон "JICA-ийн дадлага хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй хүмүүст зориулсан япон хэлний сургалт" зэргийг хэрэгжүүлсэн. Үүнээс гадна сүүлийн жилүүдэд ажлын байран дээрх япон хэлний мэдлэгийн хэрэгцээ ихсэж буйтай холбогдуулан “Бизнесийн япон хэлний сургалт” зэрэг сургалтуудыг зохион байгуулж үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлсээр байна. Мөн, дээрх сургалтуудын япон хэл суралцагчдад зориулсан дэмжлэгээр зогсохгүй Монгол дахь япон хэлний боловсролыг улам бүр хөгжүүлэхийг зорьж, Япон сангаас томилогдон ажиллаж буй япон хэлний мэргэжилтэнтэй хамтран ЕБС-ийн япон хэлний багш нарт зориулсан заах аргын сургалтыг ч гэсэн амжилттай зохион явуулсаар байна. Үүний дээр



2019 оноос хэрэгжиж буй “Тусгай ур чадвартай ажиллах хүч”-ний тогтолцоогоор Япон улсад ажиллаж амьдрах хүсэлтэй иргэдэд зориулан бэлтгэн гаргасан “Иродори: Хэрэглээний япон хэл” сурах бичгийг ашигласан заах аргын сургалтыг амжилттай зохион байгуулж, Монгол дахь япон хэлний багш нарын боловсон хүчнийг бэлтгэхэд хувь нэмрээ оруулж байна. Мөн 2024 оны 9-р сарын 22-ны Япон-Монголын дээд хэмжээний уулзалтаар, Япон сан нь 2025 оноос эхлэн Монголд Nihongo Partners program-ийг хэрэгжүүлэн (NP)-ийг илгээхээр шийдвэрлэсэн бөгөөд цаашид энэхүү ажлын бэлтгэлтэй холбогдуулан Монгол-Японы төв болон холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж амжилттай хэрэгжүүлэхээр бэлтгэж байна. Япон сан нь цаашид ч гэсэн Монгол-Японы төвтэй хамтран үйл ажиллагаагаа өргөжүүлж, олон олон монгол хүмүүст япон хэл соёлтой танилцах, суралцах боломжийг олгохоор хичээн ажиллах болно. Монгол-Японы төв нь цаашид ч япон хэлний боловсрол, япон соёлыг түгээн дэлгэрүүлэх гол байгууллага болж, хоёр улсын гүүр болох хүний нөөцийг улам бүр хөгжүүлэхийн төлөө хичээн ажиллахыг чин сэтгэлээс хүсэн ерөөе.

***Япон улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Япон сан
Япон хэлний 1-р хэлтсийн дарга Ёцүя Томоаки***



МЭНДЧИЛГЭЭ



Өнгөрөгч 2024 он нь одоо хэрэгжиж буй ЖАЙКА-гийн “Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв” төслийн таван жилийн хамтын ажиллагааны сүүлийн жил юм. Төслийн эхэн үед COVID-19 цар тахлын нөлөөгөөр үйл ажиллагааны явц саатах үе байсан хэдий ч, хожим нөхцөл байдал сайжирч, төлөвлөгөөнийхөө дагуу амжилттай хэрэгжиж байна. Нөхцөл байдал сайжирснаар төслийн зорилго болон шалгуур үзүүлэлтүүдээ бүрэн биелүүлэх төлөвтэй байна.

2024 оны 6-р сард Монголд улсын их хурлын сонгууль болж, улс төрийн хүрээнд шинэ өөрчлөлтүүд гарсан. Нөгөөтэйгүүр, Монголын нийгэм, эдийн засгийн байдалд тогтвортой ахиц гарсаар, энэ хөгжил дэвшил нь анхаарал татахуйц байна. Эдгээр өөрчлөлтөд нийцүүлэн төв ч мөн адил үйл ажиллагааны тогтолцоогоо бэхжүүлэхийн тулд, бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц болон санхүүгийн чиглэлээр зохих сайжруулалтуудыг хийсээр ирлээ. Улмаар төвийн бие даасан байдлыг дэмжих, үйл ажиллагааны чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор бүх ажилтнуудын оролцоотой 2025-2029 оны стратегийн төлөвлөгөөг боловсруулав.

ЖАЙКА төслийн хүрээнд өнгөрсөн таван жилийн хугацаанд бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх, бизнесийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, Монгол хүний нөөцийн карьерын дэмжлэг, мөн тус төвийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр ажиллаж ирсэн. Тухайлбал, үндэсний сургагч багш нарыг бэлтгэх, сургалты орлогыг нэмэгдүүлэх, тогтворжуулахад онцгойлон анхаарч ажилласан бөгөөд үүнээс гадна, “Япон явахын өмнөх сургалт” зэрэг шинэ үйл ажиллагааг эхлүүлсэн. Түүнчлэн Японы их сургуульд суралцаж байсан хоёр ажилтан доктор болон магистрын зэргээ хамгаалж, 10-р сараас үргэлжлүүлэн ажиллаж эхэлсэн. Ийнхүү үйл ажиллагааг төрөлжүүлж, ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх замаар төвийн чадавхыг бэхжүүлэхэд анхааран ажиллаж байна.

Үүний зэрэгцээ “Япон төв 2.0 төлөвлөгөө”-ний хүрээнд Япон болон Монголын салбар бүрийн байгууллагууд (засгийн газар, орон нутгийн захиргаа, их дээд сургууль, аж ахуйн нэгж гэх мэт)-ын хамтын ажиллагааны платформ болж буй үүргээ хадгалан бэхжүүлэхэд анхаарч ажиллаж байна. Мөн Японы их сургуульд элсэн суралцах болон Япон компанид ажиллах, хоёр орны бизнесийг холбох зэрэг чиглэлээр өдөр тутам хичээнгүйлэн ажиллаж байна. Үүнтэй холбоотойгоор Япон дахь ЖАЙКА-ийн байгууллагууд, төв азийн бусад япон төвүүдтэй хамтын ажиллагаагаа өргөжүүлсээр байна.

Өмнө дурдсанчлан, 2025 оны 4-р сард төслийн энэ үе шат дуусгавар болох хэдий ч дараагийн шинэ ЖАЙКА төсөл эхэлж, хамтын ажиллагаагаа таван жилийн хугацаатай үргэлжлүүлэхээр төлөвлөж байна. Энэ хүрээнд гадаадын хөрөнгө оруулалт, гараанй



бизнес зэрэг шинэ чиглэлүүд нэмэгдэх юм. Ийнхүү Монгол-Японы Хүний Нөөцийн Хөгжлийн Төв шинэ шатанд шилжиж байгаа бөгөөд цаашид ч та бүхний итгэлийг даасан, хүлээлтэд нийцсэн төв байхын төлөө чармайн ажиллах болно.

*Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв Ерөнхий зөвлөх
(ЖАЙКА-ийн мэргэжилтэн) Изаки Хироши*





I. 2024 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН БИЗНЕСИЙН СУРГАЛТ, СЕМИНАРЫН ТАЙЛАН

Бизнесийн сургалтын тасаг нь бизнесийн төрөл бүрийн сургалт, семинар, зөвлөгөөг Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-ын дэмжлэгтэйгээр Монголын бизнес эрхлэгчдийг хөгжүүлэх зорилгоор зохион байгуулж байна.

Бизнесийн үндсэн сургалтыг Удирдлагын ангид 6 сэдвээр, Менежерийн ангид 4 сэдвээр тус тус 2 удаа явуулж нийт 20 удаа, бизнесийн суурь мэдлэгийн сургалтыг Улаанбаатар хотод 10 сэдвээр тус тус 1 удаа, Эрдэнэт хотод 1 удаа, ахисан түвшний сургалтыг Улаанбаатар хотод 12 сэдвээр тус бүр 1 удаа, ажлын байран дээрх сургалтыг 35 компани дээр 40 удаа амжилттай зохион байгууллаа. Мөн Завхан аймагт зохион байгуулагдсан Баруун бүсийнн эмэгтэйчүүдийн чуулга уулзалтад тус төвийн сургагч багш нар оролцож илтгэл тавилаа. Түүнчлэн үндэсний сургагч багш нарт зориулсан заах аргын сургалтыг зохион байгуулсан нь энэ оны нэг онцлог сургалт байлаа.

2024 оны нийт сургалтад 3,024 хүн хамрагдсан байна. Монгол-Японы төвийн бизнесийн сургалтуудыг арвин туршлагатай япон, монгол багш нар удирдан явуулж, бизнест бодитоор тус нэмэр болохуйц мэдлэг олгодгоороо давуу талтай. Суралцагчдын 95-ээс дээш хувь нь сургалтыг өндрөөр үнэлэн, сургалтаас сурсан, мэдсэнээ ажлын байран дээрээ хэрэгжүүлж байна.

~ Бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх сургалтын хэрэгжилт ~

1) Танхимын сургалт “Бизнесийн сургалт”

1. Бизнесийн сургалтын тасгийн **үндсэн сургалт** болох “Жижиг, дунд аж ахуйн нэгжийн менежментийг сайжруулах оношилгоо зааварчилгаа, шинжилгээ” сэдэвт бизнесийн практик сургалтыг суралцагчдын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн жилд хоёр удаа (намар, өвлийн элсэлт) зохион байгуулдаг. Тус сургалтын зорилго нь зах зээлийн эдийн засгийн хөгжилд хувь нэмэр болохуйц хүний нөөцийг хөгжүүлж, Монголын аж ахуйн нэгжийг хөгжүүлэх, цаашлаад Монгол улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулахад оршино.

Бизнесийн үндсэн сургалтын суралцагчдыг удирдлагын болон менежерийн гэсэн хоёр ангид элсүүлэн, стратегийн менежмент, маркетинг, санхүүгийн удирдлага, хүний нөөцийн менежмент гэсэн менежментийн үндсэн 4 сэдвээр зохион байгуулдаг бөгөөд



удирдлагын ангид удиртгал болгож “Япон маягийн менежмент”, “Комплаенс” сэдэвт хоёр сургалтыг нэмэлтээр орж байна.



Зураг 1. Бизнесийн үндсэн сургалтын
Удирдлагын анги Стратегийн менежмент
сургалтын явцаас



Зураг 2. Бизнесийн үндсэн сургалтын Менежерийн ангийн
хамт олон

Энэ жил бизнесийн үндсэн сургалтыг хавар, намар 2 удаа танхимаар амжилттай зохион байгуулж, 4 ангид нийт 130 компани, аж ахуйн нэгжийн нийт 138 удирдах ажилтан, менежер суралцаж төгссөн байна.

Өмнөх жилүүдийн адил онол, практик хосолсон хэлбэрээр явагдсан ба суралцагчид тус тусын компанийн жишээ болон тулгамдаж буй асуудлаар санал бодлоо чөлөөтэй солилцож, зөвхөн мэргэжилтэн багшаас суралцах төдийгүй харилцан суралцах нөхцөл бүрдсэн сургалт болж өндөрлөлөө.

Мөн энэ хичээлийн жилийн Менежерийн ангийн 2 удаагийн сургалтын “Стратегийн менежмент”, “Хүний нөөцийн менежмент” болон “Санхүүгийн удирдлага” хичээлийг үндэсний сургагч багш хариуцан удирдан явуулсан нь уг сургалтын нэгэн онцлог байлаа. Үндэсний сургагч багш буюу Монгол багш нар сургалтыг удирдаж орохын нэгэн давуу тал нь сургалт орчуулгагүй байдгаараа ажлын талбарт байнга сорилттой тулгарч байдаг менежерүүдэд зориулан олон талын агуулгыг багтаах боломжтой болж байгаа юм. Түүнчлэн Менежерийн ангид нэг компаниас 3-4 хүн хамрагдах тохиолдол нэмэгдсэн бөгөөд удирдлага, дунд шатны албан тушаалтнууд нэг ойлголттой болсноор тухайн компанийн өсөлт хөгжилд илүү хувь нэмэр оруулдаг давуу талтай билээ.

Монгол-Японы төв нь үндсэн сургалтаас гадна суралцагчдын хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн танхимаар ахисан түвшний болон суурь мэдлэгийн сургалтыг зохион байгуулдаг. Мөн танхимын бус сургалт болох ажлын байран дээрх сургалт болон загвар аж ахуйн нэгжийг хөгжүүлэх хөтөлбөрийн дагуу төрөл бүрийн сургалтуудыг зохион байгуулдаг.



2. Ахисан түвшний сургалтыг “Эксэлээр бизнесийн шинжилгээ хийх нь”, “Бизнес төлөвлөгөө”-2 удаа, “KPI ба чадамжийн удирдлага”, “Датад суурилсан маркетинг”-2 удаа, “Хүний нөөцийн менежмент”, “Менежментийн симуляци”, “Дэлгүүрийн менежмент”, “Global Value Chain”, “Үйлдвэрлэлийн удирдлага”, “Маркетинг” сэдэв болон шинээр “Манлайлал” сэдэвт сургалтыг танхимаар зохион байгуулж, нийт 359 хүн хамрагдсан байна. “Дэлгүүрийн менежмент” сургалтыг анх удаа тус төвийн Үндэсний сургагч багш орсноороо онцлог байлаа. Мөн сургагч багш нарт зориулсан “Манлайлал болон баг бүрдүүлэлт”-ээр бүтээх үнэ цэн” сэдэвт сургалтад МЯТ-ийн үндэсний сургагч багш нар болон МУИС, ХААИС-ийн багш нар хамрагдаж, суралцагчдаас өндөр үнэлгээ авсан юм.



Зураг 3. Эксэлээр бизнесийн шинжилгээ хийх нь ахисан түвшний сургалтын явцаас



Зураг 4. “KPI ба Чадамжийн удирдлага” сэдэвт ахисан түвшний сургалтын явц

3. Бизнесийн суурь мэдлэгийн сургалтыг 2016 оноос эхлэн зохион байгуулж байна. 2017 оноос эхлэн бямба гарагт зохион байгуулдаг болсноор илүү олон компанийн ажилтнууд амралтын нэг өдрөө менежментэд суралцан үр өгөөжтэй өнгөрөөх боломжийг бүрдүүлж өгсөн юм.

Энэ жилийн хувьд суурь мэдлэгийн сургалтуудын ойлголт, үр дүнг нэмэгдүүлэхийг зорьж доорх сэдвүүдээр бүрэн танхимаар зохион байгуулсан юм. Үүнд “Маркетинг, “Хүний нөөцийн менежмент”, “Дэлгүүрийн менежмент”, “5S хөдөлгөөн”, “Санхүүгийн удирдлага”, “Үйлдвэрлэлийн удирдлага”, “Төслийн менежмент”, “Стратегийн менежмент”, “Япон маягийн менежментийг монгол удирдахуйн ухаантай хослуулах нь” болон шинээр “Удирдлагын тогтолцоо ба засаглал” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.



Мөн анх удаа хөдөө орон нутагт буюу Эрдэнэт хотод “Хүний нөөцийн менежмент” суурь мэдлэгийн сургалтыг 2 өдөр зохион байгуулсан онцлогтой жил байлаа.



Зураг 5. “Хүний нөөцийн удирдлага” сэдэвт бизнесийн суурь мэдлэгийн сургалт



Зураг 6. “5S хөдөлгөөн” сэдэвт бизнесийн суурь мэдлэгийн сургалт

4. “Ажлын байран дээрх сургалт” болон “Загвар аж ахуйн нэгжийг хөгжүүлэх хөтөлбөр”

Монголын компаниудад бизнесийн орчны өөрчлөлт, өрсөлдөөн нэмэгдэж байгаатай уялдан зөвхөн удирдах албан тушаалтнаа хөгжүүлээд зогсохгүй байгууллагын стратегид үндэслэн компанийг бүх талаар нь бэхжүүлэх, нийт ажилтнуудын мэдлэг, ур чадварыг ахиулахыг чухалчилж байна. Иймээс байгууллагын удирдах албан тушаалтныг сонгон, гаднын сургалтад хамруулахын зэрэгцээ компани дотроо нэг ойлголттой болохыг зорилгоо болгон олон төрлийн сургалтыг идэвхтэй зохион байгуулдаг болжээ.



Зураг 7. Энотека Плас ХХК “Маркетинг” сэдэвт сургалтын үеэр

Энэ эрэлт хэрэгцээнд нийцүүлэн тус төв нь аж ахуйн нэгжүүдийн менежментийн үр дүн, бүтээмжийг сайжруулах, хүний нөөцийн менежмент болон сургалт хөгжлийн системийг бий болгох зорилгоор ажлын байран дээрх сургалт, загвар аж ахуйн нэгжийг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж монгол компаниудын оновчтой удирдлага, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд түлхүү анхааран ажиллаж байна.



Тус төв нь ЖАЙКА-ийн мэргэжилтэн болон үндэсний сургагч багш нар байгууллагын хүсэлтийн дагуу, компанид тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх зорилготойгоор ажлын байран дээрх сургалтыг зохион байгуулж ирсэн билээ. 2024 онд давхардсан тоогоор 35 компанид 40 удаа сургалт орж, нийт 1235 хүн хамрагдаж, нийт 200 гаруй цагийн сургалтыг зохион байгуулсан байна. 2024 оны хувьд Хүнс Комплекс ХХК-ийн удирдлагын багийнханд стратегийн төлөвлөгөө боловсруулах нийт 16 цагийн консалтингийн зөвлөгөөг тус төвийн үндэсний сургагч багш Н.Батдэлгэр өгсөн юм. Түүнчлэн Завхан аймгийн эмэгтэйчүүдийн холбооны хүсэлтийн дагуу баруун бүсийн эмэгтэйчүүдийн чуулга уулзалтад оролцож буй 500 эмэгтэйд тус төвийн



Зураг 8. БӨТА ХХК “Дэлгүүрийн менежмент” сургалтын үеэр

Үндэсний сургагч багш Д.Дашмаа “Хүний нөөцийн менежмент”, Н.Батдэлгэр багш “Стратегийн менежмент” сэдвээр лекц орсон нь энэ оны онцлох үйл явдал байлаа.

Энэ оны “Загвар аж ахуйн нэгжийг хөгжүүлэх хөтөлбөр”-т Premium Palace ХХК, Caffè bene Mongolia ХХК, Top donj ХХК гэсэн нийт 3 компанид тус тусын хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалт, зөвлөгөөг Япон мэргэжилтэн болон Монгол багш нар шат дараатайгаар зохион байгууллаа.



Зураг 9. Каппе Бэнэ ХХК дахь “Хүний нөөцийн менежмент” сургалтын явц

Тус хөтөлбөрт хамрагдаж буй компаниудад нийт компанийн түвшний стратеги тодорхойлох, түүнтэй уялдсан нэгжийн стратеги болон хүний нөөц хөгжүүлэлт, ялангуяа компанийн гол цөм болох дунд түвшний удирдах ажилтны сургалт, хөгжүүлэлт хэмээх агуулгаар голчлон сургалт, зөвлөгөө зохион байгууллаа.

ЯПОН ДАХЬ ДАДЛАГА СУРГАЛТ

2024 оны 10 сард Японы Китакуёшү хотод дадлага сургалтыг зохион байгуулж, бизнесийн үндсэн сургалтын 15 төгсөгч, загвар аж ахуйн нэгжийн менежментийг сайжруулах хөтөлбөрийн төгсөгч 3 компанийн төлөөлөл, үндэсний сургагч 2 багш, Монгол-Японы төвийн 2 мэргэжилтэн нийт 22 хүн хамрагдлаа.



Энэхүү дадлага сургалтад бизнесийн үндсэн сургалтаар суралцсан агуулгыг япон компаниуд хэрхэн хэрэгжүүлж байгаа бодит байдалтай танилцах, япон маягийн менежментийн үндэс болох кайзэнг хэрэгжүүлснээр ямар үр дүнд хүрч болохыг таниулах зорилгоор 2003 оноос өдийг хүртэл зохион байгуулж ирсэн.

Бизнес эрхлэгчдэд Япон компаниудын бодит байдалтай биечлэн танилцаж, бид ямар түвшнийг зорих ёстой вэ гэдэг загвар жишгийг нүдээр харж мэдрэн, туршлагаас нь суралцсанаар компаниудын үр ашигтай зохион байгуулалт шийдвэр гаргалтад нөлөөлж,



Зураг 10. Нагасакигийн өргөн нэвтрүүлгийн телевизийн шууд нэвтрүүлгийн студид

улмаар энэ нь бизнес сургалтын үр дүн жинхэнэ утгаар хэрэгжиж, Монголын жижиг дунд бизнес цэцэглэн хөгжихөд дорвитой хувь нэмэр болно гэж үзэж байгаа юм.

Энэ удаагийн дадлага сургалтын удирдагч багшаар Кансай их сургуулийн Гото Кэнта профессор ажилласан бөгөөд онолын түвшинд тайлбарлан, зааж өгч байсан нь,

компанид зочлон нүдээр үзэж танилцсан зүйлсээ онолын түвшинд ойлгосон маш ашиг тустай сургалт болсон юм. SunAqua TOTO, Нагасакигийн өргөн нэвтрүүлгийн телевиз, Китаюүшү хотын Эко хотын төв зэрэг 12 байгууллагаар айлчиллаа. Мөн тус сургалтад Монгол-Японы төвийн үндэсний сургагч багш нарыг чадавхжуулах болон туршлага солилцох зорилготойгоор 2 багш хамрагдсан бөгөөд багш нарын зүгээс компаниудын айлчлалын дараа дүгнэлт хийж, багш суралцагчид хоорондоо туршлага солилцсон үр дүнтэй сургалт болж өндөрлөлөө.



БИЗНЕСИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТООН ҮЗҮҮЛЭЛТ

График 1. 2002-2024 оны бизнесийн сургалт, үйл ажиллагааны нийт оролцогчдын тоо

2002-2024 оны байдлаар нийт: 39,701 хүн





График 2. 2018-2024 оны бизнесийн сургалтын чанарын үзүүлэлт





Хүснэгт 1: Үндсэн сургалт Удирдлагын анги 24 дахь элсэлт

№	Хичээлийн нэр	Хугацаа	Орол- цогч	Агуулга	Багшийн нэр	Хүний тоо
1	Япон маягийн менежмент	2024.02.26- 27	Жижиг дунд аж ахуйн нэгжийн удирдах албан тушаалтан	- Бизнесийн орчны өөрчлөлт -Тодорхойгүй (VUCA) цаг үе -Тогтвортой хөгжлийн зорилт(SDG)-ын дэлхий дахин дахь оролдлого - Япон менежментийн онцлог -Компанийн удирдлагын үүрэг хариуцлага, Бизнесийн философи -Хэрэглэгчээ дээдлэх зарчим, Байгууллагын соёл ба манлайлал -Бизнесийн стратеги Хүний нөөцийн хөгжил	Дэгүчи Саторү	41
2	Комплаенс	2024.02.29- 03.01		- Яагаад компанийн засаглал чухал вэ? - Комплаенс ба Компанийн засаглалын сүүлийн үеийн чиг хандлага - Компанийн засаглалыг сайжруулах арга зам	Фүжимото Казүхиса	
3	Стратегийн менежмент	2024.04.08- 13		- Компанийн дээд түвшний зорилт ба бизнесийн орчин (SWOT), компанийн тогтвортой хөгжлийн хүчин зүйл - BSC-ын байр суурь тус бүрээр SWOT шинжилгээнд тулгуурласан стратегийн менежмент, бизнес домэйн, STP, PLC, PPM - Стратегийн менежменттэй уялдсан бизнесийн стратеги - Стратегийн менежмент ба KPI-д суурилсан компанийн гүйцэтгэлийн удирдлага - Жижиг дунд бизнесийн стратеги менежментийн жишээ	Кавагүчи Шиничиро	
4	Хүний нөөцийн удирдлага	2024.04.08- 13		- Хүний нөөцийн талаарх асуудлуудыг ойлгох нь -Хүний нөөцийн асуудлууд -Төлөвлөгөөт эдийн засаг ба зах зээлийн эдийн засаг дахь хүний нөөцийн удирдлага - Менежментийн стратеги ба хүний нөөцийн стратеги -Байгууллагын чадавхид шинжилгээ хийх нь - Гарах хаалганы стратеги -Ажлаас гаралт болон тогтвор суурьшил - Хүний нөөцийн зураглалыг тодорхой болгох, байгууллагын бүтцийн загварчлал - Сонгон шалгаруулалт -Сонгон шалгаруулалтын стратеги -Ажлын зар - Ур чадвар хөгжүүлэлт ба байгууллагын хөгжил - Хүний нөөцийн суурь тогтолцоо	Добаши Хаяато	



5	Маркетинг	2024.04.29-05.04	• Бизнесийн орчны хувьсал өөрчлөлт • Маркетингийн хөгжлийн орчин үеийн чиг хандлага • Байгууллага дахь маркетингийн ач холбогдол • STP стратеги -Маркетингийн стратегийн гол цөм болсон сегментчилэл (Segmentation), Зорилтот зах зээл (Targeting), Үнэ цэнийг байршуулах (Positioning) • Маркетингийн хольц (4P) • Үйлчилгээний маркетинг - Маркетингийн хольц дээр нэмэгдэх 3 хүчин зүйлс: Хүн, биет нотолгоо, процесс • Дижитал маркетинг - Хөгжин шинэчлэгдэж буй интернэтийг ашиглан худалдаа явуулах, мобайл ашигласан шинэ бизнес • Зах зээлийн орчны шинжилгээнд үндэслэн маркетингийн стратеги боловсруулах нь	Огисо Хисаши	
6	Санхүүгийн удирдлага	2024.06.03-08	• Санхүүгийн тайлан болон санхүүгийн шинжилгээ • Санхүүгийн шинжилгээний аргачлалууд • Санхүүгийн тайлангийн алдааг илрүүлэх нь • Удирдлагын нягтлан бодох бүртгэл • Менежментийг сайжруулах санхүүгийн шинжилгээ • Бизнес төлөвлөгөө болон компанийн ерөнхий зураглал	Такэгүчи Ёшихиро	

Хүснэгт 2: Үндсэн сургалт Менежерийн анги 24 дахь элсэлт

№	Хичээлийн нэр	Хугацаа	Оролцогч	Агуулга	Багшийн нэр	Хүний тоо
1	Стратегийн менежмент	2024.03.25-29	Жижиг дунд аж ахуйн нэгжийн удирдах албан тушаалтан	• Компанийн дээд түвшний зорилт ба бизнесийн орчин (SWOT), компанийн тогтвортой хөгжлийн хүчин зүйл • BSC-ын байр суурь тус бүрээр SWOT шинжилгээнд тулгуурласан стратегийн менежмент, бизнес домэйн, STP, PLC, PPM • KPI-д суурилсан гүйцэтгэлийн удирдлагын стратеги • Стратегийн менежменттэй уялдсан бизнесийн стратеги	Н.Батдэлгэр	36
2	Хүний нөөцийн удирдлага	2024.04.22-26		• Ажлаас гаралтын бүтэц • Хүний нөөцийн удирдлагын систем • Хүний нөөцийн хөгжүүлэлт -Шинэ ажилтны чиглүүлэх сургалт -Ур чадвар хөгжүүлэх гол утга учир -Ажлын байран дээрх сургалт -Ажлын байрнаас гадуурх сургалт • Карьер хөгжүүлэлт -Карьер хөгжилд хүргэх албан тушаалын томилгоо • Харилцааны ур чадвар • Зөвшилцлийн үндсэн дээрх шийдвэр гаргалт • Манлайлал • Байгууллагын менежмент -Байгууллагын соёл, шинэчлэл - Хүний нөөцийн үнэлгээ ба эргэх холбоо	Д.Дашмаа	



3	Маркетинг	2024.05.06-05.10	• Бизнесийн орчны хувьсал өөрчлөлт • Маркетингийн хөгжлийн орчин үеийн чиг хандлага • Байгууллагад маркетингийн гүйцэтгэх үүрэг • STP стратеги -Маркетингийн стратегийн гол цөм болсон сегментчилэл (Segmentation), Зорилтот зах зээл (Targeting), Үнэ цэнийг байршуулах (Positioning) • Маркетингийн хольц (4P) • Үйлчилгээний маркетинг - Маркетингийн хольц дээр нэмэгдэх 3 хүчин зүйлс Хүн, биет нотолгоо, процесс • Дижитал маркетинг - Хөгжин шинэчлэгдэж буй интернэтийг ашиглан худалдаа яву улах, мобайл ашигласан шинэ бизнес • Бүтээгдэхүүний конус (Product Cone) -г ашиглан бүтээгдэхүүний төлөвлөгөө боловсруулах нь	Огисо Хисаши	
	Санхүүгийн удирдлага	2024.05.22-26	• Санхүүгийн шийдвэр гаргалт (Санхүүгийн богино хугацааны шийдвэр гаргалт, мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ, Санхүүгийн урт хугацааны шийдвэр гаргалт) • Санхүүгийн шинжилгээ (Санхүүгийн тайлан, түүний бүтэц, уялдаа холбоо, хөрөнгийн эргэц, ашиглалт/ашигт ажиллагаа/төлбөрийн чадвар/бүтээмжийн шинжилгээ) • Зардал, үйлдвэрлэл, ашгийн хамаарлын шинжилгээ (Хугарлын цэг/зорилтот ашиг/хамгаалалтын зааг/Борлуулалтын хольц ба зардал, үйлдвэрлэл, ашгийн хамаарал/зардлын бүтэц ба хөшүүргийн шинжилгээ)	Ц.Баянмөнх	

Хүснэгт 3: Үндсэн сургалт Удирдлагын анги 25 дахь элсэлт

№	Хичээлийн нэр	Хугацаа	Оролцогч	Агуулга	Багшийн нэр	Хүний тоо
1	Япон маягийн менежмент	2024.09.09-10	Аж ахуйн нэгжийн удирдах албан тушаалтан	• Бизнесийн орчны өөрчлөлт -Тодорхойгүй (VUCA) цаг үе -Тогтвортой хөгжлийн зорилт(SDG)-ын дэлхий дахин дахь оролдлого • Япон менежментийн онцлог -Компанийн удирдлагын үүрэг хариуцлага, Бизнесийн философи -Хэрэглэгчээ дээдлэх зарчим, Байгууллагын соёл ба манлайлал -Бизнесийн стратеги Хүний нөөцийн хөгжил	Дэгүчи Саторү	
2	Комплаенс	2024.09.12-13		• Яагаад компанийн засаглал чухал вэ? • COMPLAENS ба Компанийн засаглалын сүүлийн үеийн чиг хандлага • Компанийн засаглалыг сайжруулах арга зам	Фүжимото Казүхиса	



3	Стратегийн менежмент	2024.09.16-21	• Компанийн дээд түвшний зорилт ба бизнесийн орчин (SWOT), компанийн тогтвортой хөгжлийн хүчин зүйл • BSC-ын байр суурь тус бүрээр SWOT шинжилгээнд тулгуурласан стратегийн менежмент, бизнес домэйн, STP, PLC, PPM • Стратегийн менежменттэй уялдсан бизнесийн стратеги • Стратегийн менежмент ба KPI-д суурилсан компанийн гүйцэтгэлийн удирдлага • Жижиг дунд бизнесийн стратеги менежментийн жишээ	Кавагүчи Шиничиро	41
4	Маркетинг	2024.10.07-12	• Маркетингийн тодорхойлолт болон түүний онцлогийн цаг үеийн өөрчлөлт • Дэлхийн бизнесийн орчин дахь динамик өөрчлөлт, бизнесийн боломжууд • Product-Out ба Market-In • Үйлчлүүлэгч төвтэй маркетингийн загвар • Уламжлалт маркетингийн арга • Практикт суурилсан маркетингийн аргачлал- 5 алхамт маркетингийн арга техник (1) • Data-driven marketing • Үр дүнтэй пич материал боловсруулах арга	Хиракава Масаказү	
5	Хүний нөөцийн удирдлага	2024.10.14-19	• Хүний нөөцийн тулгамдаж буй асуудлууд, гарах хаалганы бодлого • Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг, зах зээлийн эдийн засаг • Стратегийн менежмент ба хүний нөөцийн стратеги • Байгууллагын бүтэц • Ажилтны дүр зургийг тодорхой болгох, сонгон шалгаруулалт • Дасан зохицох хөтөлбөр • Ур чадварыг хөгжүүлэх • Байгууллагын соёл • Хүний нөөцийн суурь тогтолцоо, эргэх холбоо	Ямазаки Кёоко	
6	Санхүүгийн удирдлага	2024.11.18-23	• Санхүүгийн тайлан болон санхүүгийн шинжилгээ • Санхүүгийн шинжилгээний аргачлалууд • Санхүүгийн тайлангийн алдааг илрүүлэх нь • Удирдлагын нягтлан бодох бүртгэл • Менежментийг сайжруулах санхүүгийн шинжилгээ • Бизнес төлөвлөгөө болон компанийн ерөнхий зураглал	Такэгүчи Ёшихиро	



Хүснэгт 4: Үндсэн сургалт Менежерийн анги 25 дахь элсэлт

№	Хичээлийн нэр	Хугацаа	Орол- цогч	Агуулга	Багшийн нэр	Хүний тоо
1	Стратегийн менежмент	2024.09.2 3-27	Жижиг дунд аж ахуйн нэгжийн удирдах албан тушаалтан	- Компанийн дээд түвшний зорилт ба бизнесийн орчин (SWOT), компанийн тогтвортой хөгжлийн хүчин зүйл - BSC-ын байр суурь тус бүрээр SWOT шинжилгээнд тулгуурласан стратегийн менежмент, бизнес домэйн, STP, PLC, PPM - KPI-д суурилсан гүйцэтгэлийн удирдлагын стратеги - Стратегийн менежменттэй уялдсан бизнесийн стратеги	Н.Батдэлгэр	36
2	Маркетинг	2024.10.14- 18		- Маркетингийн тодорхойлолт болон түүний онцлогийн цаг үеийн өөрчлөлт - Дэлхийн бизнесийн орчин дахь динамик өөрчлөлт, бизнесийн боломжууд - Product-Out ба Market-In - Үйлчлүүлэгч төвтэй маркетингийн загвар - Уламжлалт маркетингийн арга - Практикт суурилсан маркетингийн аргачлал- 5 алхамт маркетингийн арга техник (1) - Data-driven marketing - Үр дүнтэй пич материал боловсруулах арга	Хиракава Масаказү	
3	Хүний нөөцийн удирдлага	2024.10.2 8-11.01		- Өөрийн компанийн хүний нөөцийн менежментийн тулгамдсан асуудлаа тодорхойлох - Хүний нөөцийн менежментийн өөрчлөлт - Хүний нөөцийн менежмент гэж юу вэ? - Байгууллагын соёл ба хүний нөөцийн менежментийн уялдаа холбоо - Хүний нөөцийн төлөвлөлт, бүрдүүлэлт - Хүний нөөцийн сонгон шалгаруулалт - Хөдөлмөрийн харилцааны үндсэн асуудлууд /хөдөлмөрийн тухай хуулийн гол анхаарах зүйлүүд/ ХАБЭА - Гүйцэтгэлийн менежмент - Цалин хөлс, урамшуулал, нийгмийн халамж - Сургалт хөгжил - Ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэх - Мэдээлэл солилцоог сайжруулах - Ажлаас гаралтын менежмент - Өөрийгөө таних - Манлайлал - Сайжруулах ур чадвар /харилцаа, хандлага,сонсох, бусдын оронд өөрийгөө тавих, EQ, коучинг /	Д.Дашмаа	



4	Санхүүгийн удирдлага	2024.11.18-22	• Санхүүгийн шийдвэр гаргалт (Санхүүгийн богино хугацааны шийдвэр гаргалт, мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ, Санхүүгийн урт хугацааны шийдвэр гаргалт) • Санхүүгийн шинжилгээ (Санхүүгийн тайлан, түүний бүтэц, уялдаа холбоо, хөрөнгийн эргэц, ашиглалт/ашигт ажиллагаа/төлбөрийн чадвар/бүтээмжийн шинжилгээ) • Зардал, үйлдвэрлэл, ашгийн хамаарлын шинжилгээ (Хугарлын цэг/зорилтот ашиг/хамгаалалтын зааг/Борлуулалтын хольц ба зардал, үйлдвэрлэл, ашгийн хамаарал/зардлын бүтэц ба хөшүүргийн шинжилгээ)	Ц.Баянмөнх	
---	----------------------	---------------	--	------------	--

Хүснэгт 5: Суурь мэдлэг

№	Хичээлийн нэр	Хугацаа	Оролцогч	Агуулга	Багшийн нэр	Хүний тоо
1	Маркетинг	2024.01.27	Компанийн шинэ ажилтан, гарааны бизнес эрхлэгчид	Маркетингийн үндсэн ойлголт 2. Маркетинг хэрхэн ажилладаг болохыг ойлгох нь? 3. Нөхцөл байдлын шинжилгээ буюу зах зээлийг тандах нь 4. STP стратеги 5. Маркетингийн үндсэн бодлого буюу 4P	Б.Угтахжаргал	39
2	Хүний нөөцийн удирдлага	2024.02.24		• Хүний нөөцийн менежментийн талаар суурь ойлголт • Хүний нөөцийн менежментийн үндсэн функцууд - төлөвлөлт, - бүрдүүлэлт, - сонгон шалгаруулалт - үнэлгээ - сургалт хөгжил • Ажлын байрны манлайлал, идэвхжүүлэлт	Д.Дашмаа	41
		2024.11.12-13				17
3	Дэлгүүрийн удирдлага	2024.03.23		• Дэлгүүрийн ангилал, төрөл • Дэлгүүр төлөвлөлт - Гадаад орчны төлөвлөлт - Худалдааны талбайн төлөвлөлт • Барааны удирдлага - Мерчиндайзинг - Бараа өрөлт - Барааны хаяглалт • Үйлчилгээ	Ж.Гансүх	46
4	5S хөдөлгөөнийг хэрэгжүүлэх нь	2024.04.06		• 5S-ийг хэрэгжүүлэх нь /Сэири- Сэитон-Сэйсоо-Сэйкэцү-Шицүкэ/ /Үргүй зардлыг арилгах, Чанарын удирдлага, 5S/ • PDCA циклийг хэрэгжүүлэх нь/Төлөвлөх-Хэрэгжүүлэх-Шалгах-Сайжруулах/ • 5 удаа яагаад шинжилгээ • Хоорэнсоо /Мэдээлэх-Холбогдох-Зөвлөлдөх/	Д.Долгормаа	50



5	Санхүүгийн удирдлага	2024.04.27	• Санхүүгийн удирдлагын онцлог, ач холбогдол • Санхүүгийн менежер хүний гаргах гол шийдвэрүүд • Бэлэн мөнгө болон авлагаа удирдлах нь • Хөрөнгө оруулалтын хэрэгцээ, шийдвэр гаргах үе шатууд • Төслийн мөнгөн гүйлгээг тооцох нь • Мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн хэрэглээ • Төслийн үнэлгээний аргууд • Хөрөнгө оруулалтын төслүүдээс ашигтайг сонгох нь	Б.Данаасүрэн	28
6	Үйлдвэрлэлийн удирдлага	2024.05.25	• Тоёотагийн үйлдвэрлэлийн удирдлагын арга барил • Тоёотагийн 7 муда • Стандарт ажлын зааварчилгаа • Кайзэн • Загасны ясан диаграм • Чанарын долоон арга • VSM ба үнэ цэнийн урсгалын зураглал • TPM ба засварын нэгдсэн удирдлага	Н.Батчулуун	42
7	Төслийн менежмент	2024.06.15	• Төслийн тухай үндсэн ойлголт • Төслийн үе шатууд • Төслийн удирдлага арга, техник • Төслийн эрсдэлийн удирдлага	Б.Мөнхцог	21
8	Удирдлагын тогтолцоо ба засаглал	2024.08.27	• Хурдацтай өөрчлөгдөж буй дэлхий ертөнц ба бизнесийн орчин • Компанийн засаглал ба удирдлагын тогтолцоо • ТУЗ, Гүйцэтгэх удирдлага • Компанийн хариуцлага ба бизнесийн ёс зүй	С.Санасэр	20
9	Стратегийн менежмент	2024.09.14	• Стратегийн суурь ойлголт • Стратеги менежмент - Гадаад орчны шинжилгээ - Дотоод орчны шинжилгээ - Компанийн ерөнхий стратеги - Компанийн бизнес загвар - Өрсөлдөөний стратегийг дэмжих үйлдэл	Б.Мөнхцог	18
10	Япон маягийн менежментийг монгол удирдахуйн ухаантай хослуулах нь	2024.10.26	• Менежментийн зорилгын тухай үндсэн ойлголт • Япон маягийн менежментийн онцлог • Үйлдвэрлэлийн пирамид ба 5S-ийн тухай суурь ойлголт • Монгол маягийн менежментийн онцлог • Ашгийг бүтээгч хүнээ сайжруулах нь • Япон маягийн менежментийг хэрэгжүүлэхэд гарсан алдаа, онооны туршлагаас суралцах нь	Ж.Хишигжаргал	23



Хүснэгт 6. Ахисан түвшний сургалт

№	Хичээлийн нэр	Хугацаа	Оролцогч	Агуулга	Багшийн нэр	Хүний тоо
1	Экслээр бизнесийн шинжилгээ хийх нь	2024.01.17-19	Байгууллагын удирдах албан тушаалтан, менежер, нягтлан бодогч	- Санхүүгийн загварчлалын үндсэн техник - Ашгийг таамаглах загвар боловсруулах - Санхүүгийн тайланг ашигласан санхүүгийн загвар - Санхүүгийн загварыг боловсруулах - Хугарлын цэгийн шинжилгээ - Компанийн үнэ цэнийн үнэлгээний аргазүй - Компанийн үнэ цэнийн үнэлгээний загвар боловсруулах	Н.Батдэлгэр	30
2	Бизнес төлөвлөгөө	2024.02.28-03.01	Бизнес эрхлэгчид болон шинээр бизнес эрхлэхээр эзхэж буй хүмүүс	- Бизнес төлөвлөгөөний ач холбогдол ба зорилго - Яагаад бизнес төлөвлөгөө хэрэгтэй вэ? - Бизнес төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг - Бизнесийн тойм агуулга ба алсын хараа - Зах зээл ба өрсөлдөөний шинжилгээ - Хэрэглэгчийн хэрэгцээг тодорхойлох - Ашгийн бүтцийг ойлгох - Санхүүгийн төлөвлөгөө ба төсвийн төсөл	Дэгүчи Саторү	39
3	KPI ба Чадамжийн удирдлага	2024.03.18-22	KPI-ийг хэрэгжүүлж буй байгууллагын удирдах албан тушаалтан, хүний нөөцийн менежер, бизнесийн зөвлөхүүд	- Хүний нөөцийг болон байгууллагыг үр дүнтэй удирдаж, ажиллуулах KPI-ийн удирдлага - Японы компаниудын KPI-ийн удирдлагын жишээ - Менежментийг харагдахуйц болгох арга хэрэгсэл болох KPI-ийн удирдлага - KPI-ийг хэрэгжүүлж буй Монгол компанийн жишээ - KPI болон чадамжийн гүйцэтгэлийн үнэлгээтэй уялдсан цалин, урамшууллын дизайн	Кавагүчи Шиничиро	32
4	Data driven marketing	2024.03.25-29	Компанид байгаа датаг бизнесээ өргөжүүлэх, үр дүнтэйгээр ашиглах маркетингийн аргачлалд суралцахыг хүссэн хүн бүр	- Дижитал шилжилт(DX), түүний хүчин зүйл - Маркетингийн тодорхойлолт, урсгал - Датад суурилсан маркетинг (Data driven marketing), хүчин зүйлс - Цахим худалдааны (E-commerce) үүсэл хөгжил болон хэрэглэгчийн датаг цуглуулах - Вэбсайтын бүтэц/үйлчлүүлэгчдийг татах ур чадвар/хандалтын бүртгэлийн шинжилгээ - Эксл ашиглан бизнес датаг шинжилгээ хийх аргачлал - Конжойнт шинжилгээ, хэрэгжүүлэлт	Фүкүёо Казүхиро	34
5	Хүний нөөцийн удирдлага	2024.04.15-19	Компанийн удирдах түвшний албан тушаалтан хүний нөөцийн менежер	- Стратегийн менежмент ба хүний нөөцийн стратегийн уялдаа - Хүний нөөцийн суурь тогтолцоог бүрдүүлэх нь - Хүний нөөцийн үнэлгээ - Хүний нөөцийн хөгжил - Манлайлал ба байгууллагын хөгжил	Добаши Хаяато	22



6	Дэлгүүрийн удирдлага	2024.05.15-17	Дэлгүүр, үйлчилгээний газрын үйл ажиллагаа эрхлэгч, удирдах албан тушаалтан, менежер зохион байгуулагч	• Бараа өрөлт • Бараа өрөлтийг сайжруулах зөвлөгөө • Хэрэглэгчийн удирдлага • Customer Journey Map • Хүний нөөцийнхөгжил • Шинэ ажилтныг чиглүүлэх сургалт • Борлуулалтын ажилтныг чиглүүлэх сургалт • Дэлгүүрийн даргыг чиглүүлэх сургалт • Борлуулалтыг идэвхжүүлэх • РОР, зар сурталчилгаа	Ж. Гансүх	48
7	Эксэлээр бизнесийн шинжилгээ хийх нь	2024.06.24-27	Байгууллагын удирдах албан тушаалтан, менежер, нягтлан бодогч	• Санхүүгийн загварчлалын үндсэн техник • Ашгийг таамаглах загвар боловсруулах • Санхүүгийн тайланг ашигласан санхүүгийн загвар • Санхүүгийн загварыг боловсруулах • Хугарлын цэгийн шинжилгээ • Компанийн үнэ цэнийн үнэлгээний аргазүй • Компанийн үнэ цэнийн үнэлгээний загвар боловсруулах	Б.Оюундарь	14
8	Global Value Chain	2024.08.19-23	Үйлдвэрийн салбар, цаашид бараа бүтээгдэхүүнээ экспортолохоор зорьж буй бизнес эрхлэгчид, олон улсын эдийн засаг сонирхож буй хүмүүс	• Япон болон Зүүн Азийн үйлдвэржилтийн туршлагаас суралцах нь • Дэлхийн эдийн засгийн ба дэлхийн үнэ цэнийн гинжин хэлхээ • Дэлхийн эдийн засаг доторх Монгол улс • Аж үйлдвэрийн онцлогийг ойлгох нь • Бизнес ба тогтвортой байдал	Гото Кэнта	35
9	Бизнес төлөвлөгөө	2024.09.11-13	Бизнес эрхлэгчид болон шинээр бизнес эрхлэхээр эзэх буй хүмүүс	• Бизнес төлөвлөгөөний ач холбогдол ба зорилго • Яагаад бизнес төлөвлөгөө хэрэгтэй вэ? • Бизнес төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг • Бизнесийн тойм агуулга ба алсын хараа • Зах зээл ба өрсөлдөөний шинжилгээ • Хэрэглэгчийн хэрэгцээг тодорхойлох • Ашгийн бүтцийг ойлгох • Санхүүгийн төлөвлөгөө ба төсвийн төсөл	Дэгүчи Саторү	35



10	Маркетинг	2024.09.30-10.04	Гадны зах зээлд бараа бүтээгдэхүүнээ экспортолохор төлөвлөж буй болон олон улсын үзэсгэлэн яармагт оролцохор төлөвлөж буй компанийн удирдах албан тушаалтан, менежер, үйлдвэрлэгчид, худалдаа аж үйлдвэрийн танхимуудын гадаад зах зээл хариуцсан мэргэжилтнүүд	• FoodExpo • Үзэсгэлэн яармагт оролцохоос эхлээд бүтээгдэхүүн борлуулж эхлэх хүртэлх үйл явц болон үр дүнтэй ажиллах арга • Зорилтот зах зээлийн судалгаа • Зах зээлийн бүтэц, борлуулалтын сувгийн шинжилгээ • Өөрийн бүтээгдэхүүний байршуулалт, бизнес төлөвлөгөө, боломжит түншээ тодорхойлох • Бараа бүтээгдэхүүнээ амжилттай танилцуулах арга • 5 шатлалт маркетингийн арга • Үзэсгэлэн яармагт оролцох, оролцсоны дараа бараа бүтээгдэхүүнээ борлуулах хүртэл шаардлагатай check point	Хиракава Масаказү	38
11	Data driven marketing	2024.11.11-15	Компанид байгаа датаг бизнесээ өргөжүүлэх, амжилттай явуулахад үр дүнтэйгээр ашиглах маркетингийн аргачлал сурахыг хүссэн	• Дижитал шилжилт(DX), түүний хүчин зүйл • Маркетингийн тодорхойлолт, урсгал • Датад суурилсан маркетинг (Data driven marketing), хүчин зүйлс • Цахим худалдааны (E-commerce) үүсэл хөгжил болон хэрэглэгчийн датаг цуглуулах • Вэбсайтын бүтэц/үйлчлүүлэгчдийг татах ур чадвар/хандалтын бүртгэлийн шинжилгээ • Эхсэл ашиглан бизнес датаг шинжилгээ хийх аргачлал • Конжойнт шинжилгээ, хэрэгжүүлэлт	Фүкүёо Казүхиро	31
12	Үйлдвэрлэлийн удирдлага	2024.12.02-06	Үйлдвэрлэлийн салбарт бизнес эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллагын удирдах албан тушаалтан, менежер	• Үйлдвэрлэлийн удирдлагын ерөнхий ойлголт • Чанарын удирдлага • Дамжлагын сайжруулалт • QC-н 7 арга хэрэгсэл /Чанарын удирдлагын/ • Аюулгүй байдал, эрүүл ахуйн менежмент • 5S үйл ажиллагаа хэрэгжилт • Менежментийн ур чадварыг сайжруулах • Хүний нөөцийн сургалт, хөгжил	Такаясү Мицүхарү	34

Хүснэгт 7. Загвар Аж Ахуйн нэгжийг хөгжүүлэх хөтөлбөр

№	Компанийн нэр	Үйл ажиллагааны чиглэл	Хөтөлбөрийн агуулга	Хугацаа
---	---------------	------------------------	---------------------	---------



2024-2025 он	1	Premium Palace ХХК	Зочид буудал, ресторан	- Ажилтнуудын сэтгэл ханамжийг тогтмол үнэлэх замаар сэтгэл ханамжийг тогтоох, сайжруулах - Нийт компанийн түвшний стратеги тодорхойлох	2023.04-2024.06
	2	Caffe Bene Mongolia ХХК	Кафе, хүнс үйлдвэрлэл	- Хүний нөөцийн тогтолцоо сайжруулах, ажилтнуудын сэтгэл ханамжийг тогтмол үнэлэх замаар сэтгэл ханамжийг тогтоох, сайжруулах - Үйлдвэрлэлийн удирдлагын сайжруулалт	2023.11-2024.06
	3	Кашмер Холдинг ХХК	Ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэл, худалдаа	- Стратегийн зорилгоо тодорхойлох, бизнесийн орчны шинжилгээ - SWOT-д суурилсан нийт компанийн түвшний стратеги тодорхойлох, түүнтэй уялдсан CSF, SGKI, KPI тодорхойлох, хэлтэс, баг, хувь хүний KPI-д буулгах	2023.09-2024.06

Хүснэгт 8. Ажлын байран дээрх сургалт

№	Компанийн нэр	Сургалтын нэр	Хугацаа	Багшийн нэр	Оролцогчдын тоо
1	GTN ХХК	Би бид компанийнхаа үнэ цэнтэй ажилтан	2024.01.05	Д.Дашмаа	9
2	МЯК ХХК	Хоо Рэн Соо	2024.1.12	Д.Дашмаа	9
3	Сtimo ХХК	Бизнес төлөвлөгөө	2024.2.29	Дэгүчи Саторү	11
4	Байгалийн чулуун хийц ХХК	Цагийн менежмент	2024.3.4	Д.Дашмаа	23
5	Хаанзаа Сервис ХХК	Цагийн менежмент, Хувь хүний хөгжил	2024.3.11,22	Д.Дашмаа	24
6	Хаан банкны ЖД бизнесийг дэмжих төв	Дэлгүүрийн менежмент	2024.3.15	Ж.Гансүх	16
7	МУИС, олон улсын харилцааны гэнхим	KPI	2024.3.18	Кавагүчи Шиничиро	2.5
8	Моннидер ХХК	Стратегийн менежмент	2024.3.21	Н.Батдэлгэр	8
9	Бумбод ХХК	Стратегийн менежмент	2024.4.6	Н.Батдэлгэр	20
10	Грийн Химистри ХХК	5S хөдөлгөөн	2024.4.14	Д.Долгормаа	25
11	Мөнхийн үсэг ХХК	Хүний нөөцийн менежмент	2024.4.16	Д.Дашмаа	40
12	Завхан аймаг	Хүний нөөцийн менежмент, Стратегийн менежмент	2024.4.19,20	Д.Дашмаа, Н.Батдэлгэр	500
13	Алтан говь ХХК	5S хөдөлгөөн	2024.4.24	Д.Долгормаа	35
14	Азура Пэйнтинг ХХК	Маркетинг	2024.5.6	Огисо Хисаши	9
15	Рэд Рок Холдинг ХХК	Өөрчлөлтийн менежмент	2024.5.14,28	Н.Батдэлгэр	24
16	Моншибасаки ХХК	Хүний нөөцийн менежмент	2024.5.26	Д.Дашмаа	24
17	Өгөөж чихэр боов ХХК	Үйлдвэрлэлийн удирдлага	2024.6.8	Н.Батчулуун	16
18	Говь ХК	5S хөдөлгөөн	2024.6.10	Д.Долгормаа	26
19	Говь ХК	5S хөдөлгөөн	2024.6.10	Д.Долгормаа	26
20	Дүүрэн Фүүд ХХК	Төслийн менежмент	2024.6.12	Б.Мөнхцог	7
21	Бороо Гоулд ХХК	KPI	2024.6.18,20	Н.Батдэлгэр	54
22	Дүүрэн Фүүд ХХК	Стратегийн менежмент	2024.6.21	Н.Батдэлгэр	7
23	Байгалийн чулуун хийц ХХК	Стратегийн менежмент	2024.6.26	Д.Долгормаа	26
24	Инвескор Проперти	5S хөдөлгөөн	2024.8.14	Д.Долгормаа	33
25	Мандал Групп	Байгууллагын соёл	2024.8.14	Ониши Ёшифүми	15
26	Мэргэн Инженеринг Сервис ХХК	Хүний нөөцийн менежмент	2024.8.16	Д.Дашмаа	5
27	Рэд Рок Холдинг ХХК	Цагийн менежмент	2024.9.10	Д.Дашмаа	18
28	Наран групп	Бизнес төлөвлөгөө	2024.9.11	Дэгүчи Саторү	60
29	Гэгээн Далай ХХК	Бизнес төлөвлөгөө	2024.9.11	Дэгүчи Саторү	9



30	Хүнс Комплекс ХХК	Үйлдвэрлэлийн удирдлага	2024.9.25	Н.Батчулуун	16
31	Хүнс Комплекс ХХК	Стратегийн менежмент	2024.10.1,2,3	Н.Батдэлгэр	16
32	Оптимал Эн Макс ХХК	Стратегийн менежмент	2024.10.9,10	Н.Батдэлгэр	14
33	Энотека Плас ХХК	Маркетинг	2024.10.10,11,14,15	Хиракава Масаказү	4
34	Рэд Рок Холдинг ХХК	Стратегийн менежмент	2024.10.15	Н.Батдэлгэр	10
35	БӨТА ХХК-Поларис их дэлгүүр	Дэлгүүрийн менежмент	2024.10.30,31	Ж.Гансүх	20
36	Говийн Оюу хөгжлийг дэмжих сан ГББ	Төслийн менежмент	2024.11.9	Ж.Мөнхцог	3
37	Монос Хүнс ХХК	Үйлдвэрлэлийн удирдлага	2024.12.3	Такаясу Мицүхарү	20
38	И И ЭС ХХК	5S хөдөлгөөн	2024.12.9	Д.Долгормаа	30
39	Дөлгөөн Орхон ХХК	Дэлгүүрийн менежмент	2024.12.12	Ж.Гансүх	7
40	Амгалан Заяа ХХК	5S хөдөлгөөн	2024.12.18	Д.Долгормаа	15
41	Хүнс Комплекс ХХК	Стратеги боловсруулах консалтинг	2024.11.29,12.4,12,14,18,21	Н.Батдэлгэр	10

Хүснэгт 9. Япон дахь дадлага сургалтын суралцагчид

1. Бизнесийн үндсэн сургалт төгсөгчид

№	Нэр	Албан тушаал	Байгууллагын нэр
1	Г.Амаржил	Захирал	Аяа корсет белт ХХК
2	Г.Ариунтөгс	Ерөнхий менежер	Гулга төхөөрөмж ХХК
3	М.Батбаяр	Чанар хариуцсан захирал	Делакс фурнитур ХХК
4	Б.Баяндалай	Гүйцэтгэх захирал	Смарт И Ар Пи Про Экспертс ХХК
5	Б.Баярмаа	Үйлдвэрийн дарга	Мастер фүүдс ХХК
6	Б.Болорцэцэг	Барилгын материалын чанарын менежер	Монголын Алт (МАК) ХХК
7	О.Давааням	Үйл ажиллагаа хариуцсан менежер	Байгалийн чулуун хийц ХХК
8	Б.Дэлгэрэх	Бизнес хөгжил хариуцсан дэд захирал	Лайфэлектроник ХХК
9	А.Ганбат	Гүйцэтгэх захирал	Нойкрафт ХХК
10	Б.Нарангарав	Захирал	Амгаланзаяа ХХК
11	Ц.Пүрэвжаргал	Гүйцэтгэх захирал	Жак Интернэйшнл ХХК
12	Г.Төртөгтөх	Дэд захирал	Зангиа Портал ХХК
13	Д.Түвшинжаргал	Гүйцэтгэх захирал	Ханжинтранс ХХК
14	Д.Өлзийханд	Гүйцэтгэх захирал	Тайван хайрхан ХХК
15	Д.Урангоо	Гүйцэтгэх захирал	Гоо Лайф Лорис ХХК

2. 2021 оны Загвар аж ахуйн нэгж

№	Нэр	Албан тушаал	Байгууллагын нэр
16	Д.Болд-Эрдэнэ	Ахлах супервайзор	Caffe Bene Mongolia ХХК
17	Ц.Цэнгэлбаяр	Үйл ажиллагаа хариуцсан менежер	Кашмер Холдинг ХХК
18	Э.Онон	Ресторан хариуцсан захирал	Премиум Палас ХХК

3. Үндэсний сургагч багш

№	Нэр	Албан тушаал	Байгууллагын нэр
19	Д.Долгормаа	Үндэсний сургагч багш	Моншибасаки ХХК
20	Б.Угтахжаргал	Үндэсний сургагч багш	Монгол Улсын Их Сургууль

4. Монгол-Японы төв

№	Нэр	Албан тушаал	Байгууллагын нэр
21	О.Баярмаа	Бизнесийн сургалтын тасгийн ахлах мэргэжилтэн	Монгол-Японы төв
22	Х.Жаргалмаа	Бизнесийн сургалтын тасгийн мэргэжилтэн	Монгол-Японы төв



II. ОНЦЛОХ МЭДЭЭ

1. Баруун бүсийн эмэгтэйчүүдийн холбооны нэгдсэн сургалт семинарт оролцлоо.

2020 оноос бизнесийн сургалтуудыг цахимаар зохион байгуулж эхэлснээс хойш хөдөө орон нутгаас бизнесийн сургалтад хамрагдах болон хамтрагдахыг хүсэх хүмүүсийн тоо нэмэгдэсээр байгаа билээ. Энэ удаа Завхан аймгийн засаг даргын тамгын газрын хүсэлтээр баруун бүсийн эмэгтэйчүүдийн холбооны нэгдсэн “Харилцан суралцаж, хамтдаа хөгжье” чуулга уулзалтад оролцож, илтгэл тавилаа.

Тухайлбал, тус төвийн ерөнхий менежер Н.Батдэлгэр “Стратегийн менежмент”, “Кластер хөгжил” сэдвээр, үндэсний сургагч багш Д.Дашмаа “Тогтвортой хөгжлийн зорилт”, “Хүний нөөцийн менежментийн суурь ойлголт” сэдвээр чуулгад оролцож буй баруун бүсийн 500 гаруй эмэгтэйчүүдийн төлөөлөлд хандан илтгэл тавьлаа.

Түүний зэрэгцээ Бизнесийн сургалтын тасгийн мэргэжилтэн О.Баярмаа Улиастай хотын ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 700 гаруй сурагчдад зориулан Япон улсад суралцах талаарх мэдээлэл болон карьер төлөвлөлтийн талаар туршлагаасаа хуваалцлаа.

Орон нутагт маш олон бизнесийн боломж, нөөц байдаг. Түүнчлэн орон нутгийн иргэдэд өөрийн гэсэн өвөрмөц арга барил, ноу хау байдаг учраас түүнийг хэрхэн хамтдаа хүчээ нэгтгэн бизнес болгон хөгжүүлэх, тус тусдаа юу хийж чадах, эвлэлдэн



Зураг 11. Д.Дашмаа “Илтгэлийн явц”

Зураг 12. Н.Батдэлгэр “Илтгэлийн явц”

нэгдсэнээрээ юу хийж чадах, улс орныхоо төлөө болон хойч үеийнхээ төлөө тогтвортой хөгжлийн зорилтыг хэрхэн хэрэгжүүлэх талаар 2 өдрийн хугацаанд санал бодлоо солилцон, үнэ цэнтэй цаг хугацааг өнгөрүүлээ гэж бид дүгнэж байна.



2. Үндэсний сургагч багш нарт зориулсан “Манлайлал болон баг бүрдүүлэлтээр бүтээх үнэ цэн” сургалтыг анх удаа зохион байгуулав.

Монгол-Японы төвийн зүгээс анх удаа сургалт удирдан явуулдаг монгол багш нарт буюу үндэсний сургагч багш нарт зориулж сургалтыг практик бөгөөд оролцоотой явуулах аргын сургалтыг 2 өдөр зохион явууллаа. Тус сургалтыг МЯТ-ийн япон мэргэжилтэн багш Ямазаки Кёоко удирдан явууллаа. Ямазаки Кёоко багш нь хувийн хэвшилд болон академик салбарт аль алинд нь олон жилийн турш ажилласан, мөн Монгол улсад сүүлийн 18 жилийн турш жил бүр хүрэлцэн ирж хүний нөөцийн менежментийн чиглэлээр сургалт зөвлөгөө өгч ирсэн туршлагатай багш юм. Уг туршлагадаа үндэслэн тоглоомын арга ашиглан сургалтыг зөвхөн багш нэг талаас зааж, нэг талаас ярих биш, суралцагчдын сонирхлыг татан, сургалтдаа оролцуулж, 2 талын оролцоотойгоор явуулах арга туршлагаасаа хуваалцлаа.

Нийт 6 төрлийн багийн ажил, тоглоом ашиглан, зааж буй агуулгаа илүү ойлгомжтой хүргэх, суралцагчдыг хамруулах төдийгүй, тухайн тоглоомыг тоглоод өнгөрөх биш хэрхэн суралцагчдад хичээл болохуйцаар feedback хийх талаар тайлбарлалаа.

Уг сургалтад тус төвийн багш, МУИС, ХААИС-ийн багш нарын төлөөлөл нийт 21 багш хамрагдсан ба сургалтын дараах санал асуулгын үр дүнгээс харахад багш нарын хувьд цаашид сургалтдаа ашиглах арга техник түүний ач холбогдлын талаар мэдлэгээ тэлж, шинэчилж чадсан, шинэ мэдлэг арга барил олсон, хэрэгцээнд нийцсэн сургалт боллоо гэж дүгнэж байна.



*Зураг 13. Сургалтыг удирдан явуулсан
Ямазаки Кёоко багш*



Зураг 14. Сургалтын дасгал ажлын явц



3. Эрдэнэт хотод “Хүний нөөцийн менежмент” сургалтыг зохион байгуулав.

Монгол-Японы төвийн бизнесийн сургалт нь бүрэн танхимын сургалт хэлбэрээр зохион байгуулагддаг ба ингэхдээ голчлон Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй компани, аж ахуйн нэгжийн удирдлага болон ажилтнууд түлхүү хамрагддаг онцлогтой билээ. Орон нутгаас сургалтад хамрагдах хүсэлт ихээр ирдэг ба бид аль болох орон нутгийн иргэддээ хэрэгцээ шаардлагад нь нийцсэн сургалтыг орон нутагт нь зохион байгуулах боломжийг байнга эрэлхийлж байна.

Үүний хүрээнд өнгөрсөн онд орон нутгийн компани аж ахуйн нэгжийн хүний нөөцийн менежментэд тулгарч буй асуудлыг хамтдаа хэлэлцэх, шийдэл хайх зорилгоор “Хүний нөөцийн менежмент” суурь мэдлэгийн сургалтыг анх удаа Эрдэнэт хотод зохион байгуулсан нь бидний хувьд нэгэн чухал ажлын эхлэл боллоо гэж үзэж байна.

Өнгөрсөн оны 11 сард 2 өдрийн турш тус сургалтыг зохион байгуулсан ба сургалтыг Монгол-Японы төвийн үндэсний сургагч багш, Шин Хикари ХХК-ийн захирал Д.Дашмаа удирдан явуулсан бөгөөд сургалтад Эрдэнэт хотноо үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжийн төлөөлөл 16 хүн хамрагдлаа. Оролцогчид сурах хүсэл эрмэлзэл дүүрэн байсныг онцлон тэмдэглэхэд таатай байна.

Нийт оролцогчид хүний нөөцийн менежментийн тулгарч буй асуудлыг авч хэлэлцэж, санал солилцонгоо харилцан бие биенээсээ суралцаж байсан нь уг сургалтыг илүү үр дүнтэй болгосон билээ.



Зураг 15. Эрдэнэт хот “Хүний нөөцийн менежмент сургалтын үер”



Зураг 16. Дасгал ажлын явц



II. БИЗНЕСИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТАСАГ





I. 2024 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН МОНГОЛ-ЯПОНЫ БИЗНЕСИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН


Бизнесийн хамтын ажиллагааны тасаг 2024 онд хоёр орны бизнесийн хамтын ажиллагааг дэмжих үйл ажиллагаа өргөжүүлэн илүү олон төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг дэмжиж ажиллаа.

Монгол-Япон төвийн бизнесийн хамтын ажиллагааг дэмжих үйл ажиллагаа нь 8 дах жилдээ тасралтгүй үргэлжилж буй бөгөөд энэ онд “Бизнесийн хамтын ажиллагааны тасаг” албан ёсоор байгуулагдсан нь тус үйл ажиллагааг цаашид илүү тогтвортой үргэлжлэхэд чухал нөлөө үзүүлэх үйл явдал болж өрнөлөө. Бизнесийн хамтын ажиллагааны чиглэлээр төвөөр үйлчлүүлэгчдийн тоо монгол, япон гээд өмнөх онуудтай харьцуулахад харьцангуй тогтворжиж, 240 гаруй хүн үйлчлүүлсэн байна. Мөн түүнчлэн Монгол Японы хоорондын бизнесийн хамтын ажиллагаа эрчимжиж, нийт 19 төрлийн үйл ажиллагааг амжилттай гүйцэтгэлээ. Хоёр улсын хооронд бизнес болон хүмүүс хоорондын харилцаа эрчимтэй хөгжиж байгаа бөгөөд цаашид ч илүү их өргөжихийн хэрээр бусад Япон төвүүдтэй хамтын ажиллагаагаа тэлж, Япон төдийгүй бусад орнуудтай хамтран ажиллах боломжууд нэмэгдэх хандлагатай байна.

Энэ жилийн хувьд бас нэгэн онцлог нь Япон талаас Монгол орны бизнес, соёлыг сонирхох компаниудын төлөөлөлүүд өмнөх онуудтай харьцуулахад харьцангуй нэмэгдэж ЖАЙКА болон ЖЕТРО олон улсын байгууллагуудтай хамтарсан аялал, бусад хувийн хэвшлийн компаниудын хүсэлтээр үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн танилцуулах эвент арга хэмжээ, семинар зэргийг амжилттай зохион байгууллаа. Эдгээр гэрээт ажлуудын үр дүнд Монгол залуус Японд ажиллах боломжууд нэмэгдэхийн зэрэгцээ Японы бүтээгдэхүүн, үйлчилгээг Монголын зах зээлд оруулах боломжууд нэмэгдэж, хамтын ажиллагааны эхлэлүүд тавигдлаа.

Бизнесийн хамтын ажиллагааны хүрээнд мэдээллийн түгээлт, таниулах хэмжих үзүүлэлтийг уулзсан үйлчлүүлэгчдийн дараах тоон үзүүлэлтээр¹ илэрхийлдэг.

¹ Энд дурдагдаж буй уулзалт гэдэг нь танхимаар эсвэл цахимаар гэсэн 2 хэлбэрээр, зөвлөгөө болон лавлагаанд хариулан, гэрээт ажлын төлөвлөлт, зохион байгуулалттай холбоотой хийсэн хурлын тоог хэлнэ.



2017-2024 онд хийсэн уулзалтын тоон харьцуулалт

Дээрх график дээр харагдаж байгаачлан 2024 онд үйлчлүүлэгчдийн тоо өмнөх онтой дүйцэж үйл ажиллагаа тогтвортой явагдаж байна. 2024 оны хувьд Жайка-гийн өвсний үндэс төсөл, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны төсөл болон бусад захиалгат төрийн төслүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллаа.

№	Үйл ажиллагааны нэр	
1	Жайка-тай холбоотой ажил (төлбөртэй)	Өвсний үндэс төсөл Улаанбаатар хот “Юнитранд” компани /тайлан орчуулга/
2		Японы санхүүгийн корпораци /Монголд дахь Бизнес аялал/
3		Орикон консалтинг компани (Нүүрс төрөгчийн ялгарал багатай нийгмийг бий болгох хот хоорондын хамтын ажиллагааны төсөл)
4		JICA Кюүшю /Монголд дахь Бизнес аялал/
5	Жайка-тай холбоотой ажил (төлбөргүй)	MONJA 2024
6		Монгол-Япон Бизнес Форум
7		Foodex2024, Foodex 2025 –д Монгол павилон зохион байгуулах хороо гишүүн
8	Хувийн хэвшил хамтын ажиллагаа ажил (төлбөртэй)	Шизүока муж “Озава тэнт” компани(Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн хадгалах майхан хэлбэрийн зоорийн туршилт судалгаа)
9		Чиба банк өдөрлөг
10		Кожицү компани /автомашины сэлбэг үйлдвэрлэгч япон компаниудтай уулзах өдөрлөг/
11		HIS /Анкет судалгаа/
12		Хаттори Папер компани үйл ажиллагаа танилцуулга уулзалт



13	Бусад ажил (төлбөртэй)	JETRO үйл ажиллагаа
14		Япон улсын элчин сайдын яам, Ока&Вауаг хуулийн ферм(Хуулийн семинар)
15		Япон улс Шинагава мужийн семинар
16		Хитачи /аж үйлдвэрийг дэмжих төв/ үйл ажиллагаа
17		Нийгата муж /Технологийн хамтын ажиллагааны холбоо/ (Япон дахь далага сургалт)
18		JFM 2024
19	Matching (төлбөртэй)	Kaigen Pharma Co., Ltd. & Next Generation Health LLC

Тус төвийн төлбөртэй үзүүлдэг бизнесийн хамтын ажиллагааны үйлчилгээний орлого жил ирэх тусам тогтворжиж буй нь бизнесийн хамтын ажиллагааг дэмжих үйл ажиллагааг тогтвортой хийж, таниулан сурталчлах үйл ажиллагаа болон үйлчилгээний чанарын сайжруулалт дээр анхаарсаны үр дүн юм.

Бизнесийн хамтын ажиллагааг дэмжих ажил цаашид Монгол-Японы бизнесийн хамтын ажиллагаа үүсгэх орчинг тогтмол бий болгох, төрийн төслүүдээс гадна хувийн хэвшлийн хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх, үйл ажиллагаагаа тогтворжуулах. Мөн бусад Япон төвүүдтэй хамтарсан үйл ажиллагаа явуулах гэсэн төлөвлөгөөтэй байна.



II. ОНЦЛОХ МЭДЭЭ

1. Монгол улсын "Үйлдвэрлэлийн технологийг сайжруулах" сэдэвт Япон дахь дадлага сургалтыг амжилттай зохион байгууллаа.

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв нь Япон Улсын Нийгата мужийн “Олон улсын техник технологи хамтын ажиллагааны холбоо”-той хамтран Монгол улсын "Үйлдвэрлэлийн технологийг сайжруулах" сэдэвт Япон дахь дадлага сургалтыг хамтран зохион байгуулах 3 жилийн гэрээ байгууллаа. Энэ гэрээний дагуу тус дадлага сургалтад хүнсний салбарт үйлдвэрлэл эрхлэгч Монгол-Японы төвийн Бизнесийн үндсэн сургалт төгсөгч хоёр компанийн төлөөлөл болон тус төвийн Бизнесийн хамтын ажиллагааны тасгийн мэргэжилтэн гурван хүний бүрэлдэхүүнтэй баг 2024 оны 11-р сарын 17-ноос 25-ны өдрүүдэд Нийгата мужийн аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага солилцлоо.

Тус сургалтыг зохион байгуулах бэлтгэл ажилаас эхлээд хөтөлбөр боловсруулалт дээр Монгол-Японы төв болон Нийгата мужийн “Олон улсын техник технологи хамтын ажиллагааны холбоо” хамтран ажиллаж, сургалтад оролцогч компаниудын эрэлт хэрэгцээг урьдчилан судалж, түүнд тааруулан зочлох компани болон зөвлөгөө авах мэргэжилтэн, судалгааны байгуулга зэргийн агуулгыг тогтсон нь тус сургалтын үр дүн өндөр байх шалтгаануудын нэг байсан бөгөөд тус сургалтын үеэр оролцогчид Япон компанийн үйл ажиллагаатай танилцаад зогсохгүй Японы соёл, Япон маягийн менежментийн арга барилтай бодитоор танилцах, өөрсдийн компанидаа хэрэгжүүлэх олон олон санааг олж авсан үр дүнтэй хөтөлбөр болж өндөрлөлөө.



Зураг 17. “Курияа Бейка ХХК: Бакаүке үйлдвэр дэх айлчлалын үеэр”



Зураг 18. “Абио Нийгатагийн хөдөө аж ахуй, биотехникийн сургуультай танилцах аялалын үеэр”



Энэхүү дадлага сургалт нь гэрээний хугацаанд жил бүр зохион байгуулагдахаар төлөвлөгдөж буй бөгөөд цааш цаашдын сургалтын хөтөлбөр, агуулгыг тогтмол сайжруулан, бодит үр дүнд хүрэхүйц дадлага сургалт болгохоор төлөвлөн ажиллаж байна.

Хүснэгт-10: "Үйлдвэрлэлийн технологийг сайжруулах" сэдэвт Япон дахь дадлага сургалтын суралцагчид

№	Нэр	Албан тушаал	Байгууллагын нэр
1	Б.Сарнай	Бизнесийн хамтын ажиллагааны тасгийн мэргэжилтэн	Монгол-Япон төв
2	М.Нарантуяа	Инновац, Технологийн хэлтсийн дарга	Жүр-Үр ХХК
3	Э.Алтантуяа	Үйлдвэрлэлийн алба, Цехийн дарга	Өгөөж-Чихэр боов ХХК

Хүснэгт-11: "Үйлдвэрлэлийн технологийг сайжруулах" сэдэвт Япон дахь дадлага сургалтын хөтөлбөр, 2024 он.

Сар өдөр	Байршил
11-р сарын 17, Ням гараг	Наритад буух: 14:30 Keisei Limited Express Skyliner No46: Нисэх онгоцны буудлын 2-р байрнаас 16:02 цагт хөдөлнө → 16:43 цагт Үэнод хүрнэ JR Шинкансен Токи 333: Үэногоос 17:14-д хөдөлнө → 18:57-д Нийгатад хүрнэ Нийгата өртөө ~Hotel
11-р сарын 18, Даваа гараг	10:00 - "Курияма Бейка ХХК : Бакауке үйлдвэр" Бүтээгдэхүүний дэвшилтэт савлагааны стратеги, үйлдвэрлэлийн автоматжуулалт бүхий цагаан будааны жигнэмэгийн үйлдвэр 12:00 - "Фурусато тосгон" (Бан Я тэй ресторанд үдийн хоол) Фурусато тосгоны байгууламжийн аялал 14:00 - "Икүтопия Шокүхана" Хүнс-Цэцэг боловсролын төв
11-р сарын 19, Мягмар гараг	10:00 - "Камеда Сейка ХХК Ширане үйлдвэр" : Японы зах зээл дэх эзлэх хувь: 32.9% Үйлдвэрийн тайлбар, үйлдвэртэй танилцах, санал бодлоо солилцох 12:30 - Үдийн хоол (Агри парк дотор үдийн хоол) 13:30 - "Нийгата хотын Агри парк" Ерөнхий тайлбар, хоол боловсруулах төвийн аялал, нэгдсэн аялал
11 сарын 20, Лхагва гараг	10:00-"Хөдөө аж ахуйн үндэсний хүрээлэн, Хүнсний судалгааны төв" 11:30 - Үдийн хоол (Камо хотын далайн хүнсний ресторан Камогава) 13:30 - "DMG MORI Precision Boring ХХК" Өндөр нарийвчлалтай, том машин хэрэгсэл үйлдвэрлэгч, CAD/CAM систем 16:00 - "Gateau Senka Нацу Ханаби Кан" *Үйлдвэрлэлтэй цонхоор танилцах
11 сарын 21, Пүрэв гараг	09:30-10:00 Yasuda Yogurt Ltd : Сүүн бүтээгдэхүүн 11:30 - Үдийн хоол (Цубамесанжо Бит Цубамесанжо гол дэлгүүр, Цубамесанжо Бусанкан) "Цубамэ Санжо бүтээгдэхүүний музей" аялал



	13:30 - Тожиро ХХК “Тожиро нээлттэй үйлдвэр” 15:00-17:00 Үйл ажиллагааны тайлан, санал солилцох уулзалт Чисоку танхим 18:00 - Хүлээн авалт
11-р сарын 22, Баасан гараг	10:00 - "Нийгата мужийн исгэх үйлдвэрлэлийн туршилтын төв" Нийгатагийн сакэ исгэх үйлдвэрлэлийн танилцуулга 12:00 - Үдийн хоол (Нийгата галт тэрэгний буудлын урд, Арт зочид буудал, Iroha ресторан) 13:30~ "Нийгатагийн хөдөө аж ахуй, биотехникийн сургууль Абио" Мэргэжлийн сургууль, сургуулийн аялал, орон нутгийн нөөцийг ашигласан бүтээгдэхүүний талаархи танилцуулга Бүтээгдэхүүн хөгжүүлэлт (амттан зэрэг)-ийн талаар, судалгааны тайлан
11-р сарын 23, Бямба гараг	10:30 - "Зах зээлийн судалгаа" 12:00 - Үдийн хоол 13:30 - "Зах зээлийн судалгаа"
11-р сарын 24, Ням гараг	Нийгата → Токио Токио хот: Чөлөөт цаг
11-р сарын 25, Даваа гараг	Наритагаас хөдлөх: 15:30 OM502

2. Бизнесийн хамтын ажиллагааны тасгийн эхлэл ба одоо

Энэ жилээс бизнесийн хамтын ажиллагааны тасгийн нийтлэл жилийн тайланд бие даасан байдлаар нийтлэгдэх болсонд маш их баяртай байна. Бизнесийн хамтын ажиллагаа хөгжүүлэх үйл ажиллагаа 2015 оноос хойш Монгол-Японы төвд хэрэгжиж эхэлж, ийнхүү 10 дахь жилээ угтах гэж байна. Миний бие 2017 оны 9 сараас JICA-аас томилогдон бизнесийн хамтын ажиллагааг хөгжүүлэх ажлыг хариуцан ажиллах болсон. Бизнесийн хамтын ажиллагааг хөгжүүлэх үйл ажиллагаа нь шинэ төсөл байсан тул Монгол-Японы төвийн ажилтнуудад ойлгуулахад эхэндээ хүндрэлтэй байсан. Харин бизнесийн хамтын



Зураг 19. JICA Бизнесийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, Японд хөдөлмөр эрхлэх монгол иргэдийг дэмжих мэргэжилтэн Накамура Коо

ажиллагааны үйл ажиллагаа нь бие даасан тасаг болон хөгжүүлэхэд онцгой хүчин чармайлт гаргасан Монгол-Японы төвийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Анх ажиллаж эхэлж байхад сард 2-3 удаа л товлогддог байсан компанийн уулзалт сард 2019 он гэхэд 10 гаран болтлоо өссөн. Ийнхүү бизнес хамтын ажиллагааны



тасгийн хамт олон ч илүү идэвхтэй ажиллах болж тасгийн орлого ч дагаад өссөн. Түүнчлэн тасгийн дарга Ж.Оюунчимэг Япон улсад суралцаад эргэн ажилдаа орсон байсан тул Монгол-Японы төвийн ажилтнууд бизнесийн хамтын ажиллагааны төслийн гол тулгуур нь болох болов уу гэсэн хүлээлт ихэссэн гэж бодож байна.

Гэвч 2020 оноос короновирусийн халдвар дэлхий даяар тархсан билээ. Ийнхүү 2020 онд компаниудтай хийсэн уулзалтын тоо 79 байсан ба энэ нь 2019 оныхоос 2 дахин бага тоо юм. Бизнесийн зорилгоор Монгол Японы хооронд аялах нь бараг л боломжгүй байсан үе билээ. Тухайн үед короновирусийн тархалт хэзээ нэгэн цагт намдана гэсэн хүлээлттэйгээр бизнесийн хамтын ажиллагааны үйл ажиллагааг боломжит байдлаар үргэлжлүүлж байсан. Энэ цаг үеэс хойш аль хэдийн 5 жил өнгөрчээ. Ийнхүү энэ жил компанийн уулзалтын тоо 300-г давж, короновирус дэлгэрэх жилийн өмнөхтэй харьцуулахад 2 дахин өсжээ. Тасгийн орлого ч мөн энэ үеийнхээс өндөр болсон. Төсөл анх эхэлж байхад Монгол-Японы төвөөс энэхүү үйл ажиллагааг хариуцах ажилтан байхгүй байдаг байсан бол одоо 3 ажилтантай болоод буй.

Ийнхүү өргөжиж буй бизнесийн хамтын ажиллагааг дэмжих үйл ажиллагааг хариуцан ажилласан 7 жилийн хугацаанд төрөл бүрийн үйл ажиллагааг хийсээр ирлээ. Эдгээрээс хамгийн их сэтгэлд хоногшин үлдсэн нь “Japan Festival in Mongolia” (цаашид JFM гэх) арга хэмжээг зохион байгуулагчдын нэгээр Монгол-Японы төв багтах болсон явдал юм. JFM нь хүн бүрийн мэддэг алдартай арга хэмжээг зохион байгуулж, “Монголын талаар Япончуудад, Японы талаар Монголчууд таниулах” зорилготой хүсэл тэмүүллээр дүүрэн арга хэмжээ билээ. 2019 онд анх зохион байгуулагдаж байхад нийт 6000 хүн, 2022 онд 9000 хүн, 2024 оноос Сүхбаатарын талбайд 2 өдөр зохион байгуулагдах болсноор 26,000 хүн ирж, олон Монголчуудын дунд алдартай арга хэмжээнүүдийн нэг болоод байна.



Зураг 20-1, 20-2. “Japan Festival in Mongolia-2024 үйл ажиллагааны ерөнхий зураг”



Мөн энэхүү арга хэмжээнээс гадна “Монгол-Японы бизнес” форум 2022 оноос зохион байгуулагдах болж, Монгол-Японы төв мөн энэхүү арга хэмжээний хамтран зохион байгуулагчдын нэг болж, Японы 8-р сарын Обон фестивалийн дараах JAPAN WEEK-тэй төстэй амжилттай арга хэмжээ болон өргөжиж байна. Мөн эдгээр арга хэмжээнд JICA-ийн мэргэжилтний хувиар оролцсондоо үнэхээр их баяртай байна.

Сүүлийн 7 жилийн хугацаанд Монголын эдийн засаг маш сайн өссөн ба цаашид ч үүнээс илүү өснө гэж бодож байна. Миний анх Монгол ирж байсан 23 жилийн өмнөх үетэй харьцуулахад маш өөр болсон билээ.

Тиймээс одоогоос Япон компани Монголын зах зээлд, Монгол компани Японы зах зээлд нэвтрэх боломж илүү их болж байгаа гэж бодож байна. Би 2025 оны 4 сарын 21-ний өдрөөс ажлаа хүлээлгэн өгч, Япон буцах ч гэсэн цаашид Монгол, Японы бизнесийн хамтын ажиллагаа нь Монгол, Япон хоёр улсыг хооронд нь холбох гүүр болж эдийн засгийн хувьд сайн хөрш байж харилцан ашигтайгаар хамтдаа хөгжих харилцааг тогтоохыг чин сэтгэлээсээ хүсэж байна.

Эцэст нь хэлэхэд, Япон сангийн зохицуулагч мэргэжилтэн болж ажиллаж эхэлснээс хойш нийт 9 жилийн хугацаанд, Монгол-Японы төвтэй холбогдож, олон Монгол болон Япон хүмүүстэй танилцаж, хамтран ажиллан бүрэн эрхийн хугацаагаа амжилттай дуусгах гэж байна. Та бүхэндээ чин сэтгэлийн талархал илэрхийлье. Маш их баярлалаа.



Ш. ЯПОН ХЭЛНИЙ СУРГАЛТЫН ТАСАГ





I. 2024 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН ЯПОН ХЭЛНИЙ СУРГАЛТ, СЕМИНАРЫН ТАЙЛАН

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв /цаашид Монгол-Японы төв гэх/-ийн Япон хэлний сургалтын тасаг нь 2012 оны 04 сараас Япон сангийн япон хэлний боловсролын стандартад /цаашид JF стандарт гэх/ нийцүүлсэн япон хэлний сургалтыг хавар, зун, намрын улиралд зохион байгуулж байна. Түүнчлэн “Монгол японы төвийн япон хэлний түвшин тогтоох жишиг шалгалт”, “Япон оюутнуудад зориулсан Монгол орны талаарх тайлбар лекц”, “Япон соёлтой танилцагчаа тусгай сургалт” зэрэг олон төрлийн сургалтуудыг төлөвлөн хэрэгжүүллээ.

Дээр дурдсан сургалтаас гадна бусад байгууллагуудын хүсэлтийн дагуу гэрээт ажлуудыг гүйцэтгэлээ. Тухайлбал, “Тусгай ур чадварын тогтолцоо”-той холбоотой үйл ажиллагаа, Японы “Киото их сургуульд элсэн орохын өмнөх япон хэлний бэлтгэл сургалт-2024” болон “Монгол дахь JDS хөтөлбөрийн оюутнуудад зориулсан япон хэлний анхан шатны бэлтгэл сургалт”-ыг үргэлжлүүлэн зохион байгуулснаас гадна, “Япон хэлтэй аяллын хөтөч-тайлбарлагч бэлтгэх ахисан түвшний сургалт”, “ЖАЙКА-ийн дадлагажигч хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй оюутнуудад зориулсан япон хэлний бэлтгэл сургалт”-ыг шинээр амжилттай зохион байгууллаа.

1. Япон хэлний сургалтын талаар

Япон хэлний сургалт нь дээр дурдсан JF стандартын дагуу явагдаж байгаа болно. Энэхүү тайлан мэдээ нь 2024 оны 02 сараас 05 сарын хооронд явагдсан хаврын сургалт болон 05 сараас 07 сарын хооронд явагдсан зуны сургалтын эхний хагас, 07 сараас 08 сарын хооронд явагдсан зуны сургалтын сүүлийн хагас, 09 сараас 12 сарын хооронд явагдсан намрын сургалт /дуусах хугацаа 2024 оны 01 сар/-уудын тайлан болно.

Хавар, намар явагддаг сургалтуудад суралцагчдын түвшинд тохирсон “Яриа, дүрэм хосолсон цогц сургалт”-ууд болон “11-13 насны хүүхдэд зориулсан марүгото япон хэлний анхан шатны сургалт”, япон хэлний багш нарт зориулсан “Япон хэлний заах аргын сургалт”-ыг явуулж байна. Дээрх сургалтуудын агуулга болон үр дүнгийн дэлгэрэнгүй мэдээллийг доорх хүснэгтээс харна уу. Хавар болон намрын сургалт нь дөрвөн сар орчим үргэлжилдэг ба “Яриа, дүрэм хосолсон цогц сургалт-1” /анхан шат/-ээс “Яриа, дүрэм хосолсон цогц сургалт-6” /дунд шат/ хүртэл явагддаг. Энэ жилийн “Япон хэлний заах аргын сургалт” нь хавар болон намар “Япон сангийн япон хэлний боловсролын стандартыг ашиглан явуулах анхан шатны сургалтын заах арга зүй”



сэдвээр явагдсан. Зуны сургалтын эхний болон сүүлийн хагаст “Япон хэлний анхан шатны түргэвчилсэн сургалт”-ыг нийт 4 удаа, “8-10 насны хүүхдэд зориулсан япон хэлний анхан шатны сургалт”-ыг 1 удаа зохион байгууллаа.

Үүнээс гадна 2023 оноос эхлэн шинээр зохион байгуулж буй “Япон хэлтэй аяллын хөтөч-тайлбарлагч бэлтгэх сургалт” /нийт 13 удаагийн 33 цаг/-ыг энэ онд мөн явуулсан төдийгүй намрын улиралд дундаас дээш түвшний мэдлэгтэй суралцагчдад зориулан “Бизнесийн япон хэлний сургалт”-ыг амжилттай зохион байгуулсан. 2024 оны хавар “Япон хэлний дунд түвшний суралцагчдын уншиж ойлгох чадварыг ахиулах сургалт”, 2024 оны зун “РРТ-д суурилсан япон хэлний сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах арга зүй” сэдэвт дадлага ажилд суурилсан сургалтыг шинээр зохион байгуулсан нь өндрөөр үнэлэгдсэн юм.

2. Хамтран зохион байгуулсан үйл ажиллагааны талаар

2024 онд хамтран зохион байгуулсан үйл ажиллагааны хувьд, 11 сард “Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 30 дахь удаагийн тэмцээн”-ийг Япон улсын элчин сайдын яам, Монголын япон хэлний багш нарын холбоо, ШУТИС-ийн Гадаад хэлний институт, Япон сантай хамтран зохион байгууллаа. Түүнээс гадна “Монголын япон хэлний сургалт, судалгааны холбооны ээлжит хурал” зэрэг олон төрлийн үйл ажиллагааг хамаарал бүхий байгууллагуудтай хамтран амжилттай зохион байгуулсаар ирсэн билээ.



2024 онд япон хэлний сургалтын тасгаас зохион байгуулсан үйл ажиллагаа

Хүснэгт-12: Хавар, зун, намрын сургалтууд

Эх сурвалж: Монгол-Японы төв, Япон хэлний сургалтын сар бүрийн тайлан

№	Сургалтын нэр	Хугацаа	Агуулга	Багш	Суралц агчдын тоо
1	Хүүхдэд зориулсан марүгото япон хэлний анхан шатны сургалт /11-13 нас, А1 түвшин/	2024/02/06- 2024/05/09	Япон хэлийг анхлан суралцаж буй 11-13 насны хүүхдүүдэд зориулсан, Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото нюүмон- А1, рикаи" сурах бичгийг ашиглан сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь эзэмшүүлэх сургалт.	П.Марал, Күрияма Томоюки	11
2	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-1А анги /А1 түвшин/	2024/02/05- 2024/05/20	Япон хэлийг анхлан суралцаж буй хүмүүст зориулсан сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь эзэмшүүлэх сургалт бөгөөд Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото нюүмон-А1 кацүдоо, рикаи" хэмээх 2 сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулав.	Д.Золзаяа, С.Амарбаясгал ан, Күрияма Томоюки	23
3	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-1В анги /А1 түвшин/	2024/02/05- 2024/05/20	Япон хэлийг анхлан суралцаж буй хүмүүст зориулсан сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь эзэмшүүлэх сургалт бөгөөд Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото нюүмон-А1 кацүдоо, рикаи" хэмээх 2 сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулав.	Д.Золзаяа, С.Буманцэцэг, Күрияма Томоюки	26
4	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-2А анги /А2 түвшний эхний шат/	2024/02/05- 2024/05/20	А1 түвшний япон хэлийг эзэмшсэн суралцагчдад зориулсан дараагийн А2 түвшний эхний шатыг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото шокюү-1 А2 кацүдоо, рикаи" хэмээх 2 сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулав.	Д.Мөнхтуяа, П.Алтанбулаг, Сато Кэйичи	21



5	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-2В анги /А2 түвшний эхний шат/	2024/02/05-2024/05/20	А1 түвшний япон хэлийг эзэмшсэн суралцагчдад зориулсан дараагийн А2 түвшний эхний шатыг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото шокюү-1 А2 кацүдоо, рикаи" хэмээх 2 сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулав.	П.Алтанбулаг, С.Амарбаясгалан, Сато Кэйичи	22
6	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-3А анги /А2 түвшний дунд шат/	2024/02/05-2024/05/20	А2 түвшний эхний шатыг эзэмшсэн суралцагчдад зориулсан, дараагийн шатны А2 түвшний дунд шатны мэдлэгийг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото шокюү-2 А2 кацүдоо, рикаи" хэмээх 2 сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулав.	Ц.Онон, П.Марал, Икома Каорү	15
7	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-3В анги /А2 түвшний дунд шат/	2024/02/05-2024/05/20	А2 түвшний эхний шатыг эзэмшсэн суралцагчдад зориулсан, дараагийн шатны А2 түвшний дунд шатны мэдлэгийг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото шокюү-2 А2 кацүдоо, рикаи" хэмээх 2 сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулав.	Ц.Онон, П.Марал, Икома Каорү	25
8	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-4 /А2 түвшний төгсгөлийн шат-В1 түвшний эхний шат/	2024/02/07-2024/05/30	А2 түвшний дунд шатыг эзэмшсэн суралцагчдад зориулсан, А2 түвшний төгсгөлийн шат болон В1 түвшний эхний шатыг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото шочюүкюү А2/В1" сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулав.	Д.Золзаяа, Күрияма Томоюки	18



9	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-5 /B1 түвшин/	2024/02/06-2024/05/21	B1 түвшний эхний шатыг эзэмшсэн суралцагчдад зориулан B1 түвшний дунд шатыг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото чюүкюү-1 B1" сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулав.	Ц.Онон, Икома Каорү	17
10	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-6 /B1 түвшин/	2024/02/20-2024/05/30	B1 түвшний төгсгөлийн шатны суралцагчдад B2 түвшний эхний шатыг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. Япон сангийн япон хэлний стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото чюүкюү-2 B1" сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулав.	Д.Мөнхтуяа, Икома Каорү	14
11	Япон хэлний заах аргын сургалт /B2-C1 түвшин/	2024/02/22-2024/05/16	Хоёр дахь хэл эзэмшихүйн онол болон Япон сангийн япон хэлний боловсролын стандартыг ашигласан япон хэлний заах арга зүйн суурь ойлголтод суралцах Анхан шатны япон хэлний нэгж хичээлийн хөтөлбөрийг боловсруулахад суралцаж, өөрийн боловсруулсан хөтөлбөрт үндэслэн жишиг хичээлийг заах	Цүрүта Ясүюки, С.Амарбаясгалан	14
12	Япон хэлтэй аяллын хөтөч-тайлбарлагч бэлтгэх сургалт-2024	2024/04/01-2024/04/17	Япон жуулчдын хөтөч-тайлбарлагчаар ажиллах хүсэлтэй хүмүүст зориулан аяллын хөтчийн ноу-хау, ёс зүй, гадаад төрх байдал, хувцаслалт, мэдвэл зохих үг хэллэгийн талаарх ойлголтыг өгч, бодитоор хэрэглэхэд нь туслах зорилго бүхий сургалт бөгөөд лекц, бодит туршлага дээр үндэслэсэн яриа, хосоор болон багаар ажиллах дасгал даалгавар зэрэг онол, практик хослуулсан нийт 15 удаагийн 38 цагийн сургалт юм.	Үндсэн багш: О.Булган, Э.Эрдэнэцэцэг, П.Марал, Б.Буманцэцэг, С.Амарбаясгалан Зочин багш: Б.Батмөнх, Б.Дуламсүрэн /Монголын мэргэжлийн хөтөч тайлбарлагчдын холбоо/ Б.Гантулга /Монголын улаан загалмай нийгэмлэг/	17
13	Япон хэлний дунд түвшний суралцагчдын уншиж ойлгох чадварыг ахиулах сургалт	2024/04/02-2024/05/21	Япон хэлний түвшин тогтоох шалгалтын дунд түвшний уншиж ойлгох даалгаврыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай үндсэн мэдлэг, чадваруудыг	Цүрүта Ясүюки	14



	*Шинэ сургалт		эзэмшүүлнэ. Зөв хариултыг сонгох даалгавар бүхий шалгалтын материал дээр ажиллаж, хариулах арга стратегид суралцана.		
14	Япон хэлний анхан шатны түргэвчилсэн сургалт-А анги /А1 түвшин/	2024/05/24-2024/07/05	Япон хэлийг анхлан суралцаж буй хүмүүст зориулсан сургалт бөгөөд Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото нюүмон А1 рикаи" сурах бичгийг ашиглан сонсох, ярих, унших, бичих чадваруудыг олгох сургалт юм.	Д.Золзаяа, С.Амарбаясгалан, Күрияма Томоюки	28
15	Япон хэлний анхан шатны түргэвчилсэн сургалт-В анги /А1 түвшин/	2024/05/24-2024/07/05	Япон хэлийг анхлан суралцаж буй хүмүүст зориулсан сургалт бөгөөд Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото нюүмон А1 рикаи" сурах бичгийг ашиглан сонсох, ярих, унших, бичих чадваруудыг олгох сургалт юм.	Д.Золзаяа, П.Марал, П.Алтанбулаг, Күрияма Томоюки	28
16	Япон хэлний анхан шатны түргэвчилсэн сургалт-А анги /А1 түвшин/	2024/07/18-2024/08/28	Япон хэлийг анхлан суралцаж буй хүмүүст зориулсан сургалт бөгөөд Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото нюүмон А1 рикаи" сурах бичгийг ашиглан сонсох, ярих, унших, бичих чадваруудыг олгох сургалт юм.	Д.Золзаяа, Д.Мөнхтуяа Күрияма Томоюки	28
17	Япон хэлний анхан шатны түргэвчилсэн сургалт-В анги /А1 түвшин/	2024/07/18-2024/08/28	Япон хэлийг анхлан суралцаж буй хүмүүст зориулсан сургалт бөгөөд Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото нюүмон А1 рикаи" сурах бичгийг ашиглан сонсох, ярих, унших, бичих чадваруудыг олгох сургалт юм.	Д.Золзаяа, О.Булган, Күрияма Томоюки	28
18	Хүүхдэд зориулсан япон хэлний анхан шатны сургалт /8-10 нас/	2024/07/18-2024/08/20	Япон хэлийг хөгжилтэйгөөр сурах хүсэлтэй 8-10 насны хүүхдүүдэд зориулсан сургалт. Мэндчилгээний үг хэллэг, өөрийгөө танилцуулах, гэр бүлээ танилцуулах, дуртай идэх уух зүйлээ хэлэх, өөрийн биеийн бүтэц, төрсөн өдөр, хобби, амралтын өдөр зэргийн талаар хэлж сурсан. Мөн хирагана үсгийг уншиж, бичиж сурсан. Катакана үсгээр өөрийн нэр болон улсын нэрийг уншиж, бичиж сурсан.	П.Марал, Б.Буманцэцэг, Күрияма Томоюки	16
19	РРТ-д суурилсан япон хэлний сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах арга зүй	2024/08/13-2024/08/30	Япон хэлний хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэхэд шаардагдах РРТ-ийн үндсэн функц, техникийг суралцах	Күрияма Томоюки, С.Амарбаясгалан	11



	*Шинэ сургалт		Яриа, дүрэм, үсэг, үгийн сан голлосон хичээл тус бүрийн онцлогт тохирсон РРТ хэрэглэгдэхүүн бэлтгэх, хичээл заан дадлага хийх		
20	Хүүхдэд зориулсан маругото япон хэлний анхан шатны сургалт /11-13 нас, А1 түвшин/	2024/09/24-2024/12/24	Япон хэлийг анхлан суралцаж буй 11-13 насны хүүхдүүдэд зориулсан, Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Маругото нюүмон-А1, кацүдоо" сурах бичгийг ашиглан сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь эзэмшүүлэх сургалт.	П.Марал, Күрияма Томоюки	16
21	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-1А анги /А1 түвшин/	2024/09/25-2025/01/13	Япон хэлийг анхлан суралцаж буй хүмүүст зориулсан сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь эзэмшүүлэх сургалт бөгөөд Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Маругото нюүмон-А1 кацүдоо, рикаи" хэмээх 2 сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулав.	Д.Золзаяа, С.Амарбаясгалан, Мацүо Фүми	28
22	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-1В анги /А1 түвшин/	2024/09/25-2025/01/13	Япон хэлийг анхлан суралцаж буй хүмүүст зориулсан сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь эзэмшүүлэх сургалт бөгөөд Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Маругото нюүмон-А1 кацүдоо, рикаи" хэмээх 2 сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулав.	Д.Золзаяа, С.Амарбаясгалан, Мацүо Фүми	24
23	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-1С анги /А1 түвшин/	2024/09/25-2025/01/13	Япон хэлийг анхлан суралцаж буй хүмүүст зориулсан сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь эзэмшүүлэх сургалт бөгөөд Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Маругото нюүмон-А1 кацүдоо, рикаи" хэмээх 2 сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулав.	Д.Мөнхтуяа, П.Алтанбулаг, Күрияма Томоюки	16
24	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-2А анги /А2 түвшний эхний шат/	2024/09/25-2025/01/13	А1 түвшний япон хэлийг эзэмшсэн суралцагчдад зориулсан дараагийн А2 түвшний эхний шатыг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Маругото шокюү-1 А2 кацүдоо, рикаи" хэмээх 2	Д.Золзаяа, П.Алтанбулаг, О.Булган, Күрияма Томоюки	25



			сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулав.		
25	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-2В анги /A2 түвшний эхний шат/	2024/09/25-2025/01/13	A1 түвшний япон хэлийг эзэмшсэн суралцагчдад зориулсан дараагийн A2 түвшний эхний шатыг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото шокюү-1 A2 кацүдоо, рикаи" хэмээх 2 сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулав.	Д.Золзаяа, П.Алтанбулаг, О.Булган, Күрияма Томоюки	28
26	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-3А /A2 түвшний дунд шат/	2024/09/25-2025/01/13	A2 түвшний эхний шатыг эзэмшсэн суралцагчдад зориулсан, дараагийн шатны A2 түвшний дунд шатны мэдлэгийг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото шокюү-2 A2 кацүдоо, рикаи" хэмээх 2 сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулав.	Ц.Онон, П.Марал, Күрияма Томоюки	8
27	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-3В /A2 түвшний дунд шат/	2024/09/25-2025/01/13	A2 түвшний эхний шатыг эзэмшсэн суралцагчдад зориулсан, дараагийн шатны A2 түвшний дунд шатны мэдлэгийг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото шокюү-2 A2 кацүдоо, рикаи" хэмээх 2 сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулав.	Ц.Онон, П.Марал, Күрияма Томоюки	17
28	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-4 /A2 түвшний төгсгөлийн шат-B1 түвшний эхний шат/	2024/09/26-2025/01/23	A2 түвшний дунд шатыг эзэмшсэн суралцагчдад зориулсан, A2 түвшний төгсгөлийн шат болон B1 түвшний эхний шатыг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото шочюүкюү A2/B1" сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулав.	Д.Мөнхтуяа, Икома Каорү	22



29	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-5 /B1 түвшин/	2024/09/26- 2025/01/21	B1 түвшний эхний шатыг эзэмшсэн суралцагчдад зориулан B1 түвшний дунд шатыг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото чюүкюү-1 B1" сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулав.	Ц.Онон, Икома Каорү	8
30	Бизнесийн япон хэлний сургалт	2024/10/08- 2024/12/24	Дунд дээд түвшний япон хэл суралцагчдын бодит хэрэглээ, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн боловсруулсан сургалт юм. Япон хүмүүстэй ажил хэргээ саадгүй явуулахад нь тус дөхөм болох үүднээс бизнесийн харилцаанд утсаар хэрхэн ярих, бичиг баримт хэрхэн боловсруулах, и-мэйл хэрхэн бичих талаар ойлголт өгөхийн тулд сургалтын агуулгыг ярих, бичих, илтгэх гэсэн 3 хэсэгт хуваан боловсруулав.	Э.Эрдэнэцэцэг, Цүрүта Ясүюки	16
31	Япон хэлний заах аргын сургалт /B2-C1 түвшин/	2024/09/26- 2024/12/19	Хоёр дахь хэл эзэмшихүйн онол болон Япон сангийн япон хэлний боловсролын стандартыг ашигласан япон хэлний заах арга зүйн суурь ойлголтод суралцах Анхан шатны япон хэлний нэгж хичээлийн хөтөлбөрийг боловсруулахад суралцаж, өөрийн боловсруулсан хөтөлбөрт үндэслэн жишиг хичээлийг заах	Цүрүта Ясүюки, С.Амарбаясгал ан	20
					604



Хүснэгт-13: Тусгай сургалт, семинарууд

№	Сургалтын нэр	Хугацаа	Агуулга	Багш болон хариуцсан ажилтан	Оролцогчдын тоо
1	ЕБС-ийн япон хэлний багш нарт зориулсан заах аргын сургалт-2024	2024/01/23-2024/01/26	"Япон сангийн япон хэлний боловсролын стандартад тулгуурласан ярианы хичээлийн заах арга зүй" сэдвийн хүрээнд ЕБС-ийн япон хэлний багш нарт зориулан сургалтыг зохион байгуулж, Монгол орон даяар япон хэлний боловсролыг түгээн дэлгэрүүлэх, чанаржуулахад хувь нэмэр оруулахыг зорьсон. Сургалтын агуулга: Гадаад хэл заах аргын түүх болон онцлог, сургалтын хөтөлбөрийг хэрхэн боловсруулах, Япон сангийн хэлний боловсролын стандартад заасан "Харилцан ярих чадвар", ярианы хичээлийг хэрхэн заах, ярианы хичээлийн дүрд хувирах дасгалыг хэрхэн үр дүнтэй хийлгэх, ярианы чадварыг хэрхэн үнэлэх	Багш: Цүрүта Ясүюки Сургалт хариуцсан ажилтан: П.Марал, Б.Буманцэцэг	24
2	Япон хэлтэй аяллын хөтөч-тайлбарлагчдад зориулсан ахисан түвшний сургалт /B2-C1 түвшин/ *Шинэ сургалт	2024/02/19-2024/03/25	H&A Friendship Co., Ltd компанийн хүсэлтээр хөтөч-тайлбарлагчаар ажиллаж байсан туршлагатай хүмүүст зориулан зохион байгуулсан бөгөөд лекц, бодит туршлага дээр үндэслэсэн яриа, хосоор болон багаар ажиллах дасгал даалгавар зэрэг онол, практик хослуулсан нийт 15 удаагийн 37 цагийн сургалт. Сургалтын агуулга: Үйлчилгээнд хүндэтгэлийн үг хэллэгийг хэрхэн зөв хэрэглэх тухай, Японы түүх түүнийг Монголын түүхтэй хэрхэн харьцуулан тайлбар хүргэх тухай, соёл, ёс заншлын хүрээнд соёлын ялгаатай жуулчдад тайлбар хийх тухай, жуулчин зочны сэтгэлд хоногшихуйц storytelling хийх тухай, геополитик болон олон улсын харилцаа зэрэг	Үндсэн багш: О.Булган, Э.Эрдэнэцэцэг, Б.Буманцэцэг, С.Амарбаясгалан, Такигүчи Рёо, Күрияма Томоюки Зочин багш: Б.Батмөнх, Б.Дуламсүрэн, М.Мөнгөнцэцэг /Монголын мэргэжлийн хөтөч тайлбарлагчдын холбоо/	
3	Монгол дахь JDS хөтөлбөрийн оюутнуудад зориулсан япон хэлний анхан шатны бэлтгэл сургалт *Гэрээт сургалт	2024/04/15-2024/06/21	Хүний нөөцийг хөгжүүлэх JDS тэтгэлэгт хөтөлбөрт тэнцсэн хүмүүст зориулан Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Иродори хэрэглээний япон хэл" /A1 түвшний суурь шат/ сурах бичгийг ашиглан япон хэлний анхан шатны сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь эзэмшүүлэхийг зорьсон.	Д.Мөнхтуяа, Д.Золзаяа, Күрияма Томоюки	14



4	Киото их сургуульд элсэн орохын өмнөх япон хэлний бэлтгэл сургалт-2024 *Гэрээт сургалт	2024/06/17-2024/08/14	Киото их сургуулийн iUP хөтөлбөрт элсэн орж буй оюутанд зориулсан гэрээт сургалт бөгөөд Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото Япон хэл ба соёл" /нюүмон A1/ сурах бичгийг ашиглан, суралцагчийн сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь хөгжүүлэхийг зорьсон.	Цүрүта Ясүюки, Күрияма Томоюки, Ц.Онон, Э.Эрдэнэцэцэг	1
5	"ЖАЙКА-ийн дадлагажигч хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй оюутнуудад зориулсан япон хэлний бэлтгэл сургалт" *Гэрээт сургалт	2024/11/09-2025/05/31	JFS-B1 түвшин, JLPT-N3 түвшинтэй дүйцэхүйц япон хэлний мэдлэг эзэмшүүлэх зорилго бүхий сургалт. "Марүгото Япон хэл ба соёл" /Анхан дунд шат, дунд шат-1/ сурах бичгүүдийг ашиглан хэлний чадвараа ахиулахын сацуу N3 түвшний үгийн сан, дүрмийн чадвараа ахиулж, сонсож ойлгох болон уншиж ойлгох стратегид суралцана.	С.Амарбаясгалан, Д.Мөнхтуяа, П.Марал, Күрияма Томоюки	28
6	"Япон соёлтой танилцагсаа" тусгай сургалт *Шинэ сургалт	2024/05/06-2024/05/09	118-р сургуулийн 3-р ангийн сурагчдад зориулан цүмами зайкү буюу японы уламжлалт чимхлүүр гар урлалаас танилцуулж үсний зүүлт хийж, оригами буюу цаасан нугалбарын урлалаас танилцуулж зүрхэн хэлбэртэй номын хавчуурга хийснээс гадна япон уламжлалт тоглоом наадгай болох кэндама, кома-маваши, дарүма-отоши, тонтон сүмо зэргээс танилцуулж, хамт тоглож хөгжилдөв.	Э.Эрдэнэцэцэг, Д.Мөнхтуяа, П.Алтанбулаг, П.Марал, О.Булган, Б.Буманцэцэг, С.Амарбаясгалан	74
7	"Япон фестиваль Монголд-2024" дахь сургалт, үйл ажиллагааны танилцуулах булан	2024/08/17-2024/08/18	Япон хэлний сургалт, үйл ажиллагааны танилцуулах булан ажиллуулав.	Э.Эрдэнэцэцэг, Д.Мөнхтуяа, П.Алтанбулаг, Б.Буманцэцэг	500
8	Японы залуу хамтлаг, уран бүтээлчдийн япон хэлний суралцагчидтай хийх уулзалт	2024/08/19	Японы залуу хамтлагийн дуучид "Хүүхдэд зориулсан марүгото япон хэлний анхан шатны сургалт"-ын хүүхдүүдтэй уулзаж, хамтдаа дуу дуулж, цаасан нугалбар хийж, цагийг хөгжилтэй өнгөрүүлсэн.	П.Марал, Б.Буманцэцэг	52
9	Япон оюутнуудад зориулсан Монгол орны талаарх тайлбар лекц	2024/09/04	Токиогийн эдийн засгийн их сургуулийн оюутнуудад зориулан тус төвийн үйл ажиллагаа, Монголын талаарх тойм тайлбар, Монгол Япон хоёр орны соёлын онцлогийн талаарх танилцуулга хийж, монгол үндэсний дээл өмсөж зургаа авхуулсан.	П.Алтанбулаг, Э.Эрдэнэцэцэг, Т.Болормаа, Э.Урангоо	31



10	"ЖАЙКА-ийн дадлагажигч хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй оюутнуудад зориулсан япон хэлний бэлтгэл сургалт" эхлэхийн өмнөх хэлний түвшинг нягтлах шалгалт /Бичгийн болон ярианы шалгалт, сурах идэвхийг нягтлах ярилцлага/	2024/11/03	Япон хэлний түвшин тогтоох шалгалтын N4 түвшний мэдлэгийг шалгах яриа болон бичгийн шалгалт, сурах идэвхийг нягтлах ярилцлага	Э.Эрдэнэцэцэг, С.Амарбаясгалан , Д.Мөнхтуяа, П.Марал, Д.Цацрал	35
11	Монголд өгч болох япон хэлний түвшин тогтоох шалгалтуудын талаарх танилцуулга *Шинэ үйл ажиллагаа	2024/03/26 2024/03/27 2024/03/28 2024/04/29	2024 оны хаврын сургалтын суралцагчдад зориулан Монголд өгч болох япон хэлний түвшин тогтоох шалгалтуудын талаар танилцуулсан.	Э.Эрдэнэцэцэг, Д.Мөнхтуяа, П.Марал, П.Алтанбулаг, Б.Буманцэцэг, С.Амарбаясгалан	131
12	Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн япон хэлний түвшин тогтоох жишиг шалгалт /N1-N5 түвшин/	2024/05/13- 2024/05/17	N1-N5 түвшний жишиг шалгалт /Хэлний мэдлэг-үсэг, үгийн сан, хэлний мэдлэг-дүрэм, уншиж ойлгох чадвар, сонсож ойлгох чадвар/	Э.Эрдэнэцэцэг, П.Алтанбулаг, П.Марал, О.Булган, Б.Буманцэцэг, С.Амарбаясгалан	105
13	Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн япон хэлний түвшин тогтоох жишиг шалгалт /N1-N5 түвшин/	2024/06/10- 2024/06/17	N1-N5 түвшний жишиг шалгалт /Хэлний мэдлэг-үсэг, үгийн сан, хэлний мэдлэг-дүрэм, уншиж ойлгох чадвар, сонсож ойлгох чадвар/	Э.Эрдэнэцэцэг, Д.Мөнхтуяа, П.Марал, Б.Буманцэцэг, С.Амарбаясгалан	126
14	Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн япон хэлний түвшин тогтоох жишиг шалгалт /N1-N5 түвшин/	2024/10/07- 2024/10/15	N1-N5 түвшний жишиг шалгалт /Хэлний мэдлэг-үсэг, үгийн сан, хэлний мэдлэг-дүрэм, уншиж ойлгох чадвар, сонсож ойлгох чадвар/	П.Марал, О.Булган, Д.Цацрал	61
15	Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн япон хэлний түвшин тогтоох жишиг шалгалт /N1-N5 түвшин/	2024/11/04- 2024/11/08	N1-N5 түвшний жишиг шалгалт /Хэлний мэдлэг-үсэг, үгийн сан, хэлний мэдлэг-дүрэм, уншиж ойлгох чадвар, сонсож ойлгох чадвар/	П.Марал, П.Алтанбулаг, О.Булган, Д.Цацрал	96
16	Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн япон хэлний түвшин тогтоох жишиг шалгалт /N3, N4, N5 түвшин/ *"BNM-MEIRAI" Гадаад хэлний сургалтын төв, Их засаг ОУИС, ХААИС, Логарифм сургууль, Соёл эрдэм ахлах сургууль, Наран сургууль, Номт наран сургуулийн хүсэлтээр	2024/01/17 02/20 03/15 03/20 04/04 04/10 05/01 05/30 06/05 07/22 08/26 10/25 11/14 12/20 14 удаа	JLPT шалгалтын N3, N4, N5 түвшний жишиг шалгалт /Хэлний мэдлэг-үсэг, үгийн сан, хэлний мэдлэг-дүрэм, уншиж ойлгох чадвар, сонсож ойлгох чадвар/	Э.Эрдэнэцэцэг, Д.Мөнхтуяа, П.Алтанбулаг, П.Марал, О.Булган, Б.Буманцэцэг, Д.Цацрал	477



17	Япон хэлний сургалтын тайлангийн хурал	2024/01/24	2023 оны намрын сургалтын тайлан хэлэлцүүлэг, 2024 оны хаврын сургалтын хуваарь нягтлах, мэдээлэл солилцох	Хурал хөтлөгч: П.Марал Хурлын тэмдэглэл хөтлөгч: Күрияма Томоюки Хуралд оролцогчид: Сургалт хариуцсан багш нар	13
18	Япон хэлний сургалтын тайлангийн хурал	2024/05/31	2024 оны хаврын сургалтын тайлан хэлэлцүүлэг, 2024 оны зуны сургалтын хуваарь нягтлах, мэдээлэл солилцох	Хурал хөтлөгч: Э.Эрдэнэцэцэг Хурлын тэмдэглэл хөтлөгч: С.Амарбаясгалан Хуралд оролцогчид: Сургалт хариуцсан багш нар	13
19	Япон хэлний сургалтын тайлангийн хурал	2024/08/30	2024 оны зуны сургалтын тайлан хэлэлцүүлэг, 2024 оны намрын сургалтын хуваарь нягтлах, мэдээлэл солилцох	Хурал хөтлөгч: П.Алтанбулаг Хурлын тэмдэглэл хөтлөгч: О.Булган Хуралд оролцогчид: Сургалт хариуцсан багш нар	7
20	2024 оны хаврын сургалтын өмнөх анги хуваарилах шалгалт	2024/01/12-2024/02/20	Яриа, дүрэм хосолсон цогц сургалт 2-6-гийн элсэлтийн өмнөх анги хуваарилах шалгалт	Д.Мөнхтуяа, П.Марал, О.Булган	55
21	2024 оны намрын сургалтын өмнөх анги хуваарилах шалгалт	2024/09/04-2024/09/24	Яриа, дүрэм хосолсон цогц сургалт 2-6-гийн элсэлтийн өмнөх анги хуваарилах шалгалт	Д.Мөнхтуяа, П.Марал, С.Амарбаясгалан, Д.Цацрал	58
22	Япон хэлний сургалтын тасгийн багш нарт зориулсан заах аргын сургалт, семинар	2024/02/27 03/12 04/09 05/22 06/06 10/23 11/06 11/27 12/19 9 удаа	Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв Япон сангийн хэлний төвийн сургалт хариуцсан багш нарт зориулан япон хэлний боловсрол, заах аргын талаарх мэдлэгээ өргөжүүлэх, харилцан мэдээллээ хуваалцах зорилготой, сурч мэдсэн зүйлээ өөрийн хичээл сургалтад хэрэгжүүлэхэд чиглэсэн сургалт юм.	Цүрүта Ясүюки, Күрияма Томоюки, О.Булган, С.Амарбаясгалан	74



23	Япон сангийн япон хэлний суурь мэдлэгийн шалгалт /JFT-Basic/-ын удирдамж семинар	2024/02/13, 05/29, 08/22, 10/24 4 удаа	JFT-Basic шалгалтын талаарх ерөнхий тайлбар, тестийн зорилго, зорилтот хүмүүс, тестийн хэлбэр, компьютерын дэлгэц дээрх зураглал, түүний бүтэц, түвшний үзүүлэлт, тестийн дүнг хэрхэн харах тухай тайлбар, тестийн ерөнхий загварыг танилцуулах, "Иродори онлайн сургалт"-ын талаарх товч танилцуулга, асуулт хариултын цаг гэсэн агуулгатайгаар зохион байгуулагдсан.	П.Алтанбулаг	117
24	"Иродори хэрэглээний япон хэл" сурах бичгийн 1 удаагийн танилцуулах хичээл	2024/02/16	"Иродори хэрэглээний япон хэл" /Суурь шат, A1 түвшин/ сурах бичгийн 3-р хичээлээр дамжуулан сурах бичгийн онцлог, хэрэглэх арга барил, онлайн сургалттай хэрхэн хослуулан хэрэглэх талаарх ойлголтыг өгсөн.	П.Алтанбулаг	21
25	"Иродори хэрэглээний япон хэл" сурах бичгийг ашигласан заах аргын семинар	2024/01/10- 2024/01/16	"Иродори хэрэглээний япон хэл" сурах бичгийн агуулга, онцлог, заах аргын талаарх үндсэн ойлголтуудыг олгох сургалт. Сургалт нь загвар хичээлд оролцон, хичээлийн талаарх санал сэтгэгдлээ хуваалцах, суралцагчид өөрсдөө сурах бичгийг ашиглан хичээл зааж үзэх, заасан хичээлийнхээ талаар харилцан санал бодлоо солилцох, сургалтын талаарх ерөнхий дүгнэлт хийх гэсэн хэсгүүдээс бүтнэ.	Цүрүта Ясүюки, Сато Кэйичи, П.Алтанбулаг	16
26	"Иродори хэрэглээний япон хэл" сурах бичгийг ашигласан заах аргын семинар	2024/06/12- 2024/06/18	"Иродори хэрэглээний япон хэл" сурах бичгийн агуулга, онцлог, заах аргын талаарх үндсэн ойлголтуудыг олгох сургалт юм. Сургалт нь загвар хичээлд оролцон, хичээлийн талаарх санал сэтгэгдлээ хуваалцах, суралцагчид өөрсдөө сурах бичгийг ашиглан хичээл зааж үзэх, заасан хичээлийнхээ талаар харилцан санал бодлоо солилцох, сургалтын талаарх ерөнхий дүгнэлт хийх гэсэн хэсгүүдээс бүтнэ.	Цүрүта Ясүюки, Күрияма Томоюки, П.Алтанбулаг	11
27	"Иродори хэрэглээний япон хэл" сурах бичгийг ашигласан заах аргын семинар	2024/09/11- 2024/09/17	"Иродори хэрэглээний япон хэл" сурах бичгийн агуулга, онцлог, заах аргын талаарх үндсэн ойлголтуудыг олгох сургалт юм. Сургалт нь загвар хичээлд оролцон, хичээлийн талаарх санал сэтгэгдлээ хуваалцах, суралцагчид өөрсдөө сурах бичгийг ашиглан хичээл зааж үзэх, заасан хичээлийнхээ талаар харилцан санал бодлоо солилцох,	Цүрүта Ясүюки, Күрияма Томоюки, П.Алтанбулаг	13



			сургалтын талаарх ерөнхий дүгнэлт хийх гэсэн хэсгүүдээс бүтнэ.		
28	"Иродори япон хэлний онлайн сургалт"-ын танилцуулах хичээл	2024/02/23 06/05 08/26, 10/29 4 удаа	"Иродори хэрэглээний япон хэл" сурах бичгийг түгээн дэлгэрүүлэх, Япон сангийн япон хэлний суурь мэдлэгийн /JFT-Basic/ шалгалтад тэнцэх Монгол суралцагчдын тоог нэмэгдүүлэхэд туслах зорилгоор "Иродори япон хэлний онлайн сургалт"-ын талаарх ерөнхий ойлголт өгөх, хэрхэн хэрэглэх аргыг сурч, дасгал даалгавар дээр ажиллаж үзсэн.	П.Алтанбулаг	72
29	"Иродори" сурах бичгийн заах арга зүйн туршлага солилцох семинар	2024/12/14	"Иродори хэрэглээний япон хэл" сурах бичгийн ерөнхий бүтэц онцлог, хэрэглэх аргын талаар товч танилцуулсны дараа, сурах бичгийг сургалтдаа амжилттай ашиглаж буй 4 багш өөрсдийн заах арга зүйн туршлага, ололт амжилт, хүндрэл бэрхшээлээсээ хуваалцсан. Үйл ажиллагааны төгсгөлд "Иродори" сурах бичгийг JFT-Basic шалгалттай уялдуулан сургалтдаа хэрхэн үр дүнтэй ашиглах тухай зөвлөмжийг өгсөн.	Илтгэгч: "Жисонкэй" япон хэлний сургалтын төвийн багш Х.Дэлгэрдалай, "Хагеми" боловсролын төвийн багш Н.Цэдэнсодном, МУИС Ази судлалын тэнхмийн багш Ц.Онон, Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн багш Д.Мөнхтуяа, П.Алтанбулаг	33
30	Япон сангийн төсөл хөтөлбөрийн танилцуулах семинар /Япон улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Япон сан, Япон улсын элчин сайдын яам, Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн хамтран зохион байгуулсан шинэ үйл ажиллагаа/	2024/11/12	"Тусгай ур чадварын тогтолцоо"-ны хүрээнд тус төвөөс хэрэгжүүлж буй япон хэлний боловсролын үйл ажиллагаа, "Иродори хэрэглээний япон хэл" сурах бичгийн талаар, Япон улсад ажиллаж амьдрах хүмүүст зориулсан япон хэлний сургалтын байгууллагад үзүүлэх дэмжлэгийн талаар, япон хэлний багш нарын Япон улс дахь сургалт семинарын талаар, Япон сангийн төсөл хөтөлбөрт хамрагдсан байгууллагын туршлагаас, Япон сангийн төсөл хөтөлбөрт бүртгүүлэхэд шаардагдах материал бүрдүүлэлтийн талаар танилцуулсан.	Япон улсын элчин сайдын яамны атташе Морияма Масами, Япон сангийн япон хэлний 2-р хэлтсийн төлөвлөлт хөгжлийн багийн ахлах Аказава Томоки, "Шинтооёобаши" ХХК-ийн захирал Ц.Амгалан, Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн мэргэжилтэн П.Алтанбулаг	107



31	"Япон улсад ажиллаж амьдрахад шаардлагатай мэдээлэл болон японы соёлыг хэрхэн заах тухай" сэдэвт семинар *Шинэ үйл ажиллагаа	2024/06/16	Япон улсад ажиллаж амьдрахыг зорьж буй хүмүүс болон япон хэлний боловсролын байгууллага, япон улсад ажилтан илгээгч байгууллагын багш нарт зориулан японы амьдрал, соёлын талаарх агуулгыг хичээлийн цагт хэрхэн тусгах, хэрхэн заах талаар танилцуулж, хичээлд ашиглах боломжтой гарын авлага, видео бичлэг зэрэг сургалтад шууд нэвтрүүлэх боломжтой хэрэглэгдэхүүнийг танилцуулсан.	Цүрүта Ясүюки	45
32	Япон хэлний заах аргын ганцаарчилсан зөвлөгөө /G&D Development ХХК-ийн харъяа "Мика Монгол" сургалтын төв, Глобал Траст Нэтворкс ХХК-ийн харъяа "GTN" Япон хэлний сургалтын төв/	2024/03/17	Сургалтын үйл ажиллагаа, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, заах арга зүйн талаар ярилцсан.	Мацүмото Такэши /Япон сан/, Цүрүта Ясүюки, Күрияма Томоюки, П.Алтанбулаг /Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв/	2
33	Япон хэлний заах аргын ганцаарчилсан зөвлөгөө /МУИС Ази судлалын тэнхим/	2024/03/19	"Иродори хэрэглээний япон хэл" сурах бичгийг япон хэлний анхан шатны яриа болон сонсох чадварыг ахиулах сургалтад ашиглан зааж буй багшийн хичээлд сууж, хичээлийн талаар заавар зөвлөгөө өгсөн.	Цүрүта Ясүюки, П.Алтанбулаг	1
34	Япон хэлний заах аргын ганцаарчилсан зөвлөгөө /Дорноговь аймгийн Сайншанд хот, "B&T" Япон хэлний сургалтын төв/	2024/04/06	Сургалтын төвийн үйл ажиллагаатай танилцан, сурах бичгийн сонголт болон JLPT буюу япон хэлний түвшин тогтоох шалгалтад бэлтгэх ганцаарчилсан сургалтыг хэрхэн үр дүнтэй явуулах талаар ярилцсан.	П.Алтанбулаг	1
35	Япон хэлний заах аргын ганцаарчилсан зөвлөгөө /МУБИС-д харьяалагдаж буй ЖАЙКА-ийн сайн дурын ажилтан/	2024/06/26	Их сургуулийн япон хэлний шалгалт болон үнэлгээний талаар заавар зөвлөгөө өгч ярилцсан.	Цүрүта Ясүюки	1
36	Япон хэлний заах аргын ганцаарчилсан зөвлөгөө /Нийслэлийн ерөнхий боловсролын 32 дугаар сургууль /	2024/07/04	Бага ангийн сонгон судлах хичээлийн хүрээнд үзэх япон хэлний сургалтын хөтөлбөрийг хэрхэн боловсруулах, сурах бичгийг хэрхэн сонгох талаар ярилцаж, "Дэкирүмон" сурах бичгээр боловсруулсан загвар сургалтын хөтөлбөрийг харуулж зөвлөгөө өгөн ярилцав.	Цүрүта Ясүюки, П.Алтанбулаг	1
37	Япон хэлний заах аргын ганцаарчилсан зөвлөгөө /"Түшиг цүёоши" Япон хэлний сургалтын төв/	2024/11/28	"Иродори хэрэглээний япон хэл" сурах бичгийн давуу тал, заах аргын талаар, сурах бичгийг ашиглан хэрхэн сургалтын хөтөлбөр боловсруулах талаар, JLPT буюу япон хэлний түвшин тогтоох шалгалттай хэрхэн уялдуулан заах талаар, JFT-Basic	Цүрүта Ясүюки, П.Алтанбулаг	4



			шалгалтын талаар тус тус заавар зөвлөгөө өгсөн.		
38	"Bridge to Dornogobi" ОУ-ын боловсролын үзэсгэлэн дэх сургалт, үйл ажиллагааны танилцуулах булан	2024/04/04-2024/04/06	Япон улсад суралцах талаар, Япон улсын засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийн талаар, япон хэлний сургалт, шалгалтуудын талаар танилцуулж, заавар зөвлөгөө өгсөн.	П.Алтанбулаг	154
39	Хаврын "Японд суралцах тухай мэдээллийн яармаг 2024" дэх сургалт, үйл ажиллагааны танилцуулах булан	2024/04/20	Япон хэлний сургалт болон шалгалтуудын талаар танилцуулж, заавар зөвлөгөө өгсөн.	П.Алтанбулаг, П.Марал	100
					2691

Хүснэгт-14: Бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан үйл ажиллагаа

№	Үйл ажиллагааны нэр	Хугацаа	Агуулга	Илтгэгч болон хариуцсан багш	Оролцогчдын тоо
1	Монголын япон хэлний сургалт судалгааны холбооны 119 дэх удаагийн хурал /Монголын япон хэлний багш нарын холбоотой хамтарсан үйл ажиллагаа/	2024/01/20	Илтгэлийн сэдэв: 1) "Ярианы дасгалын дараах үнэлгээ болон дүгнэлтийг идэвхтэй аргаар явуулах боломжийн талаар" 2) "Япон хэлний уран илтгэлийн тэмцээн-10 жил"	Илтгэгч: 1) П.Марал /Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн япон хэлний багш/ 2) Л.Жавзандулам /Монгол-Японы Залуучуудын Хамтын Ажиллагааг Дэмжих Төвийн захирал/	13
2	Монголын япон хэлний сургалт судалгааны холбооны 120 дахь удаагийн хурал /Монголын япон хэлний багш нарын холбоотой хамтарсан үйл ажиллагаа/	2024/02/27	Илтгэлийн сэдэв: 1) "「雨は「降りそうにない」? 「降らなそう」? 「降らなさそう」? -Корпус ашиглан эргэцүүлэх нь-" 2) "Сонсогч, уншигчийг мэдэрч ухамсарласан сурах үйл ажиллагаа"	Илтгэгч: 1) Маки Күмиго /Нагояагийн ИС, Японы эрх зүйн боловсрол, судалгааны төвийн япон хэлний багш/ 2) Йо Юкико /Нагояагийн ИС, Японы эрх зүйн боловсрол, судалгааны төвийн япон хэлний мэргэжилтэн багш/	23
3	Монголын япон хэлний сургалт судалгааны холбооны 121 дэх удаагийн хурал /Монголын япон хэлний	2024/03/16	Илтгэлийн сэдэв: 1) "Хирагана үсгийг мнемоник аргаар заах нь" 2) "Дунд сургуульд япон хэлийг гуравдагч хэл болгон заах нь"	Илтгэгч: 1) Б.Үүрийнтуяа /"Хобби" сургуулийн япон хэлний багш/	23



	багш нарын холбоотой хамтарсан үйл ажиллагаа/			2) Д.Дэлгэрсүрэн /"Сэлбэ"сургуулийн япон хэлний багш/	
4	Монголын япон хэлний сургалт судалгааны холбооны 122 дахь удаагийн хурал /Монголын япон хэлний багш нарын холбоотой хамтарсан үйл ажиллагаа/	2024/04/15	Илтгэлийн сэдэв: 1) "МУИС дахь япон хэлний ярианы клубийн үйл ажиллагаа" 2) "MUDIE Multi Dimensional Education System буюу олон хэмжээст боловсролын систем ашиглан анхан шатны япон хэлийг заах нь"	Илтгэгч: 1) Аракава Ёшиэ /МУИС-д харьяалагдаж буй ЖАЙКА-ийн сайн дурын гишүүн багш/ 2) У.Анударь /"Наго Улаанбаатар" сургалтын төвийн япон хэлний багш/	19
5	Монголын япон хэлний сургалт судалгааны холбооны 123 дахь удаагийн хурал /Монголын япон хэлний багш нарын холбоотой хамтарсан үйл ажиллагаа/	2024/05/20	Илтгэлийн сэдэв: "МЯХБХ-ны жилийн үйл ажиллагааны тухай" /2023 оны 6 сараас 2024 оны 5 сар хүртэлх үйл ажиллагааны тайлан, асуулт хариулт/	Илтгэгч: Э.Батжаргал /МЯХБХ-ны тэргүүн/	14
6	Монголын япон хэлний сургалт судалгааны холбооны 124 дэх удаагийн хурал /Монголын япон хэлний багш нарын холбоотой хамтарсан үйл ажиллагаа/	2024/09/21	Илтгэлийн сэдэв: 1) ""Боосай" карт ашиглан Ховд аймгийн сурагчдын гамшгаас сэргийлэх мэдлэгийг дээшлүүлсэн нь" 2) "МЯХБХ-ны энэ жилийн төлөвлөгөө"	Илтгэгч: 1) Б.Нармандах /МЯХБХ-ны ажилтан/ 2) Э.Батжаргал /МЯХБХ-ны тэргүүн/	24
7	Монголын япон хэлний сургалт судалгааны холбооны 125 дахь удаагийн хурал /Монголын япон хэлний багш нарын холбоотой хамтарсан үйл ажиллагаа/	2024/10/19	Илтгэлийн сэдэв: "8-10 насны хүүхдэд зориулсан япон хэлний сургалтын тухай"	Илтгэгч: П.Марал /Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн япон хэлний багш/	18
8	Монголын япон хэлний сургалт судалгааны холбооны 126 дахь удаагийн хурал /Монголын япон хэлний багш нарын холбоотой хамтарсан үйл ажиллагаа/	2024/11/23	Илтгэлийн сэдэв: 1) "Япон хэлний өгөх, авах утгат туслах үйл үгийг эзэмших судалгаа -Япон хэл сурч буй монгол оюутнуудын жишээгээр" 2) "8 дахь удаагийн ханзны наадам"-ын талаарх тайлан	Илтгэгч: 1) Улаан /МУБИС-ийн докторант/ 2) Б.Гэрэлмаа /Шинэ Монгол сургуулийн япон хэлний багш/	16
9	Монголын япон хэлний сургалт судалгааны холбооны 127 дахь удаагийн хурал /Монголын япон хэлний багш нарын холбоотой хамтарсан үйл ажиллагаа/	2024/12/21	Илтгэлийн сэдэв: 1) "Техникийн коллежийн оюутнуудын бичил судалгааны тухай" 2) "Мэдээлэл технологийн хэрэгслийг ямар хичээлд ашиглаж болох вэ?"	Илтгэгч: 1) Сакураи Чиёко /Монголын Технологийн Коллежийн Үндэсний Холбоо: Жайкагийн сайн дурын гишүүн багш/ 2) Мацүо Фүми /МУБИС-д харьяалагдаж буй	15



				ЖАЙКА-ийн сайн дурын гишүүн багш/	
10	"Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 30 дахь удаагийн тэмцээн"-ий 1-р шатны шалгаруулалт /Зохион бичлэг/	2024/10/26	Тэмцээнд оролцохоор зохион бичлэгээ ирүүлсэн ахлах ангийн 46 сурагчаас 21 сурагч, их дээд сургуулийн 16 оюутнаас 13 оюутан зохион бичлэгийн сонгон шалгаруулалтад тэнцсэн. Зохион бичлэгийн сэдэв: Ахлах ангийн ангилал: "Өөрийгөө сорьж үзмээр байгаа зүйл", оюутны ангилал: "Хариуцлага"	Тэмцээний зохион байгуулах комисс	34
11	"Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 30 дахь удаагийн тэмцээн"-ий 2-р шатны шалгаруулалт /Ярилцлагын шалгалт/	2024/11/02	Зохион бичлэгийн сонгон шалгаруулалтаас тунаж үлдсэн ахлах ангийн 16 сурагч, их дээд сургуулийн 13 оюутнаас ярилцлагын шалгалт авч, ахлах ангийн 10 сурагч, их дээд сургуулийн 8 оюутан төгсгөлийн шалгаруулалт болох илтгэлийн тэмцээнд оролцохоор болсон.	Тэмцээний зохион байгуулах комисс	34
12	"Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 30 дахь удаагийн тэмцээн"-ий өмнөх бэлтгэл	2024/11/14	Тэмцээний өмнөх бэлтгэл	Тэмцээний зохион байгуулах комисс	25
13	"Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 30 дахь удаагийн тэмцээн" /Хамтран зохион байгуулагч: Япон улсын элчин сайдын яам, Монголын япон хэлний багш нарын холбоо, ШУТИС-ийн Гадаад хэлний институт, Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв, Япон сан Дэмжигч: Монгол дахь япончуудын холбоо, Монгол Японы худалдааны танхим/	2024/11/16	Зохион бичлэг болон ярилцлагын шалгалтын дүнгээр тунаж үлдсэн ахлах ангийн 10 сурагч, их дээд сургуулийн 8 оюутан илтгэл тавьсан. Илтгэлийн сэдэв: Ахлах ангийн ангилал: "Өөрийгөө сорьж үзмээр байгаа зүйл", оюутны ангилал: "Хариуцлага"	Тэмцээний зохион байгуулах комисс	113



14	"2024 оны Нийгата мужийн нэрэмжит япон хэлний уран илтгэлийн тэмцээн"-ий өмнөх бэлтгэл	2024/09/28	Тэмцээний өмнөх бэлтгэл	Тэмцээний зохион байгуулах комисс	8
15	"2024 оны Нийгата мужийн нэрэмжит япон хэлний уран илтгэлийн тэмцээн"	2024/09/28	Их дээд сургуулийн 8 оюутан "Японы сэтгэл татам байдал - Миний бодлоор" сэдвээр илтгэл тавьсан.	Тэмцээний зохион байгуулах комисс	53
					432


Хүснэгт-15: Япон хэлний сургалтад хамрагдсан суралцагчдын тоо

	2023 он	2024 он
Хаврын сургалт	205	237
Зуны сургалт	120	139
Намрын сургалт	212	228
Нийт	537	604




Хүснэгт-5: Тусгай сургалтад хамрагдсан хүний тоо

	2023 он	2024 он
Тусгай сургалт	1,190	2,691



Хүснэгт-6: Бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцсон хүний тоо

	2023 он	2024 он
Хамтарсан үйл ажиллагаа	574	432





II. ОНЦЛОХ МЭДЭЭ

1. 8-10 насны хүүхдэд зориулсан япон хэлний сургалт

Энэхүү сургалт нь япон хэлийг сонирхон суралцахыг хүсэж буй хүүхдүүд болон хүүхдээ япон хэлний сургалтад хамруулах хүсэлтэй эцэг эх, асран хамгаалагчдын хэрэгцээ шаардлагад тулгуурлан жил бүр зохион байгуулагддаг билээ.

Сургалтад япон хэлийг эхнээс нь системтэйгээр суралцахыг хүссэн хүүхдүүд хамрагддаг ба сургалтын агуулгын хувьд “хирагана” үсгээр уншиж бичиж чаддаг болохын сацуу өөрт ойр сэдвийн хүрээнд япон хэлээр өөрийгөө илэрхийлэх чадварыг эзэмшүүлэх зорилготой юм.

Хүүхдийн сургалт 07 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн 08 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл явагдаж, нийт 16 хүүхэд 20 удаагийн 30 цагийн сургалтыг амжилттай суралцан төгслөө.

Монгол-Японы төвийн үндсэн сургалтуудтай харьцуулахад тус сургалт нь хүүхдийн анхаарал татахуйц хөгжөөнт тоглоом бүхий дасгал даалгаврыг боловсруулан бэлдэж, сургалтын орчин, идэвхтэй арга барилыг түлхүү баримтлан жил бүр шинэчлэгдэж байдгаараа онцлогтой. Энэ жилийн хувьд завсарлагааны цагийг үр ашигтай өнгөрүүлэхэд онцгой анхаарсан. Хирагана үсэг, нинжагийн зурагт үзүүлэн зэрэг япон хэл соёлтой холбогдох материалуудыг хэвлэн бэлтгэж ангийн эргэн тойрны самбарт байршуулснаар завсарлагааны цаг нь хамтдаа будах, зурах зэргээр хөгжилдөх цаг болон хувирсан юм. Мөн япон үндэсний тоглоом наадгайн соёлоос танилцуулах зорилгоор хичээл бүрийн өмнө “кэндама”, “комамаваши”, “дарүма отоши” зэрэг тоглоомуудыг бэлтгэн тавьж чөлөөт цагаараа тоглох буланг гаргав.

Жил бүрийн суралцагч хүүхдүүдэд зөвхөн хэлний мэдлэг олгох бус япон соёлыг ч мөн сонирхон суралцуулах зорилгоор 2 удаагийн соёлын танилцуулга хичээл ордог. Энэ жил шинээр “сүибокүга” буюу японы үндэсний бийрэн бичлэгийн соёлоос танилцуулан хамтдаа зурж, бүтээлийн үзэсгэлэн гаргаж, хичээлийн төгсгөлд оригамигаар хүүхэлдэй хийж сурлаа.

Дахин нэг онцлууштай зүйл нь энэ жил сургалтын хүрээнд япон хүмүүстэй уулзаж, сурсан мэдсэнээ ашиглан ярьж үзэх боломж олонтоо тохиосон явдал юм. “Япон фестиваль Монголд-2024” арга хэмжээнд оролцсон японы залуу уран бүтээлчид тус төвөөр айлчлах үеэр хүүхдүүдтэй хамт оригамигаар цаасан хүүхэлдэй хийж, япон соёлоос танилцуулав. Мөн ЖАЙКА /Японы олон улсын хамтын ажиллагааны



байгууллага/-гийн хилийн чанад дахь багш нарын дадлага сургалтаар Монголд ирсэн 8 багш тус төвд айлчлах үеэр хүүхдийн сургалтын хичээлийн явцтай танилцан, хүүхдүүдтэй хөгжилтэй яриа өрнүүллээ.

Эдгээр үйл ажиллагааны үр дүнд энэ жилийн суралцагч хүүхдүүд болон эцэг эх, асран хамгаалагчид илүү сэтгэл хангалуун сургалтаа өндөрлүүлсэн болов уу хэмээн найдаж байна. Мөн тус сургалтад хамрагдсан хүүхдүүд маань цаашдаа ч япон хэл, соёлыг шамдан суралцаж, дараагийн шатны япон хэлний сургалтад үргэлжлүүлэн суралцахаар ирэх өдрийг тэсэн ядан хүлээж байна.



Зураг 21. “8-10 насны хүүхдэд зориулсан япон хэлний сургалт”



2. “PPT-д суурилсан япон хэлний сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах арга зүй” практик сургалт

Энэхүү сургалт нь 2024 онд шинээр төлөвлөж зохион байгуулсан сургалтуудын нэг бөгөөд япон хэлний багш нарт зориулж заах аргын ур чадвараа нэмэгдүүлэхэд туслах зорилгоор явуулсан сургалт юм. Сүүлийн жилүүдэд Монгол дахь япон хэлний боловсролын салбарт ч мөн PPT ашигласан практик хичээлүүд нэмэгдэх болсон бөгөөд PPT хэрэглэгдэхүүн бэлтгэх нь япон хэлний багш нарын хувьд чухал чадваруудын нэг болоод байна. Иймд тус сургалтаар япон хэлний хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэхэд шаардагдах PPT-ийн хялбар функц, техникүүдээс гадна яриа, дүрэм, үсэг, үгийн сан зэрэг хичээл тус бүрийн онцлогт тохирсон PPT хэрэглэгдэхүүн бэлтгэх агуулгыг багтааснаараа онцлог юм.

Сургалтын хугацааг төлөвлөхдөө хичээлийн шинэ жил эхлэхийн өмнөх, багш нарын оролцоход хялбар хийгээд мэргэжлийн ур чадвараа нэмэгдүүлэх идэвхтэй үеийг сонгож, 08 сарын 13-аас 08 сарын 20 хүртэл нийт 6 удаагийн 18 цагийн сургалтыг зохион байгуулсан юм.

Сургалтад нийт 11 хүн хамрагдсан бөгөөд заах аргын туршлагатай, ирээдүйд япон хэлний багш болох хүсэлтэй, PPT-ийн талаар мэдлэгтэй, түүнийгээ ашиглаж чаддаг, компьютер бараг ашиглаж үзээгүй гээд олон төрлийн хүн хамрагдсан билээ. Сургалтын төгсгөлд нийт 11 суралцагчаас 10 нь амжилттай төгссөн бөгөөд 1 суралцагч ирцийн хувь нь шаардлагын түвшинд хүрээгүй тул төгсөж чадаагүй юм.

Тус сургалтын эхний 4 удаагийн хичээлээр PPT ашигласан хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэх талаар танилцуулж, суралцагчдыг өөрсдийн компьютер дээр дадлага хийлгэх хэлбэрээр зохион байгуулсан. Үлдсэн 2 удаагийн хичээлээр өмнөх хичээлүүд дээр сурсан агуулгаар PPT хэрэглэгдэхүүн боловсруулж дадлага хичээл заалгасан юм. Суралцагчдад цаашид хэрэглэгдэх боломжтой PPT хэрэглэгдэхүүн боловсруулах даалгавар өгч, түүгээр нь дадлага хичээл заалгасан тул практик дээр ашиглаж болохуйц олон зүйлийг олж анзаарсан гэдэгт итгэлтэй байна. Нөгөөтэйгөөр, суралцагчдын япон хэлний заах аргын туршлага болон PPT ашиглах ур чадварын зөрүү их байсан тул суралцагчдад хүндрэлтэй, бэрхшээлтэй зүйл ч бас байсан болов уу. Иймд дараагийн удаа аль болох суралцагчдад хүндрэл, бэрхшээл багатай байхаар сургалтын агуулгыг сайжруулах шаардлага тулгарч байна.



Энэ удаагийн сургалтад 11 суралцагчийн 6 нь ЕБС-ийн япон хэлний багш байсан бөгөөд Монголын япон хэлний багш нарын холбооноос ЕБС-ийн япон хэлний багш нарыг дэмжих зорилгоор тэдгээр 6 суралцагчийн төлбөрийг 100% даасан билээ. Энэ дашрамд япон хэлний багш нарын хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулж, хамтран ажилласан Монголын япон хэлний багш нарын холбоонд гүн талархал илэрхийлье.



Зураг 22. “PPT-д суурилсан япон хэлний сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах арга зүй практик сургалт ”

3. “Япон хэлний дунд түвшний суралцагчдын уншиж ойлгох чадварыг ахиулах сургалт”

Япон хэлний дунд түвшний суралцагчдын /Япон хэлний түвшин тогтоох шалгалтын N2, N1 түвшин орчим/ уншиж ойлгох чадварыг ахиулах зорилготойгоор нийт 8 удаа, 16 цагийн шинэ сургалтыг зохион байгуулсан бөгөөд бүх суралцагчид амжилттай суралцан төгслөө. Суралцагчдын хувьд ахлах сургуулийн сурагч, их дээд сургуулийн оюутан, төрийн албан хаагч, компанийн ажилтан зэрэг өргөн цар хүрээтэй байв.

Сургалтын эхний 3 хичээл нь уншиж ойлгоход шаардлагатай үндсэн чадваруудыг эзэмшүүлэхийн тулд лекц болон дасгалууд дээр ажилласан. Тухайлбал, “хичээл” болон “шалгалт”-ын ялгаа, зөв хариултыг сонгох даалгавар бүхий шалгалтын материалын онцлог, шалгалтаар үнэлэхийг зорьж буй чадвар, уншиж ойлгоход шаардлагатай хийсвэрлэн бодох чадвар, логик сэтгэлгээний чадвар, харьцуулалт зэрэг агуулгыг үзэж судалсан. 4 дэх хичээлээс “Япон хэлний түвшин тогтоох албан ёсны шалгалт”-ын эмхэтгэл /2-р эмхэтгэл/-ээс N2, N1 түвшний асуултын материалыг ашиглан даалгавар тус бүр дээр ажилласан.

Сургалтын үед N3 түвшний суралцагчид N1 түвшний шалгалтын материалыг ажиллахад зориулан, бодит шалгалтын материалыг хялбаршуулан бэлдсэн бөгөөд ингэснээр N3 түвшинтэй суралцагчид асуудалгүйгээр тус сургалтад оролцож чадсан



болов уу хэмээн найдаж байна. Харин хамтран суралцах болон багаар суралцах ажлыг хангалттай хийж чадаагүй тул цаашид анхаарах шаардлагатай хэмээн үзэж байна. Насаар залуу суралцагчдын хувьд багаар суралцах хэсэгт идэвхтэй оролцохгүй байдал ажиглагдсан тул баг болгон хуваарилахад нэлээд бодох шаардлага гарч байв. Сургалтын үеэр багийн ажил дутмаг үед хичээл нэг талыг барьсан аргачлалтай болох эрсдэлтэй учир цаашид суралцагч хоорондоо харилцан суралцах боломж, орчныг бүрдүүлэх тал дээр анхаарах шаардлагатай хэмээн үзлээ.

Төгсгөлд нь хэлэхэд, Монголын япон хэлний багш нарын холбооноос сургалтад хамрагдсан ЕБС-ийн япон хэлний багш нарт сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлсэн явдалд тус төвийн зүгээс гүн талархал илэрхийлж байна.


4. “Япон соёлтой танилцацгаая” тусгай сургалт

Тус төвийн “Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт”-ын нэгэн том онцлог бол япон соёлын танилцуулах хичээл байдаг. Энэ онд энэхүү япон соёлын танилцуулах хичээлийг тус төвийн япон хэлний сургалтын суралцагчид төдийгүй япон хэл, соёлыг сонирхож буй хэн бүхэнд нээлттэйгээр тусгай сургалт болгон үйл ажиллагаандаа нэвтрүүлээ.

Энэхүү тусгай хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн ерөнхий боловсролын 115 дугаар сургуулийн “Зд” ангийн хамт олон “Хөвгүүдийн баяр”, “Хамтдаа урлацгаая” охидын өдөрлөг, “Японы үндэсний тоглоом наадгай” гэсэн 3 төрлийн үйл ажиллагаанд хамрагдахын сацуу тус төвийн номын сантай танилцан зочиллоо. Охид зориулалтын бэлдцээс дуртай өнгөө сонгон өөртөө “Камиказари” буюу үсний гоёл урлаж, японы цаасан нугалбар болох оригами нугалан, чамин номын хавчуурга хийнгээ юмхнаар юм хийх ухааны тухай бяцхан яриа өрнүүлэв. Түүнчлэн анги хамт олноороо япон үндэсний тоглоом наадгай болох кэндама, дарүма отоши, тон тон зүмо, нинжягийн шүрикэн, комамаваши зэргээр наадангаа тоглоом тус бүрийн онцлог, ач холбогдлын талаар ярилцаж, цагийг хамтдаа хөгжилтэй бөгөөд сонирхолтой өнгөрүүлсэн болно. Үйл ажиллагааны үеэр хүүхдүүд хөдөлгөөний дутагдал, стресс ядаргаа, анхаарал төвлөрөл, биеийн тэнцвэртэй байдал, тэсвэр тэвчээрийн талаар олон сонирхолтой яриа өрнүүлж байсан нь насандаа баймгүй хэрсүү хэр нь хайр татам байлаа. Энэхүү тусгай хөтөлбөрөөр дамжуулан анги хамт олноороо өөр соёл орчинтой танилцан, шинэ



туршлага хуримтлуулж, бага ч болтугай танин мэдэхүйгээ тэлж чадсан байх хэмээн найдаж байна.



Зураг 23. “Япон соёлтой танилцаагаар тусгай сургалт”

5. Гэрээт сургалт, үйл ажиллагааны талаар

“Тусгай үр чадварын тогтолцоо” гэрээт ажлын хүрээнд

Тус төв нь Япон сантай байгуулсан гэрээний дагуу 2019 оноос эхлэн “Тусгай үр чадвартай ажилтан тогтолцоо”-г сурталчлан таниулах, ялангуяа тус тогтолцоотой хамаарах Монгол дахь япон хэлний боловсролыг дэмжин ажиллаж ирлээ. Гэрээт ажлын хэрэгжилтийн хүрээнд дараах 3 гол чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

1. Япон сангийн япон хэлний суурь мэдлэгийн шалгалт (JFT-Basic)-тай хамаарах ажил
2. Япон хэлний багш нарыг дэмжих үйл ажиллагаа
3. Япон хэлний сургалтын төв болон Япон улс руу ажилтан илгээгч байгууллагад хандсан судалгаа, зөвлөгөө

1. Япон сангийн япон хэлний суурь мэдлэгийн шалгалт (JFT-Basic)-тай хамаарах ажил

Нэн тэргүүнд JFT-Basic шалгалтыг олон нийтэд таниулж, шалгалтад хамрагдах болон улмаар тэнцсэн хүмүүсийн тоог нэмэгдүүлэхийн тулд JFT-Basic шалгалтын хуваарийг тогтмол зарлах зэргээр тус шалгалттай холбоотой мэдээллийг цаг тухайд нь хүргэж ажиллалаа. Мөн JFT-Basic шалгалтын удирдамж семинарыг 4 удаа зохион байгуулж 117 хүнд шалгалтын талаарх ерөнхий ойлголтыг өгч, шалгалтад бүртгүүлэх аргачлал, бэлдэх аргачлалаас танилцуулсан юм. Мөн үйл ажиллагааны хүрээнд “Иродори япон хэлний онлайн курс”-ийн танилцуулах хичээлийг 4 удаа зохион байгуулж, 72 хүнд онлайн сургалтын платформыг танилцуулахын зэрэгцээ бүх



оролцогчид компьютер ашиглан онлайн курст бүртгэл үүсгэн бодитоор дасгал ажиллалаа.

2. Япон хэлний багш нарыг дэмжих үйл ажиллагаа

Япон хэлний багш нарыг дэмжих үйл ажиллагааны хүрээнд “Иродори” сурах бичиг болон япон соёл, зан заншилтай холбоотой заах арга зүйг дэлгэрүүлэх, заах аргын туршлагаа хуваалцах зорилготой семинарыг зохион байгуулж байна. Үүнд:

- 1) “Иродори заах арга зүйн туршлага солилцох семинар”-ыг 3 удаа зохион байгуулж, нийт 40 хүнд “Иродори” сурах бичгийн заах арга зүйн үндсэн ойлголтыг өгч, суралцагчдаар загвар хичээлийг заалгав.
- 2) Япон хэлний багш нарт зориулан “Иродори” сурах бичгийн танилцуулах хичээлийг 2 сард зохион байгуулж, 21 багш оролцлоо.
- 3) “Япон улсад ажиллаж амьдрахад шаардлагатай мэдээлэл болон японы соёлыг хэрхэн заах тухай” сэдэвт семинарыг 3 сард зохион байгуулж, нийт 45 хүн хамрагдлаа.

Түүнээс гадна “Иродори сурах бичгийн заах арга зүйн туршлага солилцох семинар”-ыг 12 сард зохион байгуулж, 4 байгууллагын япон хэлний багш нарын туршлагаас нийт 33 оролцогчдод хүргэлээ. Түүнчлэн Япон сан, Япон улсын элчин сайдын яамтай хамтран япон хэлний сургалтын төвүүд болон япон руу ажилтан илгээгч байгууллагад зориулан “Япон сангийн төсөл хөтөлбөрийн танилцуулах семинар”-ыг 11 сард зохион байгуулж, нийт 107 хүнд Япон сангийн төсөл хөтөлбөрт хэрхэн бүртгүүлэх тухай, бүртгүүлэхэд шаардагдах материалын талаарх мэдээллийг хүргэлээ.

3. Япон хэлний сургалтын төв болон Япон улс руу ажилтан илгээгч байгууллагад хандсан судалгаа, зөвлөгөө

Япон хэлний боловсролын байгууллагуудын бүртгэл жагсаалтыг шинэчлэхийн сацуу бүртгэлтэй байгууллагууддаа хандан “тусгай ур чадварын тогтолцоо”-той холбоо хамаарал бүхий үйл ажиллагаа болон япон хэлний боловсролын чиглэлийн үйл ажиллагаа, Япон сангийн төсөл хөтөлбөрийн талаарх мэдээллийг тасралтгүй хүргэж ажиллалаа. Улмаар 6 байгууллагад хандан ганцаарчилсан зөвлөгөөг хүргэсэн болно.



“2024 оны Нийгата мужийн нэрэмжит япон хэлний уран илтгэлийн тэмцээн”

Нийгата мужийн нэрэмжит “Япон хэлний уран илтгэлийн тэмцээн” нь 2024 оны 09 сарын 28-ны Бямба гарагт амжилттай зохион байгуулагдлаа. Тус тэмцээн нь япон хэлийг сонирхон суралцаж буй их дээд сургуулийн оюутан залуусыг дэмжих, тэдэнд Нийгата мужийг танилцуулах зорилгоор 2 жил тутамд зохион байгуулагддаг бөгөөд Монгол дахь япон хэлний боловсролын хөгжил төдийгүй Монгол улс болон Нийгата муж хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулж буй үйл ажиллагаа билээ.

Тэмцээний ерөнхий зохион байгуулагчаар Нийгата мужийн Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, хамтран зохион байгуулагчаар Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв, Монгол-Нийгатагийн хамтын ажиллагааны нийгэмлэг, дэмжигч байгууллагаар Япон улсын элчин сайдын яам, ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Нийгата-Монголын найрамдлын нийгэмлэгүүд тус тус хамтран ажиллалаа.

Энэ оны хувьд “Япон орны сэтгэл татам байдал-Миний бодлоор” гэсэн сэдвийн хүрээнд зохион байгуулагдсан бөгөөд 5 их сургуулийн нийт 8 оюутан амжилттай оролцож, шилдгийн шилдгээр шалгарсан 3 оюутан Нийгата мужаар аялах эрхийн бичгээр шагнагдлаа. Мөн “MJ AGRITECH” ХХК-ийн зүгээс тэмцээний бүх оролцогчдод шагнал гардуулж, оюутан залуусыг урамшууллаа.

Уран илтгэлийн тэмцээнийг танхим болон цахим /Facebook live/ хосолсон хэлбэрээр зохион байгуулж, танхимаар нийт 53 хүн, шууд дамжуулалтаар 28 хүн үзжээ. Тэмцээний шууд дамжуулалтын бичлэгийг 2024 оны 09 сарын 30-ны өдрийн 9 цагийн байдлаар 1881 удаа үзэж сонирхсон байсан бөгөөд одоо ч гэсэн нийтэд нээлттэйгээр тус төвийн фейсбүүк пэйж хуудсанд байршиж байгаа тул сонирхсон хүн доорх линкээр орж үзнэ үү.

<https://www.facebook.com/MoJCenter/videos/487990520882470>

“Монгол дахь JDS хөтөлбөрийн оюутнуудад зориулсан япон хэлний анхан шатны бэлтгэл сургалт”

Тус сургалтыг 2021 оноос эхлэн жил бүр гэрээгээр хүлээн авч зохион байгуулж байгаа бөгөөд 2024 онд 4 дэх удаагаа амжилттай зохион байгууллаа. Энэ удаад 04 сарын 15-ны өдрөөс 06 сарын 21-ний өдөр хүртэлх 2 сарын хугацаанд нийт 30 удаагийн 60 цагийн эрчимжүүлсэн хөтөлбөрөөр зохион байгуулав. Суралцагчдын хувьд “Хүний нөөцийг хөгжүүлэх JDS тэтгэлэгт хөтөлбөр”-т тэнцэж, Япон улсын их сургуульд магистрын зэрэг горилохоор суралцах болсон 14 хүн байсан. Энэ оны хувьд өмнөх жилийн нэгэн адилаар “Иродори хэрэглээний япон хэл” /суурь шат A1 түвшин/ сурах



бичгийг ашиглан зохион байгуулсан бөгөөд өмнөх жилтэй харьцуулахад сургалтын цаг багассантай холбоотойгоор сурах бичгийн зарим сэдвийг хасах, агуулгаас танах маягаар хөтөлбөрийг боловсрууллаа.

Сургалтын явцад “Японы бийрэн бичлэг”-ийн урлагаас танилцуулах хичээлийг зохион байгуулсан бол, сургалтын төгсгөлд “Япон хэлээр ярилцацгаая” арга хэмжээг сайн дурын япон хүмүүстэй хамтран зохион байгуулсан юм.

Суралцагчид бүгд сургалтаа амжилттай төгсөж, 2024 оны зун Япон улс руу эрдмийн аянд мордсон билээ.

“Киотогийн их сургуульд элсэн орохын өмнөх япон хэлний бэлтгэл сургалт-2024”

Энэхүү сургалтыг 2020 оноос эхлэн жил бүр гэрээгээр зохион байгуулж байгаа бөгөөд 2024 онд 5 дахь удаагаа амжилттай зохион байгуулав. Энэхүү сургалт нь Киотогийн их сургуулийн олон улсын бакалаврын хөтөлбөр /Kyoto University International Undergraduate Program (Kyoto iUP)/-т тэнцсэн оюутанд зориулан, тухайн оюутны хөтөлбөрт тэнцсэн цаг үеэс Японд очиж суралцах хүртэлх хугацаанд явуулж буй япон хэлний бэлтгэл сургалт юм. Сургалт 2024 оны 06 сарын 17-ны өдрөөс 08 сарын 14-ний өдөр хүртэл нийт 22 удаа 67 цагаар зохион байгуулагдсан бөгөөд өнгөрсөн жилүүдийн нэгэн адил сургалтыг ганцаарчилсан хэлбэрээр явуулж, суралцагчийн түвшинд тохируулан япон хэлний суурь шатны агуулгыг заасан юм. Үндсэн сурах бичгээр “Марүгото япон хэл ба соёл” /анхан шат A1 түвшин/ сурах бичгийг сонгон ашиглаж, суралцагчид зориулсан сургалтын хөтөлбөрийг боловсруулан ажилласан бөгөөд түүний үр дүнд суралцагч маань өндөр үнэлгээтэйгээр сургалтаа амжилттай төгсөж чадсан юм.

“Япон хэлтэй аяллын хөтөч-тайлбарлагчдад зориулсан ахисан түвшний сургалт”

Энэхүү сургалтыг “Н & А Friendship” ХХК /Эйч ба Эй андуудын нөхөрлөл ХХК/-ийн ивээн тэтгэлгээр 2024 онд анх удаа зохион байгууллаа. Сургалт 02 сарын 19-ний өдрөөс 03 сарын 23-ны өдрийг хүртэл нийт 15 удаа, 37 цагаар хичээллэлээ. Тус төв “Япон хэлтэй аяллын хөтөч-тайлбарлагч бэлтгэх сургалт”-ыг зохион байгуулдаг бөгөөд энэхүү сургалт нь түүний дараагийн ахисан түвшний сургалт гэж хэлж болно.



Сургалтын гол зорилго нь япон хэлний хөтөч-тайлбарлагчаар ажиллаж буй хүмүүсийн мэргэжлийн ур чадварыг сэргээх, ахиулахад чиглэсэн бөгөөд сургалтад нийт 16 суралцагч хамрагдсанаас 15 нь сургалтаа амжилттай төгсөж чадсан юм.

Сургалтын агуулгын хувьд аялал жуулчлалтай холбоотой сэдвүүдийн хүрээнд лекц, бодит туршлага дээр үндэслэсэн яриа, хосоор болон багаар ажиллах дасгал даалгавраар дамжуулан суралцагчдын оролцоог бүрэн хангах, онол практикийг хослуулах хэлбэрээр зохион байгууллаа. Сургалтыг хөтөч-тайлбарлагчийн олон жилийн туршлагатай үндсэн багш удирдан явуулснаас гадна түүх, соёл, япон хэлний талын мэргэжлийн багш нарыг урьж тусгай лекц хичээлүүдийг оруулсан юм.



III. СУРАЛЦАГЧДЫН ДУУ ХООЛОЙ

Сургалтын талаарх сэтгэгдэл

Сайн байна уу ? Намайг Э.Аригунсондор гэдэг. Би зуны амралтаараа хүүхдэд зориулсан япон хэлний сургалтад япон хэл сурахаар хамрагдсан юм. Учир нь манай үеэл дүү Гэгээлэн маань Жулиа эгчтэй хамт Япон улсад амьдарч суралцахаар явсан ба дүү маань япон хэл сураад ах бид хоёртой видео дуудлага хийхээр бид хоёр ойлгохгүй гомдоочих вий гэж болгоомжилсны үүднээс, бас 5 дугаар ангиа төгсөөд ах маань ч гэсэн Япон улс руу сурахаар явна гэж ээж хэлсэн болохоор гэр бүлээрээ ярилцаад ер нь япон хэл сурцгаая гэж шийдсэн дээ.



Зураг 24. “8-10 насны хүүхдэд зориулсан анхан шатны япон хэлний зуны сургалт” Суралцагч Э.Аригунсондор

Сургалтад хамрагдсан хугацаанд хамгийн гоё санагдсан нь хичээлүүдийг их хөгжилтэй аргаар бидэнд заадаг байсан. Тоглоом тоглож, дуу сурангаа япон үсэг цээжилж, японоор өөрийгөө танилцуулж чаддаг болсондоо баяртай байгаа. Багш нар маань ч их гоё ааштай, үргэлж инээдэг найрсаг хүмүүс байдаг.

Одоо би үзсэн хичээлээ мартахгүйн тулд аппликэйшн ашиглан бие даан давтаж хичээлээ хийж чаддаг болсон. Би том болохоороо япон хэлний гүнзгийрүүлсэн сургалтад хамрагдан сайн сурч байгаад ахтайгаа хамт Япон улс руу сурахаар явна гэж бодож байгаа. Хичээл дуусах үед их гунигтай санагдсан. Багш нараасаа салмааргүй, ангийнхантайгаа үргэлжлүүлээд хичээлээ хиймээр л байсан. Гэхдээ намайг номын санд ном уншихаар ирэх бүртээ багш нартайгаа уулзаж болно гэж зөвшөөрсөнд нь баяртай байгаа.

“8-10 насны хүүхдэд зориулсан анхан шатны япон хэлний сургалт”

Суралцагч Э.Аригунсондор

Сайн байцгаана уу ? Манай гэр бүл Япон улстай салшгүй холбоотой болоод нэлээд хэдэн жилийг өнгөрөөж байгаа юм. Яваандаа хүү охин хоёроо тэнд сургаж, ирээдүйн боловсролд нь дэм болох санаа сэдэлтэйгээр хүүхдүүдээ япон хэлэнд хэр сонирхолтой байх нь вэ, хүүхдүүдийг маань хэр хүлээн авч үргэлжлүүлэн сурах сэдэл төрүүлж чадах



нь вэ зэрэг талыг харгалзан сургалтын төвүүдийг судалж байгаад тус төвийг сонгон сургалтад хамруулсан юм.

Сургалтын хувьд хүүхдийг уйдааж залхаахгүй, шахаж шаардахгүй, хөгжилтэй, сонирхолтой аргаар явагдаж байснаар манай хүүхдүүд япон хэл, соёлд дурлан сонирхож бүр цаашлаад үргэлжлүүлэн сурах хүсэлтэй болоод төгссөн юм. Хэл сурах суурийг нь маш эерэг, найрсаг, чадварлаг хамт олноор тавиулсандаа баяртай байна. Аливаа зүйлийг хүчээр биш, өөртөө хөгжилтэй хөнгөн аргаар суралцаж болдог гэдгийг миний хоёр хайр ойлгож авсан байх аа.

Манай гэр бүлийн зүгээс хүүхдүүдийнхээ энэ суралцах хүсэл эрмэлзлийг нь дэмжиж үргэлжлүүлэн суралцуулах хүсэлтэй байгаа ба дараагийн шатны сургалтыг тэсэн ядан хүлээхийн сацуу бусад найз нөхдөдөө итгэл дүүрэн Монгол-Японы төвөө санал болгох болно.

***“8-10 насны хүүхдэд зориулсан япон хэлний анхан шатны сургалт”
Суралцагч Э.Аригунсондорын ээж Д.Цэрэнпил***

Сургалтын талаарх сэтгэгдэл

Намайг Ц.Цэрэнхүү гэдэг. Манай аав ээж хоёр япон хэлийг төгс эзэмшсэнээс гадна аав маань Токио хотод амьдардаг. Энэ нь надад Япон орныг илүү ихээр сонирхох, тийшээ явах мөрөөдөлтэй болох үндэс суурийг тавьсан юм. Тэр мөрөөдөлдөө хүрэх анхны алхам маань япон хэлийг сурч эхлэх байлаа. Эхлээд нэгэн сургалтын төвд хичээллэж үзсэн ч тэндхийн орчин, арга барил надад нэг л сонирхолгүй, уйтгартай санагдаж байв. Энэ тухайгаа ээж болон ойр дотно хүмүүстэйгээ ярилцаад, Монгол-Японы төвийн хүүхдэд зориулсан сургалтад элсэн суралцах шийдвэр гаргасан юм.

Тус төвийн хаалгаар анх ороход л дулаахан уур амьсгал, эелдэг багш нар, халуун дулаан сэтгэлтэй ажилчид намайг угтсан тэр мөч өнөөг хүртэл сэтгэлд минь тодхон байдаг. Сургалтын арга барил, багш нарын хичээл заах сонирхолтой аргачлал, япон хэв маягтай орчин нь яг л Японд очсон мэт мэдрэмж төрүүлдэг байлаа. Үүний хажуугаар япон соёлыг танилцуулах хичээлүүд нь миний сониуч зантай илүү ихээр нийцсэн юм. Сургалтад ашигладаг сурах бичгүүд нь өнгөлөг, ойлгоход тун хялбар, залхуу миний сэтгэлийг хүртэл татсан. Ялангуяа үсэг цээжлэх хялбар зөвлөмжүүд нь үнэхээр гайхалтай.



*Зураг 25. “Хүүхдэд зориулсан марүгато япон хэлний анхан шатны сургалт”
Суралцагч Ц.Цэрэнхүү*



Хэдий гэр маань сургалтын төвөөс хол байдаг ч тэр орчинд очихын тулд би өдөр бүр дуртайяа явдаг байлаа. Тэнд өнгөрүүлсэн цаг хугацаа надад үнэхээр дотно санагддаг бөгөөд цаашдаа ч үргэлжлүүлэн суралцахыг хүсэж байна. Энэ аялал маань надад зөвхөн япон хэлийг сураад зогсохгүй хүсэл мөрөөдөлдөө хүрэхэд минь хүч өгсөн гайхалтай туршлага байлаа.

“11-13 насны хүүхдэд зориулсан марүгото япон хэлний анхан шатны сургалт”
Суралцагч Ц.Цэрэнхүү

Монгол дахь япон сургалтын орчин

Сайн байцгаана уу? Намайг Г.Мөнгөнцоож гэдэг. Улсын байгууллагад инженерээр ажилладаг. Хамгийн анх Монгол-Японы төвд ирэхдээ Улаанбаатар хотод Японд байгаа юм шиг цэвэр цэмцгэр, эмх цэгцтэй орчныг бүрдүүлж болдог л юм байна гэж бодож байлаа. Миний хувьд япон мэргэжилтнүүдтэй хамтран төсөл хэрэгжүүлэх болсноор япон хэлээ сайжруулах шаардлагатай болсон. Энэ сургалтад хамрагдсанаар япон оронд сурч байгаа шиг мэдрэмжийг авдаг. Суралцагчдыг амжилттай сургахын төлөө чин сэтгэлээсээ хичээх эелдэг найрсаг багш нар, сонсох, ярих, унших, бичих чадварыг олгоход зориулагдсан сайн сургалтын орчин болон хөтөлбөр, сурах бичигтэй үнэхээр чанартай сургалт байлаа. Хичээлийн хөтөлбөрөөс хамгийн сонирхолтой нь сургалтын явцад сурсан зүйлээрээ өөрийнхөө тухай тодорхой сэдвүүдээр бичиж, бүтээх бяцхан ном байсан.



*Зураг 26. “Яриа, дүрэм
хосолсон цогц сургалт-1С”
Суралцагч Г.Мөнгөнцоож*

Япон хэлнээс гадна тухайн орны соёлын талаар суралцах боломжийг олгодог болон япон багш нар хичээл заадаг зэрэг давуу талуудтай. Бусад сургалтын төвд 1-2 багш хичээл заадаг бол манай ангид 7 хоногийн 3 өдөрт 3 өөр чадварлаг багш нар хичээл орж байсан нь таалагдсан.

Монгол-Японы төвийн хамт олон болон япон хэлний багш нартаа талархсанаа илэрхийлж, ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөе! Япон улсад сурч, ажиллаж амьдрах зорилготой Монголын ирээдүй болсон ангийн хамт олон хөөрхөн дүү нартаа амжилт хүсье.



Монгол-Японы төвийг зорин ирж, анхан шатны ангиа төгсөж, цаашид үргэлжлүүлэн суралцах болсондоо баяртай байна.

“Яриа, дүрэм хосолсон цогц сургалт-1 С анги”
Суралцагч Г.Мөнгөнцоож

Сургалтын талаарх сэтгэгдэл

Анх япон хэл сурахаар шийдсэн минь японы уран зохиолоос эхлэлтэй. Рюүносүкэ Акүтагава, Эдогава Рампо гэх мэтчилэн өөр бусад японы зохиолчид болон тэдний бүтээлүүдэд өөрийн эрхгүй сэтгэл татагдан унших болсон үеэс тухайн улсын соёлыг ч мөн ялгаагүй сонирхох болсноор япон хэл сурах хүсэл эрмэлзэл төрсөн юм.

Монгол-Японы төвийн сургалт зөвхөн хичээл, шалгалт гэх мэтээр нэгэн хэвийн давтамж, хэв маягаар бус соёлын хичээл гэх мэтчилэн суралцагчдадаа аль болох хүсэл тэмүүлэл нэмэгдүүлэх, тухайн орон болон соёлд нь илүү дурлан суралцах боломжийг олгодог нь сэтгэлийн гүнд хүрдэг.

“Марүгото” сургалтын хөтөлбөр ч мөн бүх талаараа тэнцвэртэй мэдлэг олгодог бөгөөд сонирхол татахуйц байж чаддаг. Өмнө нь аливаа зүйлийг сурч мэдэхээр шийдэн эхэлдэг ч тэр бүрд замын голоос цуцаж, хийх хүсэл эрмэлзэл алга болоход өөрөө өөрийгөө хүчлэн хичээдэг байсан үе олон бий. Гэхдээ Монгол-Японы төвийн сургалт нь цуцах, хүсэл эрмэлзэлгүй болох гэх мэт мэдрэмж төрөх төдийд яагаад эхэлснийг минь сануулж, анхаарлыг минь буцаагаад төвлөрүүлж өгдөг “Амьдрал ба соёл”, “Соёлын хичээл” гэх мэт сонирхолтой хичээлүүд байсан учир энэ удаад хийж буй зүйл, олж авч буй мэдлэгээ зөвхөн хоосон цээжлэх биш цаад утга учир, үндэс сууриас нь эхлэн илүү өргөн утгаар ойлгон, бодож сэтгэн, шимтэн суралцаж байна.

Миний хувьд зөвхөн япон хэлийг сураад эсвэл сонирхоод өнгөрөх бус цаашид өөрийн дуртай зохиолчдын бүтээлийг эх хэлээр нь уншиж ойлгох цаашлаад, япон амьдралын хэмнэл, нарийн нандин ойлголтуудыг зөвхөн харж сонсох биш, өөрийн оюун ухаандаа ч мөн амьдруулахын тулд энэ хэлийг сонгон суралцаж буй. Энэ алхамд минь Монгол-Японы төв маш том гүүр, луужин, түлхэц болж өгч буйд талархал илэрхийлье.



Зураг 27. “Яриа, дүрэм хосолсон цогц сургалт-2”
Суралцагч Ч.Энхмарал

“Яриа, дүрэм хосолсон цогц сургалт-2”
Суралцагч Ч.Энхмарал



Тууштай нэгэн заавал зорилгодоо хүрдэг

Сайн байцгаана уу? Намайг Уртнасан гэдэг. Анх арван жилийн сургуулийн сурагч байхдаа зуны амралтаараа ямар нэгэн хэл сурах зорилгоор зуучлалын компанийн хэлний бэлтгэлд явж байсан юм. Суралцаж байсан ангиа төгсөөд үргэлжлүүлэн суралцах гэтэл надаас өөр цаашаа суралцах хүн байхгүй болсон тул багш маань Монгол-Японы төвийг зааж өгснөөр одоог хүртэл Монгол-Японы төвдөө шат ахиулан суралцсаар байна.

Манай сургалтын зүгээс сайн сурсан хоёр хүүхдэд дараагийн сургалтад хөнгөлөлттэй сурах эрхээр урамшуулан шагнадаг ба анх суралцсан ангиа төгсөхдөө тэрхүү хөнгөлөлтийн бичгийг авах завшаан надад тохиосон юм л даа. Бараг л надад цаашаа хичээн суралцах хүсэл эрмэлзэл, урам зоригийг өгсөн гэхэд болно.

Сургалтдаа явж байх хугацаанд миний их сургуулийн амьдрал эхлээд хэсэг завсарлага авсан ч эргээд суралцах хүсэл сэтгэлд минь байсаар л байсан тул ямар ч эргэлзээгүй эргэн сургалтдаа явж эхэлсэн маань одоо бодоход их зөв шийдвэр болсон санагддаг. Хэл сурах, бусад орны соёлыг сонирхон дэлхийтэй танилцах хүслийн минь эхлэлийг бат бөх тавьж өгсөн Монгол-Японы төвийн хамт олон болон найрсаг, чадварлаг багш нартаа маш их баярлалаа.

***“Яриа, дүрэм хосолсон цогц сургалт- 3”
Суралцагч Е.Уртнасан***

Монгол-Японы төвд суралцаж эхэлсэн нь

Япон хэл сурах шалтгаан:
2022 оноос 2023 он солигдох шөнө нэг жилийг хий дэмий өнгөрүүлэхгүй байх зорилго тавьж, япон хэл сурахаар шийдсэн юм. Япон зохиолчдын зохиолыг шимтэн уншдаг



Зураг 28. “Яриа, дүрэм хосолсон цогц сургалт- 3” Суралцагч Е.Уртнасан



байсныхаа хувьд сонирхлоо даган судалж, Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн сургалтад бүртгүүлэв.

Эхний хичээл: 2023.02.06-ны өдөр хаврын сургалтын эхний хичээл. Анги руу ороход ширээн дээр сурагчдын нэрийг дугаартай нь биччихсэн байсан ба ягаан өнгийн номууд жирийтэл нь тавьсан байгааг хараад их гайхсан. Урьд өмнө нь ийм сайн зохион байгуулалттай сургалтад сууж үзээгүй юм чинь.

Үндсэн хичээлдээ орж номоо дэлгэтэл тэр чигтээ мэдэхгүй үсэг өөдөөс угтсан. Японоор бичсэнийг нь мэдэхээс яаж дууддаг бүр яаж дуурайж хэлэх учраа ч олохгүй будилж өгсөн. Тэгтэл надаас бусад нь бүгдээрээ бага сага ч атугай мэдлэгтэй, "япон хэлний хэлтэрхий"-тэй хүмүүс байв. Яахав сүүлд нь асуухад анимэ үздэг байсан болохоор "こんにちは"-тайгаа л байсан хүүхдүүд юм байна билээ.

Эхний өдөр бүр амаргүй байдаг. Гэртээ очоод өгсөн даалгаврын цаасыг нь хараад бараг юу ч ойлгохгүй шууд шантарсан даа. Үсэг дуурайлгаж бичих дасгал байсныг сайн санаж байна. Дуурайлгаж бичих ч гэж зурах шахуу юм болсон. "Үсгээ ч заагаагүй байж яагаад ийм хэцүү юм хийлгээд байгаа юм бол" гэж бодсон ч хичээж хичээж үсэг ханз холин цаас дүүрэн юм бичсэнээ хараад их урам орсон. Тэр цагаас хойш нэг ч хичээл орхигдуулалгүй шамдсан даа. Одоо бол чөлөөтэй бичиж, уншиж, хэрэгцээтэй зүйлээ ярьчих хэмжээний япон хэлийг хуримтлуулсан байна. Хүний яриаг сайн тогтоож, барьж сонсож сурсандаа баярладаг. "Япончууд юу гэж тайлбарласан байна" гээд л мэдмээр байгаа зүйлээ японоор хайна. Өөрийнхөө портофолиоог хааяахан эргүүлж хараад өөрөөрөө бахархах сэтгэл төрдөг. Одоо ямар хэрэг болох биш гээд хаяа гэсэн ч хаяж чадахааргүй олон дурсамжийг өөртөө хадгалах тэр хавтсыг дурсгал болгоод үлдээдэг.

Энэ төвөөс сурсан зүйл тоймгүй олон. Хичээл дээр самбарын өмнө гаргаж яриулдаг байсан нь надад олон нийтийн өмнө өөрийгөө нээх, итгэлтэй болох дадлыг суулгажээ. Мөн багш нарын цаг төлөвлөх, хичээл заах арга барилыг сурсан нь хожим сурагчдад хичээл заахад тус болсон. Зөвхөн япон хэлийг сураад зогсохгүй тэдний соёл, хариуцлагатай амьдрах хэв маягийг өөртөө шингээж чадсан.

Монгол-Японы төв миний хувьд зүгээр нэг сургалтын төв байгаагүй, харин амьдралд минь өөрчлөлт авчирсан гүүр болсон. Хэлний мэдлэг, соёлын ойлголтоос



Зураг 29. "Яриа, дүрэм хосолсон цогц сургалт-4" Суралцагч З.Оюун



гадна өөрийгөө таньж мэдэх замыг минь зааж өгсөн газар. Би зөвхөн япон хэл сураад зогсоогүй, өөрийнхөө алдаа дутагдлыг даван туулах хүч чадалтай болсноо ухаарсан.

Тэрхүү жижигхэн, дулаахан анги танхим, эелдэг боловсон ажилтнууд, багш нарын сэтгэл шингэсэн хичээл, шинэ сорилтууд бүгд надад мартагдашгүй сайхан дурсамжууд болж үлдсэн. Япон хэл сурна гэдэг нэг зорилго байсан бол одоо илүү ихийг сурах хүсэл минь улам бүр нэмэгдсэн. Хэл сурч эхэлсэн тэр л хаврын өглөө намайг шинэ амьдралын эхлэлд хөтөлсөн юм билээ. Хэл сурах аялал маань өөрийгөө нээх гайхалтай нэгэн туршлага болсон юм.

“Яриа, дүрэм хосолсон цогц сургалт-4”

Суралцагч З.Оюун

Тэвчээртэй бай, өдөр бүр алхам алхмаар урагшил

Япон хэлийг сурч эхлэх миний шийдвэр бол миний амьдралын хамгийн чухал, оновчтой шийдвэрийн нэг байсан гэдгийг одоо илүү их ойлгож байна. Эхэндээ хэлийг сурах нь амархан мэт санагдаж байсан ч сургалтад хамрагдсанаар үнэндээ энэ нь тасралтгүй хичээл зүтгэл, тэсвэр тэвчээр шаарддаг гэдгийг ухаарсан юм.

Сургалтад оролцохдоо багш нарынхаа нарийн арга барил, заах аргачлалд гүн сэтгэгдэл төрж, улам их хичээх хүсэл эрмэлзэл бий болсон.

Багш нар маань зөвхөн хэлний мэдлэг өгөхөөс гадна, японы соёл, зан заншил, амьдралын хэв маягийг сонирхолтой, ойлгомжтой байдлаар заасан нь маш их урам өгсөн юм.

Сургалт үргэлжилсэн хугацаанд "Can-do" системд суурилсан даалгавруудыг хийхдээ би өөрийгөө алхам алхмаар сайжирч байгааг мэдэрсэн. Өмнө нь өөртөө итгэлгүй байх үед багш, ангийн хамт олон маань намайг дэмжиж, урамшуулж байсан нь маш их тус болсон.

Япон хэлийг сурч эхэлснээр зөвхөн нэг шинэ хэл сурсан төдийгүй амьдралд хандах хандлагаа өөрчилж, илүү их хичээл зүтгэл гаргах нь чухал гэдгийг ойлгосон.

“Яриа, дүрэм хосолсон цогц сургалт-5”

Суралцагч Э.Чингүүн



Зураг 30. “Яриа, дүрэм хосолсон цогц сургалт-5” Суралцагч Э.Чингүүн



Сургалтын талаарх сэтгэгдэл

Сайн байцгаана уу. Би 2024 оны намрын “Япон хэлний заах аргын сургалт”-ын төгсөгч Уянга байна. Гэр бүлийн хамт Япон улсад 7 жил ажиллаж амьдарч байгаад нутагтаа буцаж ирсэн юм. Монголдоо ирээд Япон улсад олон жил амьдарсан хүнээр өдөр тутмын хэрэглээний япон хэл заалгах сонирхолтой олон хүмүүстэй таарч байсан. Надад ч “япон хэл заагаагч” гэсэн санал их ирсэн. Миний хувьд япон хэл заах туршлага байгаагүй учир үргэлж татгалздаг байлаа. Харин тэдгээр хүмүүст Монгол-Японы төвийн цогц сургалтуудыг санал болгодог байсан юм.



Зураг 31. "Япон хэлний заах аргын сургалт"
Суралцагч Н.Уянга

Япон сангийн япон мэргэжилтэн зохион байгуулдаг “Япон хэлний заах аргын сургалт” байдгийг мэдээд шууд элсэн суралцсан. Тус сургалтаар JF /Japan Foundation/ япон хэлний боловсролын стандарт нь “Харилцан ойлголцлын төлөөх япон хэл” гэсэн үзэл баримтлалтай гэдгийг мэдэж авсан. Бид хэлээр дамжуулан харилцан ойлголцлоо гүнзгийрүүлэхэд:

1. Асуудал шийдвэрлэх чадвар буюу тухайн хэлийг ашиглан бодит зорилгод хүрэх чадвар
2. Өөр соёлыг ойлгох чадвар буюу бусад орны соёлыг ойлгох, хүндэтгэх чадвар чухал гэдгийг ойлгож авсан юм.

Эдгээр үндсэн чигийг баримтлан боловсруулсан “Марүгото”, “Иродори” сурах бичгийн заах аргыг эзэмшин төгслөө.

Япон хэлний “Иродори хэрэглээний япон хэл” сурах бичиг нь олон төрлийн хэрэглэгдэхүүнийг агуулдаг бөгөөд япон хэл суралцагчдад зориулсан бүтээмжтэй, ойлгомжтой арга замуудыг ашигладаг. Сурах бичгийг анхан шатнаас эхлэн монгол хэлээр үзэх боломжтой. Баялаг үгийн сан, дүрэм, японд амьдрах талаарх зөвлөмж зэргийг эх хэлээрээ уншиж судлах давуу талтай. Тиймээс энэ нь анхан, дунд түвшний суралцагчдад илүү тохиромжтой юм. Энэ сургалтаар заах аргын туршлагатай япон, монгол багш нар богино хугацаанд маш чухал олон мэдээллийг зөв дэс дараалалтай бэлтгэн хүргэсэн ба суралцагчдад үр өгөөжтэй сургалт байсан. Суралцагч бүр жишиг хичээл бэлтгэн зааж, алдаа оноогоо дүгнүүлэн төгссөн. Одоо хэн нэгэн япон хэл сурахаар надад хандвал “Иродори хэрэглээний япон хэл” сурах бичгийн дагуу хичээлээ



боловсруулан заах ур чадварыг эзэмшсэн гэдэгтээ итгэлтэй байна. Багш нартаа баярлалаа.

"Япон хэлний заах аргын сургалт"
Суралцагч Н.Уянга

Семинарт оролцсон багшийн сэтгэгдэл

Япон руу ажиллаж амьдрахаар явах гэж байгаа хүмүүст япон хэлний хичээл заадаг багш хүний хувьд тулгардаг олон асуудлаа шийдэх шийдэл олсон маш хэрэгтэй сургалтад суулаа гэж бодож байна.

Японд очоод шууд амьдралд гараад ажил хийхээр зорьж байгаа хүмүүсийн хэрэгцээ нь амьдралын төрөл бүрийн нөхцөлд өөрийгөө тодорхой хэмжээнд илэрхийлж сурах байдаг. "Иродори хэрэглээний япон хэл" сурах бичиг нь суралцагчийн энэ хэрэгцээг бүрэн хангасан тал нь маш их таалагдлаа. Мөн багш хүний ажлыг хөнгөвчилсөн бүтэцтэй байгааг дурдах хэрэгтэй санагдсан.




Зураг 32. "Сэйкай" япон хэлний сургалтын төвийн багш
Д.Молор-Эрдэнэ

Хичээлээ төлөвлөх, бэлдэх зэрэг нь багшаас нэлээдгүй цаг хугацааг шаарддаг нарийн ажил байдаг бол "Иродори хэрэглээний япон хэл" сурах бичиг нь хичээлийн явц, дэс дараалал ойлгомжтойгоос гадна бүх материал нь онлайн байдаг учир хичээлийн үзүүлэн слайд бэлдэх зэрэгт маш их хөдөлмөр хөнгөвчлөн, цаг хугацаа хэмнэж байгаа нь үнэхээр тустай санагдлаа.

Япон руу ажиллаж амьдрахаар явах хүмүүст зааж байгаа багш нарт энэхүү сурах бичгийг санал болгон, нэг удаа ашиглаад хичээл орж үзээсэй гэж зөвлөмөөр санагдсан. Би ч бас цаашид шинэ сурах бичгээ ашиглан хичээлээ баяжуулж, манайд итгэл найдвар хүлээлгэж ирсэн суралцагчидтайгаа хамт хичээн, гарах үр дүнгээ тэсэн ядан хүлээж байна.

"Сэйкай" япон хэлний сургалтын төвийн багш Д.Молор-Эрдэнэ



IV. НОМЫН САН, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТАСАГ





I. 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ТАЙЛАН

Монгол-Японы төвийн номын сан, хамтын ажиллагааны тасаг нь хоёр орны хамтын ажиллагаа, харилцан ойлголцлыг бэхжүүлэх үйл ажиллагааны хүрээнд нээлттэй семинар, япон киноны өдөр, Японд суралцахыг хүссэн оюутан сурагчдад зориулсан “Мэдээллийн яармаг, семинар”, Японд тэмдэглэдэг уламжлалт баяр наадмаар дамжуулан япон соёлыг мэдэж авах “Япон хэл, соёлын танилцуулга хичээл”, ЕБС-иудын япон хэлний багш, сурагчдын хамрагддаг Хакүходо боловсролын сангийн япон хэл сурч буй хүүхдийн боловсролыг дэмжих “Япон хэл, солилцооны хөтөлбөр” зэрэг ажлуудыг тогтмол зохион байгуулахын зэрэгцээ нийтийн номын сангийн үйл ажиллагаа явуулдаг.

Дээр дурдсан үйл ажиллагаануудын талаар та онцлох мэдээ хэсгээс дэлгэрүүлэн уншина уу. Энэ жил арван хурууны бичээчийн сургалт танхимаар, цахимаар нийт 23 удаа хичээллэлээ.

1) Номын сангийн үйл ажиллагаа

Номын сангийн бүртгэлтэй уншигчдын тоо 2024 оны 12-р сарын байдлаар 29,638 болсон ба 5777 уншигч номын сангийн танхимаар үйлчлүүлжээ.

Номын сангийн фондод япон хэл суралцагчдад зориулсан ном, толь бичиг, Японд суралцах шалгалт, япон хэлний түвшин тогтоох шалгалтад бэлтгэх ном, товхимол, япон, монгол зохиолчдын бүтээл, дэлхийн сонгодог зохиол, комик зэрэг 11,000 гаруй ном материал байна. Түүнээс гадна Японы 100 гаруй их, дээд сургуулийн танилцуулга, холбогдох материалууд номын санд бий. Энэ жил номын сангийн фондоо 142 номоор баяжуулжээ. Монгол, япон хэлээрх ном хандивласан монгол, япон хувь хүн, албан байгууллага, хэвлэлийн газарт гүнээ талархаж байна.

Бид энэ жил хүүхэд залуусын нэн сонирхдог японы анимэ, манга чиглэлээр танилцуулга үйл ажиллагаа, гар зургийн уралдаан, нээлттэй семинар, анимэ кино өдрүүдийг тус тус зохион явууллаа. Та бүхэн дэлгэрэнгүй мэдээллийг онцлох булангаас хүлээн авч уншина уу.

Мөн жилийн эцэст номын сангийн уншигчдаас танхимаар хамгийн их үйлчлүүлсэн болон гэрээр хамгийн их ном авч ашигласан нэг уншигчийг бүртгэлийн системээр тодруулахад Т. Баасанжав шалгаран, гарын бэлэг авлаа.



Ном хэвлэлээр үйлчлэхээс гадна бид японы соёлыг түгээн дэлгэрүүлэх үүднээс японы үндэсний хувцас юката, япон эд хэрэглэлийн зүйлсийн үйлчилгээг мөн үзүүлдэг билээ. Энэ жил 100 гаруй хувь хүн, байгууллагуудад 300-аад хувцас, эд хэрэглэлийн үйлчилгээ үзүүлжээ.

Номын сангийн мэдээллийн буланд Японы ЭСЯ-аас хариуцан явуулдаг тэтгэлэгт шалгалт, Япон хэлний багш нарын холбоо, ЖАССО /Японы оюутныг дэмжих байгууллага/-оос явуулдаг хувийн зардлаар Японд суралцах шалгалт, мөн Япон сангийн япон хэлний түвшин тогтоох шалгалттай холбоотой мэдээллийг түгээдэг.

2) Япон киноны өдөр

Хүүхэд залуусын дунд япон кинонуудаас хамгийн дуртай жанр нь мэдээж анимэ байдаг нь хэн бүхэнд тодорхой. Энэ жил соёлын уламжлалт үйл ажиллагааны нэг болох япон киноны өдрийг Японы элчин сайдын яамтай хамтран албан ёсны эрхтэйгээр, алдартай найруулагч, уран бүтээлчдийн анимэ киног 3 өдрийн турш зохион байгууллаа. Давхардсан тоогоор 131 үзэгчид хүрэлцэн иржээ.

3) Нээлттэй семинар

Төв нээгдсэн цагаасаа хойш нээлттэй семинарыг тогтмол зохион байгуулж ирсэн билээ. 2024 онд 84 дэх удаагаа “Японы анимейшн салбарын хөгжлийн түүх” сэдвээр нээлттэй семинар зохион байгуулсан нь анимэ, манга бүтээл сонирхогч бүрт ихээхэн таалагдсан арга хэмжээ болсон юм. Тус семинарын агуулга, хэрхэн явагдсан талаар сонирхолтой мэдээллийн дэлгэрэнгүйг та “Онцлох мэдээ”-ээс хүлээн авна уу.

4) Японд суралцах тухай мэдээллийн яармаг – 2024

Жил бүр тогтмол зохиогддог уламжлалт нэгэн арга хэмжээ бол Японд суралцахыг хүссэн хүмүүст зориулсан “Японд суралцах мэдээллийн яармаг” байдаг. 15 дахь удаагийн мэдээллийн яармагийг энэ онд анх удаа хавар, намар хоёр удаа зохион байгууллаа. Хаврын мэдээллийн яармагийн оролцогч их сургуулиудыг цахимаар хамруулж 1 өдрийн үйл ажиллагаа болсон бол харин намрын мэдээллийн яармагт оролцогч их сургуулиудын бие төлөөлөгч нар Японоос ирж 2 өдрийн турш хэрэгцээт мэдээллээр ханган оролцлоо. Монголд хараахан хүрэлцэн ирж амжаагүй их сургуулиуд холбогдох материалаа ирүүлж оролцдог уламжлал тогтож байна. Тухайн их сургуулиудын танилцуулга брошюр, тараах материалыг яармагийн хоёр өдөр оролцогчдод тараахаас гадна, сургуулийн мэдээлэл нь манай www.edujapan.mn тусгай



вэб сайтад байршиж байгаа юм. Ийнхүү нийт 13 их сургуулийн мэдээ мэдээлэл нийтэд хүрлээ.

Оролцогч их сургуулиудын явуулсан танилцуулга материалуудыг хүлээн авах танхимд тусгай булан гарган байршуулж, мөн номын сан дахь тараах материалын булангаар дамжуулан тараахын зэрэгцээ үйлчлүүлэгчийг тухайн сургуультай холбож өгөх үйлчилгээг үзүүлдэг. 2025 онд ч мөн адил “Японд суралцах мэдээллийн яармаг” үйл ажиллагаагаа хоёр удаа: хаврынхыг 2025 оны 4-р сард, намрынхыг мөн оны 10-р сард зохион байгуулахаар төлөвлөж байна. Дэлгэрэнгүйг онцлох мэдээнээс хүлээн авна уу.

5) Гэрээгээр гүйцэтгэх ажил

Жил бүр хэрэгждэг Хакүходо боловсролыг дэмжих сангийн “Япон хэл, солилцооны хөтөлбөр” энэ жил ч мөн амжилттай явагдлаа. Өмнөх хөтөлбөрт орон нутгийн багш шалгаран оролцсон бол энэ удаа Улаанбаатар хотын Эрдмийн ундраа цогцолбор 54-р сургуулийн япон хэлний багш Т. Энхпүрэв шалгаран багшийн дадлага сургалтад хамрагдсанаас гадна, шавь нарын хамт Япон улстай танилцах хөтөлбөрт амжилттай яваад ирлээ. Ийнхүү 14 дэх хөтөлбөр дуусч, мөн үүнтэй зэрэгцэн 15 дахь удаагийн хөтөлбөр эхэлж энэ удаад Шинэ Монгол сургуулийн япон хэлний багш В. Түвшинжаргал шалгаран 2024 оны 11-р сард багшийн дадлага сургалтдаа амжилттай оролцоод ирлээ. 2025 оны 5-р сард сурагчдын хамт танилцах хөтөлбөрт явахаар бэлтгэл ажлаа хангаж байна.

Энэ жил дээрх үндсэн гэрээт ажлаас гадна Киотогийн дэвшилтэт шинжлэх ухааны их сургууль, Нийгата мужийн их сургууль, Токиогийн эдийн засгийн их сургууль зэрэг хэд хэдэн их сургуультай хамтарсан гэрээт ажлуудыг амжилттай зохион байгуулав. Түүнчлэн, Японы оюутныг дэмжих байгууллага JASSO болон Сайко компанийн орчуулгын ажлыг хийж гүйцэтгэлээ.

6) Арван хурууны бичээчийн сургалт

2002 оноос тасралтгүй явагдаж ирсэн нэгэн сургалт бол кириллээр арван хуруугаар хурдан бичиж сурдаг сургалт билээ. 7, 12-р сараас бусад бүх сард тогтмол хичээллэдэг, жилд 10 удаагийн сургалт явагддаг байсан юм. Харин 2024 онд бид Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн 3,4-р дамжааны сонсогчдыг хамруулсан сургалтыг, нийтэд зарласан сургалттай хамт зохион байгуулж нийт 23 сургалт явуулан, 323 хүн хамрагдсаны 150 хүн нь дээрх сургуулийн сонсогчид байлаа.



Хүснэгт-16: Нээлттэй семинар

№	Сэдэв	Илтгэгч	Он сар өдөр	Хаана	Оролцогчдын тоо
1	№84. “Японы анимейшн салбарын хөгжлийн түүх”	Монголын Анимейшний холбоо ТББ-ийн гүйцэтгэх захирал Э.Тамир	2024.11.30	Их танхим	59
Нийт					59

Хүснэгт-17: Япон киноны өдөр

№	Киноны нэр (Хадмал орчуулгатай)	Он сар өдөр	Хаана	Хүний тоо
1	1. Чиний нэр 2. Тэнгэр цэлмээгч охин 3. Яндант хотын Пупель	2024.11.25,27,29	Их танхим	131
Нийт				131

Хүснэгт-18: Гэрээгээр гүйцэтгэх ажил

№	Үйл ажиллагааны нэр	Он сар өдөр	Оролцогчид	Хаана	Хүний тоо
1	Хакүходо боловсролын сангийн "Япон хэл, солилцооны хөтөлбөр" гэрээт ажил	2024.5, 11-р сар	ЕБС-ийн япон хэлний багш	Япон, Токио	6
2	Нийгата мужийн их сургууль, МУИС-ийн оюутнуудын хамтарсан семинар	2024.03.19	Нийгата мужийн их сургууль, МУИС, ШУТИС-ийн оюутнууд	МЯТ Их танхим	32
3	JICA, HIS Mongolia-н төслийн санал асуулга	2024.6-р сар		Онлайн	120
4	「Saikou Day」үйл ажиллагаа	2024.6-р сар		Их танхим	200
5	Канэко Харүхико "Тэртээд оршихуйн юмс" вааран урлалын үзэсгэлэн	2024.08.16-19	Канэко Харүхико Канэко Масаёо	Богд хааны ордон музей	786
6	Японы оюутныг дэмжих байгууллага ЖАССО-н гарын авлагын орчуулга, хэвлэлт	2024.9-10-р сар	ЖАССО	Impress Colour LLC	1
7	Токиогийн эдийн засгийн их сургуулийн оюутнуудад зориулсан: Монголын тухай танилцуулга семинар	2024.9-р сар	Токиогийн эдийн засгийн их сургуулийн оюутнууд	МЯТ Их танхим	35
8	Киотогийн дэвшилтэт шинжлэх ухааны их сургуулийн гэрээт ажил	2024.10-р сар	Киотогийн дэвшилтэт шинжлэх	Улаанбаатар дахь сургуулиудаар зочлох	300




			ухааны их сургууль		
Нийт					1480

Хүснэгт-19: Япон сангийн Япон хэл, соёлын танилцуулга хичээл

№	Үйл ажиллагааны нэр	Он сар өдөр	Оролцогчид	Хаана	Оролцогчдын тоо
1	Цагаан сар	2024.01.13	Оюутан, сурагчид	204, 205	23
2	Охидын баяр	2024.03.02 2024.03.09	Сурагчид	Их танхим	51
3	Хүүхдийн баяр	2024.05.04	Сурагчид	204, 205	23
4	Сар харах баяр	2024.09.07	Иргэд		13
Нийт					108

Хүснэгт-20: Номын сангийн үйлчлүүлэгчдийн тоо

	2024												
Сараар	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	Нийт
Үйлчлүүлэгчдийн тоо	248	387	586	768	702	503	153	385	528	626	522	369	5777





Хүснэгт-20: Орчуулагч уншигчдын уулзалт

№	Сэдэв	Илтгэгч	Он сар өдөр	Хаана	Оролцогчдын тоо
1	Мачида Соноко "52 герцийн халим"	Э.Тодрол Ө.Наран	2024.3.30	Их танхим	21
Нийт					21

Хүснэгт-21: Япон соёлын танилцуулга

№	Үйл ажиллагааны нэр	Он сар өдөр	Хаана	Оролцогчдын тоо
1	Анимэгийн соёлыг танилцуулах өдөрлөг	2024.5.18	Их танхим	87
Нийт				87

Хүснэгт-22: Компьютерийн сургалт

№	Сургалтын нэр	Хугацаа	Давтамж	Агуулга	Багшийн нэр	Оролцогчдын тоо
1	Арван хурууны бичээчийн сургалт /танхим болон цахим	2024.01-2024.12	23 удаа	Компьютерийн гарын үндсэн байрлалыг эзэмшиж, програм ашиглан арван хуруугаар зөв, хурдан бичиж сурна.	Т.Болормаа	323
Нийт						323



II. ОНЦЛОХ МЭДЭЭ

1) “Хаврын мэдээллийн яармаг”-ийг анх удаа зохион байгууллаа



Зураг 33. Мэдээллийн яармагийн

Монгол-Японы төв нь Монголынхоо ирээдүй хойч болсон оюутан залуустаа дэлхийн жишигт нийцсэн боловсрол эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор жил бүрийн намар 10-р сарын эхний 7 хоногийн амралтын өдрүүдэд “Японд суралцах тухай мэдээллийн яармаг” өдөрлөгөө амжилттай зохион байгуулсаар ирсэн билээ. Тус мэдээллийн яармагт Японы их дээд сургуулиудын төлөөлөгчид оролцож өөрийн сургуулийн танилцуулга, ганцаарчилсан зөвлөгөө, мэдээлэл өгөхөөс гадна суралцаж, амьдрахтай холбоотой бүхий л талын цогц мэдээллийг олж авах боломжтойгоороо онцлогтой байдаг.

Энэ жил хавар сургуулиа төгсөх гэж буй ЕБС-ын ахлах ангийн дүү нартаа зориулан Японд суралцахад чиглэл өгөх, хувийн бэлтгэлээ хангахад нь дэмжлэг болох зорилгоор 2024 оны 4-р сарын 20 (Бямба)-ны өдөр “Хаврын мэдээллийн яармаг”-г анх удаа зохион байгууллаа. Тус арга хэмжээнд цахимаар Киото дэвшилтэт шинжлэх ухааны их сургууль, Рицүмэйкан ази номхон далайн их сургууль, танхимаар Монгол дахь Япон улсын элчин сайдын яам, Японд сургууль төгсөгчдийн “ЖУГАМО” нийгэмлэг, Монголын япон хэлний багш нарын холбоо тус тус оролцсон. Энэхүү арга хэмжээнд Японд суралцах хүсэлтэй 500 гаруй хүүхэд, залуус хүрэлцэн ирсэн билээ.

“Хаврын мэдээллийн яармаг”-ийн хөтөлбөрт Япон улсын засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийн танилцуулга, Японд суралцах талаар ерөнхий танилцуулга (МЯТ), Япон улсад тэтгэлгээр суралцаж ирсэн оюутны яриа, Японд суралцахад зайлшгүй өгөх шалгалт, япон хэл сурах талаарх ганцаарчилсан зөвлөгөө, мэдээллийн яармагт оролцож буй сургуулиудын



Зураг 34. Их сургуулийн танилцуулга



танилцуулга болон сургууль тус бүрийн ганцаарчилсан зөвлөгөө өгөх булангуудыг бэлдэж, зорьж ирсэн хүүхэд залуучууддаа өөрт хэрэгтэй мэдээллээ авах боломжоор хангаж өгсөн. Мөн тус үйл ажиллагаанд оролцох боломжгүй хөдөө орон нутгийн хүүхэд залуустаа зориулан төвийн фэйсбүүк хуудсаар дээрх танилцуулга, үйл ажиллагааг шууд дамжуулсан юм.

Тус яармагийн онцлог үйл ажиллагаа болох Японд сургууль төгсөгчдийн “ЖУГАМО” нийгэмлэгээс “Японд сурч мэдсэн туршлага” сэдвээр нээлттэй хэлэлцүүлэг хийсэн бөгөөд улсын болон хувийн зардал, япон, эсвэл, англи хэлээр Японд суралцан тус тусын чиглэлээр мастер, докторын зэрэг хамгаалаад ирсэн залуус өөрсдийн туршлагаа хуваалцаж, оролцогчдын сонирхсон асуултад хариулсан.



Зураг 35. Цахимаар сургуулийн төлөөлөгчөөс ганцаарчилсан зөвлөгөө авч буй байдал

Хүснэгт-23. “Хаврын мэдээллийн яармаг”-ийн оролцогч их сургуулиуд

 <i>Киото дэвшилтэт шинжлэх ухааны их сургууль</i>	 <i>Рицүмэйкан Ази Номхон далайн их сургууль</i>
---	---

2) “Японд суралцах тухай мэдээллийн яармаг-2024” 15 дахь удаагаа амжилттай зохион байгуулагдлаа.

2024 оны 10-р сарын 5 (Бя), 6 (Ня)-ний өдрүүдэд “Японд суралцах тухай мэдээллийн яармаг-2024” зохион байгуулагдлаа. 15 дахь удаагаа зохион байгуулагдаж буй тус арга хэмжээнд Японы 8 их сургууль танхимаар, 2 их сургууль материалаар тус тус оролцов. 2 хоногийн турш явагдсан энэхүү арга хэмжээнд, нийтдээ Японд суралцах хүсэлтэй 1000 гаруй оюутан залуус оролцсон байна.



Мэдээллийн яармагийн эхний өдөр буюу 10-р сарын 6-ны бямба гарагт арга хэмжээг нээж Япон улсаас Монгол улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Игавахара Масарү үг хэлэн, ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газрын дарга Мияаги Кэнсүкэ, МУИС-ийн ректор, профессор Б. Очирхуяг, Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн захирал Ц. Даваадорж нар тус тус мэндчилгээ дэвшүүлэв.

“Японд суралцах тухай мэдээллийн яармаг-2024”-ийн энэ жилийн хөтөлбөрт Япон улсын засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийн танилцуулга, Японд суралцах талаар ерөнхий танилцуулга (JASSO), Япон хэлний түвшин тогтоох шалгалт (JLPT) болон Япон улсад хувийн зардлаар суралцах шалгалт (EJU), Япон улсад тэтгэлгээр суралцаж ирсэн



Зураг 36. JLPT болон EJU шалгалт, их сургуулийн ганцаарчилсан зөвлөгөө

оюутны яриа, мэдээллийн яармагт оролцож буй сургуулиудын танилцуулга болон сургууль тус бүрийн ганцаарчилсан зөвлөгөө өгөх булан зэрэг зорьж ирсэн оюутан залуусдаа цогц мэдээлэл авах боломж олгохыг зорилоо. Оюутан залуус маань өөрсдийн суралцах чиглэлээр элсэлт авч буй сургуулийн ганцаарчилсан зөвлөгөө өгөх буланд очиж тэтгэлэгт хөтөлбөрөөс гадна өөрт хэрэгтэй мэдээллүүдээ олж авсан.

Мэдээллийн яармагийн сүүлийн өдөр буюу 10-р сарын 6 (Ня)-ны өдөр, Японд сургууль төгсөгчдийн “Жугамо” нийгэмлэгээс “Японд сурч мэдсэн туршлага” сэдвээр ээлжит нээлттэй хэлэлцүүлгээ хийсэн. Тус нээлттэй хэлэлцүүлэг нь “Жугамо” нийгэмлэгээс зохион байгуулдаг “TALKio-Let’s about ideas & opportunities”-ын цуврал хэлэлцүүлэг бөгөөд оюутан залуусын хамгийн их сонирхдог мэргэжлээр Японд суралцсан залуус өөрсдийн туршлагаа хуваалцаж, оролцогчдын сонирхсон асуултад хариулсан.

Сүүлийн жилүүдэд Японд англи хэлээр нарийн мэргэжлээр сурч болох сургуулиудын тоо эрс нэмэгдэж байгаа нь зохион байгуулагч бидний хувьд



таланхууштай хэрэг бөгөөд Монголынхоо оюутан залууст илүү их боломжийг нээж өгч байгаа гэдэгт итгэлтэй байна.

Ирэх жил ч гэсэн Япон улсаас олон олон их сургууль, байгууллагын төлөөлөгчид “Японд суралцах мэдээллийн яармаг”-т оролцож, Японд суралцахыг хүсэж буй оюутан залууст хэрэгцээтэй мэдээлэл өгнө гэдэгт итгэж байна.

Ерөнхий зохион байгуулагч: Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв

Хамтран зохион байгуулагч: Монгол Улсын Их Сургууль

Японд сургууль төгсөгчдийн “JUGAMO” нийгэмлэг

Дэмжигч байгууллага: Монгол дахь Япон улсын элчин сайдын яам

Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA)

Японы оюутныг дэмжих байгууллага (JASSO)

Монголын Япон хэлний багш нарын холбоо

Оролцогч их сургуулиуд: Кэйо их сургууль, Киото дэвшилтэт шинжлэх ухааны их сургууль, Нагоя худалдаа, бизнесийн их сургууль, Нийгата мужийн их сургууль, Олон улсын их сургууль, Токио олон улсын их сургууль, Хёого мужийн их сургууль, Чюүо Гакүин их сургууль

Материалаар оролцогч сургуулиуд: Нагоя их сургууль, Ямагата их сургууль

Хүснэгт-24. “Японд суралцах тухай мэдээллийн яармаг-2024”-ийн оролцогч их сургуулиуд

 慶應義塾大学 Keio University Tokyo, Japan Кэйо их сургууль	 KUAS KYOTO UNIVERSITY OF ADVANCED SCIENCE Киото дэвшилтэт шинжлэх ухааны их сургууль	 NUCB Undergraduate School Нагоя худалдаа, бизнесийн их сургууль	 新潟県立大学 UNIVERSITY OF NIIGATA PREFECTURE Нийгата мужийн их сургууль	 IUJ INTERNATIONAL UNIVERSITY OF JAPAN Where the World Cooperates Олон улсын их сургууль
 TOKYO INTERNATIONAL UNIVERSITY Токио олон улсын их сургууль	 UNIVERSITY OF HYOGO Хёого мужийн их сургууль	 CGU Чюүо Гакүин их сургууль	 NAGOYA UNIVERSITY Нагоя их сургууль	 Yamagata University Ямагата их сургууль



3) “Тэртээ оршихуйн юмс” керамик уран бүтээлийн үзэсгэлэн

Японд төдийгүй дэлхийд алдартай керамик урлалын томоохон төлөөлөгч Канэко Харүхико, түүний уран бүтээлийн хамтрагч гэргий Канэко Масаё нарын КАНЭКО төслийн гайхамшигт уран бүтээлийн үзэсгэлэнг Богд хааны ордон музейтэй хамтран өнгөрөгч оны 8-р сарын 16-19-ний өдрүүдэд олонд толилууллаа. Тус үзэсгэлэн жил бүр зохион байгуулагддаг “Япон Фестиваль Монголд” арга хэмжээний хүрээнд явагдаж 4 өдрийн турш гадаад, дотоодын 800-аад үзэгчдийн хүртээл болсон билээ.

Уран бүтээлч Канэко нь байгаль эхийн гайхамшиг болсон номин хөх далайг илэрхийлэхийн тулд Окинавагийн эрдэст хүдрийг нунтаглан шилээр бүрж, өндөр температурт шатаан, далай тэнгисийн хөх цэнхэр болон маргад ногоон зэрэг өнгийг гарган авч бүтээлээ туурвидаг. Энэхүү уран нарийн технологийг тэрээр ааваасаа



Зураг 37. Гадаадын жуулчид

уламжлан авч улмаар хөгжүүлэн сайжруулж яваа юм. 1999 онд тэрээр баруун Окинавагийн үзэсгэлэнт Кабира далайн булангийн ойролцоо орших Ишигаки арал дээр өөрийн “Ишигаки” керамик студийг байгуулсан. Уран бүтээлийн үзэсгэлэнгийн дэглэлтийг гэргий Канэко Масаёо хариуцдаг бөгөөд нийтлэг хэв маяг, арга барилд баригдахгүйгээр шинэ содон бүтээл туурвин, эрэл хайгуул хийх нь уран бүтээлч хосын баримталдаг зарчим гэхэд болно.

Тус үзэсгэлэнгийн агуулгыг уран бүтээлчдийн тайлбарласнаар дурдвал, энэхүү үзэсгэлэн нь харагдах болон оршихуйн завсарт байх үнэн мөн чанарт ойртоно хэмээжээ. Бидний нүднээ тусаж буй бодит байдал үнэхээр үнэн мөнийг тусгаж чадаж байгаа болов уу? Зөвхөн харагдаж байгаа зүйл л үнэн байх уу? Өдөр тутмын амьдралд алгасаж



Зураг 38. “Тэртээ оршихуйн юмс”



орхигдсон, мартагдсан жижигхэн агшин, оршин байгаа ч харагдахгүй байгаа зүйлс. Бүтээлийн тусламжтайгаар та өөрийн нүдэнд харагдаж буй зүйлс үнэхээр жинхэнэ эсэх, мөн харагдахгүй зүйлс хэр зэрэг баялаг утгатайг дахин нэг бодох боломжтой болно. Толинд харагдах хязгааргүй орон зай, түүний цаадах өргөн уудам танил бус ертөнц. Энэхүү үзэсгэлэн нь үзэгчийн мэдрэмж, ухамсрыг өдөөж, шинэ харах өнцөг болон мэдлэгийг өгсөн гэж найдаж байна.

Уран бүтээлчид өмнө нь Монголд ирж байсан бөгөөд Монгол-Японы хооронд дипломат харилцаа тогтоосны 45 жилийн ой, тус төвийн 15 жилийн ойд зориулан дурсгасан, мөн Монголын ваар, шаазан урлалын хөгжлийг дэмжих зорилгоор бид бүхэнд дурсган үлдээсэн үнэ цэнтэй нэгэн бүтээл “Аз жаргалын цэнхэр хана” бүтээл нь өдгөө ч төвийн танхимыг чимэн Японы хөх цэнхэр далайг төлөөлөн өөр өөрийн давтагдашгүй өнгөөрөө туяаран гэрэлтсээр байгаа билээ. Үзэсгэлэнг үзэж амжаагүй гэж харамсалгүй, манай төвд зочлон дээрх алдартай бүтээлийг чөлөөтэй үзэж сонирхож болно шүү. Манай төвийн үүд хаалга хэн бүхний өмнө үргэлж нээлттэй.

4) 84-р нээлттэй семинар “Японы анимейшний салбарын хөгжлийн түүх”

Энэ онд зохион байгуулсан соёлын аливаа үйл ажиллагааны сэдвээ хүүхэд залуусын дунд үргэлж сонирхолтой, дуртай сэдэв нь байсаар ирсэн Японы анимэ, манга буюу зурагт номын сэдвээр төрөл бүрээр зохион байгууллаа. Түүний нэг болох нээлттэй семинарын энэ удаагийн зочноор Монголын анимейшний холбоо ТББ-ын гүйцэтгэх захирал, “Бумбардай”, “Хандгай” комикс, анимейшн зэрэг дүр дээр суурилсан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг Эконте компанийн хамтран үүсгэн байгуулагч, ерөнхий продюсер Э. Тамир оролцлоо. Семинар хэдий өвлийн хүйтэн, амралтын өдөр зохион байгуулагдсан ч тун сонирхолтой сэдвээр, мэргэжлийн байгууллагын зочин уригдсан байсан тул олон оролцогч ирж өөрсдийн хүссэн мэдээллээ авсандаа тун сэтгэл хангалуун үлдсэн юм.



Зураг 39. Илтгэгч Э.Тамир



Илтгэгч эхлээд Монголын анимейшний хөгжил, чиглэл ямар түвшинд явж байгааг видео танилцуулгаар дамжуулахын хамт, өөрөө ч тодорхой сайн ярьж тайлбарласан юм. Улмаар Японы анимейшний салбарын талаар олон жишээ дурдан, бүгдэд ойлгомжтой ярьж байлаа. Тухайлбал, Японд анимэ салбарын орлого бүрдүүлэлтийг борлуулалтын хэмжээгээр харьцуулахад телевизийн контент их байдаг ч дагалдах бүтээгдэхүүн, хүүхдийн парк, олон улсын худалдаа хамгийн өндөр борлуулалттай байдаг талаар сонирхуулав. Түүнчлэн, анимейшний дэлхийн зах зээлд АНУ тэргүүн байранд, удаад нь БНХАУ, харин Япон улс дэлхийд 3-р байранд ордог талаар гэх зэргээр олон талын мэдээ мэдээлэл өгч байлаа.

Илтгэл дуусаж, асуулт хариултын цаг эхлэхэд оролцогчид тун идэвхтэй байж илтгэгчээс маш их асуулт асууж байв. Жишээлбэл, миний мэдэхийг хүсэж байсан, төсөөлж ч байгаагүй үнэ цэнтэй мэдээллийг олж авч, цаашдын чиг хандлагаа тодорхойлж чадсандаа үнэхээр баяртай, сэтгэл хангалуун байна гэсэн утга бүхий сэтгэгдэл бичиж үлдээсэн цөөнгүй хүмүүс байлаа.

Японд очиж манга, анимэ чиглэлээр суралцах хүсэлтэй хүүхэд залууст Японы Ширахэги Гакүэн сургуулийн талаар мэдээлэл өгч, Японд хэрэв энэ чиглэлээр сурахаар үнэхээр шийдсэн бол тун тэвчээртэй суралцах, ажил дээр гарсан ч маш их зүтгэл чармайлт хэрэгтэй талаар үнэн сэтгэлийн зөвлөгөө өгч байлаа.

Цаашид дэлгэрэнгүй мэдээлэл авмаар байна, танай дээр зурах дадлага хийж болох уу, яаж холбогдох вэ зэрэг асуултад тун уриалгахан хариулж, залуусыг бүхий л талаар дэмжихээ илэрхийлж байв.

Бид цаашид ч олон нийт, залууст хэрэгтэй мэдээ мэдээллээр дүүрэн, сонирхолтой нээлттэй семинараа та бүхэнд зориулан зохион байгуулсаар байх болно оо, хүрэлцэн ирэхийг урьж байна.



5) “Япон соёл судлаач, эрдэм шинжилгээний ажилтанд зориулсан мэргэжлийн япон хэлний 2 сарын сургалт”-д амжилттай ороцлоо.

Япон сангаас жил бүр япон соёл судлаач болон эрдэм шинжилгээний ажилтанд зориулсан мэргэжлийн япон хэлний 2 сарын сургалтыг зохион байгуулсаар ирсэн билээ.

Энэ жилийн сургалтад Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвөөс номын сан, хамтын ажиллагааны тасгийн мэргэжилтэн Д.Мөнхтуяа тэнцэж, 2024 оны 1-р сарын 10-аас 2024 оны 3-р сарын 6-ны хооронд Осака хот дахь Япон сангийн Кансай төвд зохион байгуулагдсан сургалтад хамрагдаж амжилттай яваад ирлээ. Тус сургалт нь нарийн



Зураг 40. 2 сарын турш хийсэн судалгааны тайлангийн

мэргэжил болон судалгааны үйл ажиллагаанд нь япон хэлний мэдлэг шаарддаг мэргэжилтнүүд (судлаач, магистрантур, номын санч, музей, урлагийн галерейн куратор)-ийн мэргэжил бүрийн онцлогийг харгалзан үзсэн сургалтын хөтөлбөрөөр дамжуулан судалгаа болон мэргэжлийн япон хэлний ур чадварыг нь сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилготой.

Д.Мөнхтуяагийн сэтгэгдэл:

Энэ удаа Хятад, Бразил, Шри-Ланка, Малайз, Индонез, Монгол зэрэг нийт 6 орны 9 судлаачид цуглан, Япон Хятадын хоорондох торгоны замын түүх, мангагаар япон хэл заах арга, япон хэлний хүндэтгэлийн хэллэг, япон-монгол анагаахын үг хэллэг зэргээр бүгд өөр өөр сэдвээр судалгаа хийсэн юм. Миний хувьд энэхүү сургалтаар мэргэжлийн сэдвийн дагуу “YA (Young Adult) буюу өсвөр насны хүүхдэд зориулсан номын сангийн үйлчилгээ”-г сонгон судалсан. Манай номын сангаар үйлчлүүлж буй өсвөр насны үйлчлүүлэгчдийн тоог нэмэх, тухайн насны онцлогт тохирсон үйлчилгээг дэмжих, мөн энэхүү үйлчилгээг номын сандаа нэвтрүүлэн үйл ажиллагаагаа өргөжүүлэх зорилготойгоор энэхүү сэдвийг сонгон судалсан юм. Судалгааны үеэр Япондоо энэхүү өсвөр насны хүүхдэд зориулсан үйлчилгээг чухалчилдаг номын сангуудыг сонгон зочилж, мөн мэргэжлийн хүнтэй уулзаж зөвлөгөө авсан ба цаашлаад манай номын санд уг үйлчилгээг нэвтрүүлэх, хийх боломжтой ажлуудын талаар судалсан.



Дээрх хугацаанд Осакагийн Тажиричогийн номын сан, Вакаяма хотын төв номын сан, Кобэ их сургуулийн номын сан, Сайтама мужийн номын сан, Токио дахь Хибия номын сан соёлын ордон, Мүсашино паласын номын сан, Тоёо Бүнкогийн номын сангийн музей, “Osaka Gas” компани зэрэг нийт 7 номын сан 1 байгууллагын үйл ажиллагаатай танилцсан юм. Мөн Япон сангийн Кансай төвийн номын сангийн танилцуулга үйл ажиллагаа зохион байгуулахад туслах, номын сэдэвчилсэн үзэсгэлэнг хэрхэн хийх тухай зэргээр 3 удаагийн дадлага сургалт хийсэн болно. Судалгааны ажлынхаа дагуу мэргэжлийн япон хэлээ сайжруулангаа япон соёлтой танилцаж, Кообэ их сургуулийн магистрын ангийн оюутнуудтай ч Японд тулгамдаж буй сүүлийн үеийн асуудлын талаар санал бодлоо солилцож амжсан юм.



Зураг 41. Мүсашино палас Өсвөр насны хүүхдэд зориулсан сэдэвчилсэн ҮА номын булан

Бид уг сургалтаас хойш богино хугацаанд хийх боломжтой ажлуудаа биелүүлж эхэлсэн билээ. Одоогийн байдлаар япон анимэ, манга сонирхогч хүүхэд болон манга зураач болохоор сонирхон Япон оронд суралцахаар төлөвлөж буй залуустаа зориулан “Анимэгийн соёлыг танилцуулах өдөрлөг”, “Анимэ гар зургийн уралдаан”, Японы ЭСЯ-тай хамтран “Анимэ кино өдрүүд” болон Монголын Анимейшний холбооны ТББ-ийн гүйцэтгэх захирал Э.Тамирыг урьж нээлттэй семинараа “Японы анимейшний салбарын хөгжлийн түүх” сэдвээр тус тус амжилттай зохион байгууллаа. Цаашдаа ч бид өсвөр насны хүүхдүүдэд зориулан номын сангаа шинээр тохижуулах, ҮА номын тавиур, япон хэлний бяцхан номын булан зэргийг номын сандаа байрлуулахаар төлөвлөж байна.

Энэхүү сургалт нь японы талаар судалгаа хийж буй хэн бүхэнд нээлттэй учир судлаачид та бүхнийг өргөнөөр оролцож, өөрийн судалгаандаа хэрэгтэй мэдээллээ олж авахыг хүсье.



6) Анимэгийн соёлыг танилцуулах өдөрлөг

Япон анимэ, манга сонирхогч хүүхэд, залуустаа зориулан “Анимэгийн соёлыг танилцуулах өдөрлөг”-ийг 5 сарын 18-нд амжилттай зохион байгууллаа. Уг өдөрлөгийн хүрээнд "Анимэ гар зургийн уралдаан" зарласан ба уралдаанд хот хөдөө орон нутгийн нийт 100 гаруй хүүхэд залуучууд идэвхтэй хамрагдав. Мөн уралдаанд оролцсон хүүхдүүдээс шилдэг 10 байр шалгаруулж гарын бэлэг өгөв. Түүнчлэн нийт оролцсон бүх авьяаслаг хүүхдүүдийн бүтээлийг төвийн хүлээн авах танхимд үзэсгэлэн болгож 10 хоногийн турш нийтэд танилцуулсан юм.



Зураг 42. Анимэ гар зургийн үзэсгэлэн



Зураг 43. “Анимэгийн тухай quiz тэмцээн”

“Анимэгийн соёлыг танилцуулах өдөрлөг”-ийн зорилго нь Японд анимэ, манга хэрхэн үүсэж, хөгжсөн түүх соёлын тухай цэгцтэй зөв мэдээллийг хүүхэд залуучуудад хүргэх, мөн сонирхогч хүүхдүүдийг дэмжихээс гадна манай номын сан болон төвийн үйл ажиллагааг таниулж цаашид өөрсдийгөө хөгжүүлж хамрагдаасай хэмээн хүссэн болно. Тус өдөрлөг нь япон анимэтай холбоотой олон үйл ажиллагаа зохион байгуулснаараа онцлог байв. Үүнд цахим платформ ашигласан “Анимэ болон анимэ дууны quiz тэмцээн”, “Cafe de L0lita” кофе шоптой хамтран амттаны булан болон бүжгийн үзүүлбэр, япон тоглоомын булан зэрэг байв.

Мөн төвийн хашаан дахь үзэсгэлэнт сакура болон монос модны доор японы үндэсний хувцас болох юкатаг өмсөж найз нөхөд гэр бүлтэйгээ нэгэн өдрийг хөгжилтэй, дурсамжтай өнгөрүүлэнгээ анимэгийн түүх соёлын тухай ойлголттой болох боломжтой байснаараа сонирхолтой байсан хэмээн найдаж байна.



Зураг 44. “Maid бүжгийн үзүүлбэр”



V. ЕРӨНХИЙ УДИРДЛЫН ТАСАГ





I. 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ТАЙЛАН

Ерөнхий удирдлагын тасаг нь төвийн санхүү хөрөнгийн удирдлага, хүний нөөц, мэдээлэл технологи, аж ахуй, албан бичиг хөтлөлт, цэвэрлэгээ үйлчилгээ, харуул хамгаалалтын зохицуулалт гэсэн үндсэн ажлуудыг 2024 онд 91%-ийн гүйцэтгэлтэйгээр амжилттай зохион байгуулж ажиллалаа.

Бид дотоод нөөц бололцоогоороо төвийн барилга байгууламжийн засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж, төвийн ажилтнууд болон төвөөр үйлчлүүлэгчдийн аюулгүй, тайван орчинд ажиллаж үйлчлүүлэх боломжийг бүрдүүлэн ажиллалаа. Энэхүү ажлын бүтээмж өндөр гүйцэтгэлтэй гарсан нь төвийн хамт олны хичээл зүтгэл, хамтын ажиллагааны үр дүнтэй салшгүй холбоотой.

2024 онд гүйцэтгэсэн засварын болон бусад ажлууд

Ажлын агуулга	Ажил гүйцэтгэх хугацаа	Тайлбар
Сандал ширээ, урсгал засвар	Улиралд тутам	63 сандал, 26 ширээ зассан
Халуун усны тунгаагуур Ф150	2024 оны 6 сар	Гүйцэтгэсэн
Цэвэр усны бөмбөлөгөн хаалт	2024 оны 6 сар	Гүйцэтгэсэн
Дулааны тоолуурын баталгаажилт	2024 оны 6 сар	Гүйцэтгэсэн
Гадна харуулын дотор засал	2024 оны 1 сар	Гүйцэтгэсэн
Цахилгаан монтаж шинэчлэх	2024 оны 5, 9 сар	Хийгдээгүй
Хичээл болон албан хэрэгцээний худалдан авалт	Улирал тутам	Тухай бүртээ хийгддэг
Гражийн дээвэр засвар	2024 оны 7-9 сар	Хийгдээгүй
Гадаад оюутны дадлага	2024 оны 2 болон 4 сар	Кансэй гакуин их сургууль- 2 хүн Тоохокү бунка их сургууль- 4 хүн
Монгол улсын их сургуулийн оюутны дадлага	2024 оны 10, 11 сард	Ази судлалын тэнхим – 4 оюутан
Японд суралцах талаар зөвлөгөө	Жилийн турш	68 хүүхэд
Япончуудад зориулсан анхан шатны монгол хэлний сургалт	2024 оны 9-р сард	7 хүн хамрагдсан

Танхим ашиглуулсан байдал Хүснэгт-25. Байгууллагаар

№	Зохион байгуулагч	Үйл ажиллагааны тоо (удаа)
1	Япон Улсын Элчин Сайдын Яам	2
2	Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны байгууллага ЖАЙКА	12



3	Монгол Улсын Их Сургууль	11
4	Монголын Япон хэлний багш нарын холбоо	7
5	Бусад байгууллага	58
Нийт		90

Эх сурвалж: Монгол-Японы Төв, Ерөнхий удирдлагын тасаг

Сүүлийн 7-н жилийн гаднаас зохион байгуулсан үйл ажиллагааны тоо






График-3. Сүүлийн 3 жилийн гаднаас зохион байгуулсан үйл ажиллагааны чанарын үзүүлэлт





Дээрх ажлуудыг ЖАЙКА, Япон сан болон МУИС-ийн мэргэжилтнүүдийн мэргэжлийн удирдлага заавар, бүх талын дэмжлэгээр хийж гүйцэтгэсэн. Доорх үзүүлэлтээс харахад үйл ажиллагаа зохион байгуулсан тоо буурсан ч сургалтын болон , бусад үйл ажиллагааны оролцогчдын тоо улам нэмэгдэх хандлагатай байна.

График 10. Сүүлийн Сүүлийн 5 жилийн төвийн үйлчлүүлэгчийн тоо 2024 оны 12-р сарын 31 хүртэл нийт: 2,729,273 хүн (давхардсан тоо)





II. ОНЦЛОХ МЭДЭЭ

1. Баталгаат орчуулгын үйлчилгээгээ эхлүүлээ

Үйлчлүүлэгчдийнхээ бас нэгэн хэрэгцээ, шаардлагыг хангах үүднээс, мөн туршлагатай ажилтнуудынхаа мэдлэг чадварт тулгуурлан манай төвд байвал зохих нэгэн үйлчилгээг 2024 оноос албан ёсоор эхлүүлсэн нь баталгаат орчуулгын үйлчилгээ бөгөөд Монголын орчуулагчдын эвлэлээс авсан албан ёсны зөвшөөрөл авсан үйлчилгээ болно. Манай төвийн вэб сайтаас тус үйлчилгээний талаар мэдээлэл авах болон захиалгаа өгөх боломжтой.

2. Анхан шатны монгол хэлний сургалт

Монголд ажиллаж амьдарч буй япон хүмүүст зориулан монгол хэлний анхан шатны сургалтыг энэ онд анх удаагаа амжилттай зохион байгууллаа. Энэхүү сургалтаа цаашид тогтмол хэрэгжүүлээд явах зорилготой бөгөөд сургалтынхаа цар хүрээг өргөжүүлэн зөвхөн монголоор хязгаарлагдахгүй дэлхий даяарх монгол хэл, соёлыг сонирхогч хүмүүст зориулан онлайнаар сургалтаа явуулах төлөвлөгөөтэй байна.

Монголд ажиллаж, амьдарч буй япон хүмүүст хэл, соёлоо түгээх замаар тэдний ажил, амьдралд ч гэсэн тодорхой хэмжээгээр тус нэмэр болох чин хүслээр энэхүү сургалтаа явуулж байна. Манай сургалтыг сонирхсон хэн бүхэнд үүд хаалга маань нээлттэй байх болно.



Зураг 45. Анхан шатны Монгол хэлний сургалт амжилттай зохион байгууллаа

Зураг 46. Анхан шатны монгол хэлний сургалт төгсөгчиддөө сертификат олгов.





VI. БАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Lobby TV ашиглалт




Lobby TV – зэр төвийн сургалтын зараас гадна тухайн өдрийн үйл ажиллагааны танхимын хуваарийг харах боломжтой болсон.



Business section

2024 он
16-р дугаар



2024 ОНЫ БАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Монгол-Японы төвийн нийт ажилтнууд өөрийн хариуцсан ажлаас гадна төвийн нийт үйл ажиллагааны сайжруулалт болон ажилтан хоорондын харилцааг сайжруулах, өөрийгөө хөгжүүлэх зорилгоор хэд хэдэн багт хуваагдан ажиллаж байна. 2024 онд тасаг бүрийн ажилтны төлөөллөөс бүрдсэн “Маркетинг баг”, “5S Кайзэн баг”, “Эрүүл мэнд, спортын баг”, “Үйл ажиллагаа зохион байгуулах баг”, “Харилцан туслалцах баг” гэсэн 5 баг тус тусын үйл ажиллагааг амжилттай зохион байгууллаа.


Ингэснээр ажилтан хоорондын багийн ажиллагаа, уялдаа холбоо сайжрахаас гадна шинийг санаачлах, өөрийгөө шинээр нээх боломжтой болж байна.

1. МАРКЕТИНГИЙН БАГ

Тус баг нь Монгол-Японы төвийг олон нийтэд таниулахын зэрэгцээ төвөөс явуулж байгаа сургалт, үйл ажиллагаанд хамрагдах суралцагч, оролцогчдын тоог өсгөх, тогтоон барих зорилготойгоор 2016 онд анх тасаг бүрийн төлөөлөгч 4 гишүүнтэйгээр байгуулагдаж, 2024 байдлаар 6 гишүүнтэйгээр амжилттай үйл ажиллагаа явуулж байна.

2024 оны үйл ажиллагааны тойм:

№	Огноо	Үйл ажиллагаа	Тайлбар
1	2024.03	Төвийн арван зургаадугаар тайлан	Тухайн жилийн үйл ажиллагааг тайлан болгон гаргадаг бөгөөд 2024 оны 16 дахь удаагийн тайланг гаргалаа.
2	2024	Төвийн бүхий л үйл ажиллагааны постер танилцуулга	Тухайн жилийн төвийн бүхий л үйл ажиллагааны постер танилцуулга нийт 200+ баннер болон станд 20 гаруйг өөрсдийн дотоод нөөц бололцоонд тулгуурлан хийж гүйцэтгэжээ. Ингэснээр бид 4.000.000₮-н хэмнэлт хийж 7-н сая гаруй төгрөгийн орлого олж чаджээ.
3	2024	Сошиал маркетинг	Фейсбүүк дагагчийн тоо 15%-р өсөж 73000-д хүрсэн бол инстаграмм итвэхтэйгээр хөтлөн дагагчдын тоо 1500д хүргэлээ. 4200 гаруй чатад хариу мэдээлэл өгч, нүүр хуудас болон гүрүнд ирсэн 10 гаруй халдлагаас сэргийлж чадлаа.



4	2024	Багийн гишүүд	Багт шинээр орсон гишүүд багийн үйл ажиллагааг гүйцэд ойлгож чадалгүй гарах тохиолдол байсан тул багийн хуучин гишүүд зөвлөхөөр ажиллаж өөрсдийн хийсэн болон хийхээр төлөвлөсөн ажлыг амжилттайгаар үргэлжлүүлж чадлаа.
---	------	---------------	--

2. 5S КАЙЗЭН БАГ

Манай төв 2016 оноос эхлэн 5S Кайзэн хөдөлгөөнийг тасралтгүй хэвшил болгон хэрэгжүүлсээр ирсэн билээ. Ажилтнууд сайн дурын үндсэн дээр нэгэн баг болж бүрдсэн “5S кайзэн” баг нь төвийнхөө эмх, цэгц, ариун цэвэр, эрүүл ахуйн талаас эхлээд аливаа сайжруулах шаардлагатай асуудал юу байна вэ, тэр бүр дээр анхааран ажиллаж, ажилтнуудынхаа гаргасан санал санаачлагыг бүтээлчээр хэрэгжүүлэн явдаг онцлогтой болно.

5S кайзэн хөдөлгөөний гол зорилго нь үргүй зардал (үр ашиггүй үйлдэл, ажиллагаа)-г үгүй хийж, ашиг орлого, үр бүтээлч байдлыг нэмэгдүүлэх явдал байдаг тул 2024 оны “5S кайзэн” баг маань энэ тал дээр илүү бодит санаачлага гарган төлөвлөж, түүнийгээ амжилттай хэрэгжүүлж чадлаа. Тэр бол зарим актлагдсан эд зүйлсийг зарж борлуулах замаар багийнхаа тодорхой төсвийг бүрдүүлсэн явдал болно. Ийнхүү бүрдүүлсэн төсвөөрөө шилдэг кайзэн санал дэвшүүлсэн болон кайзэн саналуудын хэрэгжүүлэлтэд хамгийн ихээр гар бие оролцсон ажилтнуудаа тус тус шалгаруулж, урамшуулсан нь цааш цаашдын ажилтнуудын маань идэвх санаачлагыг дэмжихэд нөлөөлсөн болов уу.

ҮНЭЛГЭЭ

ЧИМЭЭГҮЙ КАЙЗЭНЧИН

ШАЛГУУР: БОДИТООР ХЭРЭГЖҮҮЛЭГЧ



Power automate, Sharepoint холбох гарын авлага
Кноск дээр апп хийсэн...

Зураг 47. Чимээгүй кайзэнчид

Энэ жилийн багийн үйл ажиллагааны онцлог гэвэл хамт олны уур амьсгалыг бүрдүүлэн, хамтдаа нэг зорилгоор ажиллахад анхаарсан “Workshop” ажиллагааг 3 удаа төлөвлөн хэрэгжүүлсэн нь маш үр дүнтэй болсон.

Зорилго :

“5S Кайзэн үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлж, бодит хэрэгжүүлэлтэд анхааръя”

Төлөвлөгөө:

1. “Кайзэн санал” аян “Чимээгүй кайзэнчид” шалгаруулах



2. Бүх нийтийг хамарсан “Workshop” уулзалт тогтмол хийх

3. Патрол ажиллагааг өргөн хүрээг хамран явуулах

Олж анзаарах боломжуудыг нэмэгдүүлэх зорилготой “Кайзэн патрол” үйл ажиллагааг зохион байгуулж, үр дүнд нь 27 санал гарч, төвийнхөө эмх цэгцтэй, цэвэр байдлыг ханган, дээшлүүлэв.

4. “Төсөв босгох” аян



Зураг 48. “Workshop”

Ажилтнуудаас гарсан саналын дагуу хэрэгжсэн бодит ажлууд:

- Үйлчлүүлэгчдийн санал хүсэлтийн хайрцагтай болов.
- Шүхэр түрээсийн булантай болов.
- Хойд үүдэндээ гутлын локертой болов.
- Хүлээлгийн танхимын зурагтаар танхимын мэдээллээ гаргадаг болов.
- Microsoft Office 365-г хэрхэн үр дүнтэй ашиглаж байгаа талаар зарим ажилтнууд туршлагаасаа хувцаалцаж, улмаар дата мэдээллүүдээ ч цэгцлэв.




Зураг 49. Хэрэгжүүлсэн бодит ажлууд

3. ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН БАГ

Зорилго:

Нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх замаар ажилчдын харилцаа холбоог сайжруулах, эрүүл амьдралын хэмнэлийг хэвшүүлэхэд оршино.

2024 онд хийгдсэн ажил:



No	Хэзээ	Үйл ажиллагааны нэр	Хаана	Бусад
1	1 сар-12 сар 8:55~	Өглөөний дасгал	Хүлээлгийн танхим	Тогтмол явуулах, ажлын байрны дасгал нэмэгдэн мягмар болон пүрэв гарагуудад хийж хэвшив
2	4 сар- 6 сар	Эрүүл мэндийн урьдчилсан үзлэг	БИОБЕЙС ЛАБОРАТОРИ, ХСҮТ	Бүх ажилтнуудаа хавдрын болон эрдсийн шинжилгээнд бүрэн хамруулав
3	3 сар, 11 сар	Эм болон бусад хэрэгтэй зүйлсийн худалдан авалт	-	Эмийн санд дууссан эмийг болон бусад хэрэгцээт зүйлсийг худалдан авч эмийн шинэчлэлт хийв.
4	4 сар,11 сар	Сургалт семинар	Их танхим, 205 тоот танхим	Өөртөө орц нэмье, Японы уламжлалт аарцаг нурууны бариа сэдэвт сургалтыг багш урин зохион байгуулав
5	1 сар	Багш ажилтны спортын их наадам	МУИС спорт заал	МУИС багш ажилтны спортын их наадамд амжилттай оролцож багийн дүнгээр хоёрдугаар байранд оров.